

Лиахона

**Маш олон
өсвөр үеийнхэн
ариун сүм явж
байна: Тэдэнд
бэлтгэхэд нь
тусална уу, х. 18**

**Номлолоо өөр өнцгөөс
харсан минь, х. 42**

**Бишоп наманчлахад тань
хэрхэн тусалж чадах вэ,
х. 58**

**Есүс хүн бүрийг,
тэр байтугай танхай
этгээдүүдийг ч хайрла
гэж хэлсэн, х. 68**





“Бид өнөөгийн
нөхцөл байдлаа-
саа болж, төөрч
алдагдсан мэт
мэдэрч болох
хэдий ч Бурхан
Өөрийн гэрлийн
найдварыг өгч,
Тэрээр бидний
өмнөх замыг
гэрэлтүүлж,
харанхуйгаас
гарах замыг
заахаар амладаг.”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрду-
гаар зөвлөх, Ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф, “Бурханы
гэрлийн найдвар,” *Лиакона*,
2013 оны 5-р сар, 80.



ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Авралын ажил дахь бидний үүрэг

Ерөнхийлөгч Томас С.Монсон

7 Айлчлагч багшийн захиас бичиг: Есүс Христийн бурханлаг үүрэг: Бүтээгч

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

12 Үүрэгт ажлаа сайн хий

Ахлагч Квинтин Л.Күк

Үнэн дүр төрхөө нуух нь хэзээ хэзээнээс илүү амар хялбар байх үед баг өмсөхгүй байж, “итгэлдээ үнэнч байх” чухал зарчмууд байдаг.

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Гэрэл зураг чимэглэлийг
Коди Бэлл Ар талд: Гэрэл зураг чимэглэлийг
Коди Бэлл Нүүрэн талын хавтасны дотор талд:
Гэрэл зураг чимэглэлийг iStockphoto/Thinkstock

18 Өсвөр насныхан ба ариун сүмийн гэрээнүүд

Гари Картэр ба Сюзан Картэр
Хүүхдүүдийг ариун сүмд ороход нь одооноос эхлэн бэлтгэх хэрэгтэй.

20 Бидний номлолын агуу өв

Ларэнэ Портэр Гаунт
ба Линда Дэккэр Лопез
Өнгөрсөн ба одоо үеийн бүх номлогчид хүмүүсийн амьдралыг илүү сайхан болгох итгэл найдвартайгаар үйлчилдэг.

26 Тулаанд бэлтгэсэн нь

Ахлагч Эдуардо Гаваррэт
Энгийн зарчмууд амьдралын тэмцэл дунд бидний хувь заяаг шийдэж чадна.

30 Их Эзэний ажлыг яаравчлуулах нь

Их Эзэний сүмийн гишүүд түүний ажилд бүрэн оролцохоор дуудагдсан юм.

34 Амар амгаланг тогтоогч болох нь

Маттью Д.Флиттон
Сайн мэдээ нэг хүний зүрх сэтгэлийг өөрчилснөөр гэр бүлийг нь нэгтгэжээ.

АЛБАД

8 Аравдугаар сарын чуулганы тэмдэглэл: Ерөнхий чуулганы санаанууд

Тина Спенсэр

9 Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлоос заах нь: Бие махбод ба сэтгэл санааны эрүүл мэнд

10 Сүмийн мэдээ

38 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой

80 Биднийг дахин уулзтал: Би хараалын үг хэлдэг болсон байв . . .

Р.Вал Жонсон

42



- 42 Би хэрхэн амжилттай номлогч болж чадах вэ?**
Лорэн Бангэртэр Вайлд



Энэ дугаарт
нуусан
Лиахонаг
олоорой.
Санамж:
Үр жимсийг
хуваалц.

- 46 Миний сайн мэдээг номло удирдамжийг дагадаг номлогч болох нь**

Ахлагч Дэвид А.Бэднар
Эдгээр таван шаардлага нь илүү сайн номлогч болоход тань туслах болно.

- 51 Зүгээр л инээмсэглээд үгүй гэж хэл**

Хэйзл Мэри Тайбул
Би компаний ерөнхийлөгчид яаж үгүй гэж хэлэх юм бэ?

- 52 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Хүч чадалтай, эрүүл чийрэг, ухаалаг бай**

Ахлагч Адриан Очоа
Бэлтгэлийнхээ хувцсыг өмсөөд, дасгал хийхэд бэлэн бол!

- 54 Түүний замыг дага**

Мэлиса Зэнтэно
Есүс Христтэй адилхан болох нь маш хэцүү юм шиг санагдаж болох ч уг үйл явц таны анхны алхмаар эхэлдэг.


- 56 Асуулт, хариултауд**

"Сүмийн зарим гишүүд яагаад та нарын жишгүүдээр амьдардаггүй юм бэ? гэж асуудаг гишүүн бус хүмүүст би юу гэж хэлэх вэ?"

- 58 Би яагаад гэм буруугаа бишоптоо хүлээх хэрэгтэй юм бэ? Үүний тулд би юу хийх хэрэгтэй вэ?**

Ахлагч С.Скотт Греү
Наманчлал бол Их Эзэн бид хоёрын хоорондын хувийн асуудал шүү дээ. Би яагаад бас бишоптоо ярих хэрэгтэй юм бэ?

52



61

- 61 Аврагчийг амьдралдаа урих нь**

Ахлагч О.Винсент Халэк
Аврагч таны амьдралд уригдахаар хүлээж байна!

- 62 Шинэхэн дикон**

Жэйн Макбрайд Чөүт
Бэнжи ариун ёслолыг яаж түгээнэ дээ хэмээн санаа нь зовж байлаа. Тэр үнэхээр үүнийг хийж чадах болов уу?

- 64 Бошиглогчийн мөрөөр: Винтэр Квортэрст хүлээсэн нь**
Жэннифэр Мадди

- 66 Гэгээнтнүүд Винтэр Квортэрст түр суурьшсан нь**
Ари Ван Де Графф

- 67 Онцгой гэрч: Есүс Христ бошиглогчидтой хэрхэн ярьдаг вэ?**
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон

- 68 Вайолитэд туслах нь**
Чарлотт Мэй Шэппард
Вайолит Эммад үргэлж таатай биш ханддаг байлаа. Эмма яагаад түүнтэй сайхан харцах ёстой юм бэ?

- 70 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Би Бурханы бүх хүүхдүүдтэй сайн мэдээг хуваалцана**

- 72 Нью-Йорк хотын Камилл**

- 74 Бидний хуудас**

- 76 Бага насны хүүхдүүдэд зориулав**

- 81 Бошиглогчийн хөрөг:**
Дэвид О.Маккэй

2013 ОНЫ АРАВДУГААР САРЫН ДУГААР 14 NO. 5 ЛИАХОНА 10790 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Бойд К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Крейг А.Кардон

Зөвлөхүүд: Шэйн М.Боуэн, Брэдли Д.Фостер,
Бага Кристоффел Гоулдэн, Энтони Д.Пэркинс

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр,
Ларин Портер Гаунт

Хэвлэлийн туслах: Мэлисса Зентено

Редакцийн баг: Сюзан Барретт, Давид Диксон,
Давид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Минди Рая Фриедман,
Лори Фуллер, Гарретт Х.Гарфф, Женифер Гейс Жөүнс,
Майкл Р.Моррис, Ричард М.Ромни, Пол ВанденБерг

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсен

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанетт Эндрюс,
Фэй П.Андрус, С.Кимбол Ботт, Томас Чаилд, Керри Линн
С.Херрин, Коллийн Хинкли, Эрик П.Хонсен, Скотт М.Моои,
Брэд Тиаре

Оюуны өмчийн зохицуулагч: Жэин Анн Петрс

Хэвлэлийн захирал: Жэин Анн Петерс

Хэвлэх баг: Кевин К.Банкс, Конни Бөүторп Бриж, Жүүли
Бурдетт, Браян У.Гиги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,
Гэил Тэйт Рафферти

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга төлөн үнийн
талаар орон нутгийн Сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернет вэбсайт

liahona.lds.org pyu; шуудангаар *Liahona*, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиана нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2013 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиана дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиалан олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

October 2013 Vol. 14 No. 5. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December) by
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is
\$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals
Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required
for change of address. Include address label from a recent issue;
old and new address must be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглах өгүүлэл, үйл ажиллагаанууд багтсан.
Доор хоёр жишээг өгөв.



ГЭРЛЭГ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КРЕЙГ ДАЙМОНД

**"Миний сайн мэдээг номло удир-
дамжийг дагадаг номлогч болох нь,"**

хуудас 46: *Миний сайн мэдээг номло*
удирдамжийг дагадаг номлогчдын таван
шинж чанарыг гэр бүлээрээ ярилцаад
эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэхийг хичээ.
Миний сайн мэдээг номло удирдамжийн
нэг хэсгийг хамтдаа нэгтгэн дүгнэсний
дараа, гэр бүлийн гишүүдийн заримыг
сонирхогчид болгож, зарим гишүүдээр
нь номлогчийн хичээлүүдээс богинохон
хугацаанд заах дадлага хийлгүүлж болно.
Та номлолын ажлын сорилт бэрхшээ-
лүүдийн тухай болон Ахлагч Дэвид А.
Бэднарын дүрсэлсэн зан чанаруудыг
хөгжүүлэх арга замуудын тухай ярилцан,
хуваалцаж болно.

"Хүч чадалтай, эрүүл чийрэг, ухаалаг

бай," хуудас 52: Ахлагч Адриан Очоа-
гийн өгүүллийг товчхон дүгнэсний дараа
гэр бүлийн гишүүдэд бие бялдраа хөгжүү-
лэхийн тулд бүгдээрээ хамт байх боломж
олгох үйл ажиллагааг төлөвлөхийг хичээ.
Та нар спортоор хичээллэж эсвэл явган
аялал хийж болно. Үйл ажиллагаагаа
гэр бүлийнхээ гишүүдийн нас, чадварт
тохируулахад анхаар (жишээ нь, та том
хүүхдүүдээсээ үйл ажиллагааг хийхэд
нь дүү нартаа туслахыг хүсч болно). Үйл
ажиллагааныхаа дараа бие бялдрын
идэвхтэй амьдралын хэв маягийн ашиг
тусын талаар гэр бүлээрээ ярилц. Та
түүнчлэн бие махбоддоо анхаарал тавих
талаар амьд бошиглогчдын зөвлөгөөг
дагахаар гэр бүлээрээ үргэлжлүүлэн
ажиллах арга замуудыг төлөвлөж болно.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиана болон сүмийн бусад материалуудыг www.languages.lds.org вэбсайт дээр
олон хэл дээр үзэх боломжтой.

ЭНЭХҮҮ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд өгүүллийн эхний хуудсыг заана.

Амар амгалан, 34

Анхдагчид, 64

Ариун Сүнс, 41, 46

Ариун сүм, 18, 34

Бишопууд, 58

Бошиглогчид, 67

Бүтээлт, 7

Бэлтгэл, 26

Бэрхшээл, 42, 64, 68

Гэмшил, гэм буруугаа

хүлээх, 58

Есүс Христ, 7, 76

Жишгүүд, 56, 80

Зорилгууд, 12, 54

Идэвхжүүлэлт, 4, 30, 38

Илчлэлт, 67

Маккэй, Дэвид О., 81

Миний сайн мэдээг

номло, 42, 46, 54

Мэргэн Ухааны Үг, 9,

51, 52

Наманчлал, 58

Номлолын ажил, 20, 30,

40, 42, 46, 61, 70, 72

Нөхөрлөл, 39, 40, 72

Санваар, 62, 76

Сүмийн түүх, 64, 66

Уруу таталт, 51, 80

Уучлал, 58, 68

Үлгэр дууриал, 12, 56

Үнэнч шударга байдал,

12, 51

Хараалын үг хэлэх, 80

Христийнхтэй адил

зан чанарууд, 54

Хэл, 80

Хүүхдүүд, 76

Шүүх нь, 56

Энэрэл, 4, 20, 34, 68

Эрүүл мэнд, 9, 52



Ерөнхийлөгч
Томас С.Монсон

Авралтын ажил

дахь бидний үүрэг

Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд сүмийн үйл ажиллагаанаас ямар нэг шалтгаанаар хөндийрсөн ах эгч нар аа, аврах хэрэгцээ нь мөнхийн чухал ач холбогдолтой зүйл юм. Сайн мэдээг нэгэнтээ бүрэн хүлээн авч, түүгээр амьдарч байсан ийм хүмүүсийн тухай бид мэддэг бил үү? Хэрэв мэддэг бол, тэднийг аврах ямар үүрэг бидэнд байдаг вэ?

Өндөр настай, бэлэвсэн болон өвчтэй хүмүүсийн дундаас алдагдсан тэдэнд илүү анхаарал тавь. Тэднээс маш олон нь ганцаардал хэмээх хуурай, эзгүй цөлд төөрч алдагдсан байдаг. Насных нь наран хэвийж, эрүүл мэнд нь доройтон, эрч хүч нь суларч, найдварын гэрэл нь хэзээ ч байгаагүйгээр бүүдийсэн үед тусламжийн гар, өрөвч энэрэнгүй зүрх сэтгэл тэднийг өргөн дэмжиж чадна.

Мэдээж хэрэг, аврах хэрэгтэй бусад хүмүүс байгаа. Зарим хүмүүс нүгэлтэй тэмцэлдэж байхад бусад нь айдас, идэвхгүй байдал, ойлголт төсөөлөлгүйгээс болж, төөрч будилж явна. Тэд ямар ч шалтгаантай байсан, сүмийн үйл ажиллагаанаас өөрсдийгөө холдуулан хөндийрүүлсэн байдаг. Хэрэв сүмийн идэвхтэй гишүүд бидэнд тэднийг аврах хүсэл төрөхгүй бол тэд алдагдсан хэвээр үлдэх нь бараг л тодорхой юм.

Зам заах хүн

Би нэлээд дээр үед сүмээс хөндийрсөн нэгэн хүнээс захидал хүлээн авч билээ. Энэ захидал маш олон гишүүдэд тохиолддог зүйлийн тухай өгүүлсэн байлаа. Тэр хэрхэн идэвхгүй болсон тухайгаа дүрслэн өгүүлсний дараа ингэж бичсэн байлаа:

“Надад их юм байсан, харин одоо өчүүхэн бага зүйлтэй үлджээ. Би аз жаргалгүй байгаа бөгөөд бүх зүйл буруугаар эргээд байгаа юм шиг санагдаж байна. Хэдийгээр би сайн мэдээний сургаалуудаар бүрэн амьдраагүй ч сайн мэдээний тухай гэрчлэл надад үргэлж байсан. Би та бүхнийг залбирахыг хүсч байна.

“Одоо энд байхгүй байгаа, төөрөлдсөн хожмын үеийн гэгээнтнүүд биднийг битгий мартаарай. Би сүм хаана байдгийг мэднэ, гэхдээ заримдаа надад зам заан, урам хайрлаж, айдсыг минь зайлуулан, гэрчлэлээ хэлж байх хэн нэгэн хэрэгтэй юм шиг санагддаг.”

Би энэ захидлыг уншиж байхдаа Английн Лондон дахь Виктори ба Альбертын Музей хэмээх дэлхийд алдартай уран зургийн үзэсгэлэнгүүдийн нэгийг үзсэнээ саналаа. Тэнд 1831 онд Жозеф Маллорд Виллиам Төрнэрийн зурсан, гоёмсог жаазтай урлагийн хосгүй гайхамшигт нэгэн уран зургийн бүтээл байдаг. Энэ зурагт тэнгэрийг харанхуйлах бараан үүлс, үхэл, аюулын харанга дэлдэн, хуйлран давалгаалах догшин далайг дүрсэлжээ. Их далайд ганцаархнаа үлдсэн нэгэн усан онгоцны гэрэл алс тэртээд сүүмэлзэнэ. Өмнө талд нь аврах том завь хөөсрөн давалгаалах усанд дээр дээр шидэгдэн усан онгоцны зүт тэмүүлэнэ. Аврах завь хуйлран хүрхрэх далайн давалгаа руу шумбан ороход эрчүүд хүчлэн сэлүүрдэж байв. Эрэг дээр нэгэн эхнэр хоёр хүүхэдтэйгээ бороонд шалба норж, шуурганд балбуулан зогсоно. Тэд сэтгэл түгшин, далай руу ширтэнэ. Би зургийг товчхоноор юу гэж нэрлэмээр юм бэ? гэж бодоод *Аврахаар* гэж нэрлэв.¹

Амьдралын хүнд сорилтуудын дунд аюул алхам тутамд тохиолдож болно. Эрэгтэй, эмэгтэйчүүд, хөвгүүд, охид ганцаардаж, аюул сүйрэлтэй тулгардаг. Хэн гэр орныхоо ая тух болон гэр бүлээ орхин аврах завийг удирдаж, хүмүүсийг аврахаар явж чадах вэ?

Бидний үүрэг давж даашгүй зүйл биш. Бид Их Эзэний зараалд байгаа болохоор Түүний тусламжийг авах эрхтэй билээ.

Их Эзэн үйлчлэлийнхээ үед Галилын загасчдыг тороо орхин Өөрийгөө дага гэж дуудахдаа “Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно” гэсэн билээ.² Бид чадлынхаа хэрээр тэдэнд тусалснаар эрэгтэй,



эмэгтэй загасчдын үүргээ биелүүлэх болтугай.

Бидний үүрэг бол тэднийг Түүний үтэн дээр найрлуулан, Түүний Сүнсний нөхөрлөлд баясаж болохын тулд Их Эзэний зоогийн ширээнд авчирч, “цаашид харь хүмүүс болон гадны хүмүүс биш, харин ариун хүмүүсийн адил Бурханы гэр бүлийнх” болоход нь туслахын тулд аюулгүй байдлаас холдож хөндийрсөн хүмүүсийг аврахын тулд тэдэнд хүрэх явдал юм.³

Хайрын зарчим

Сүмийн үйл ажиллагаанд эргэж ирэх болон зан төлөв, дадал зуршил, үйлдлүүдийг өөрчлөхөд ихээхэн хэмжээгээр нөлөөлдөг үндсэн хоёр шалтгааныг би олж мэдсэн юм. Нэгдүгээрт, хэн нэгэн мөнхийн боломжуудыг нь тэдэнд үзүүлж, тэдгээр боломжуудыг олж авахаар шийдэхэд нь тэдэнд тусалсан тэр хүмүүс эргэж ирдэг. Тэдгээр идэвх султай гишүүд нь олж авах боломжтой тэр төгс зүйлүүдийг нэгэнт мэдэрсэн бол одоогийн байгаа байдалдаа үргэлжлүүлэн сэтгэл хангалуун байж чадахгүй.

Хоёрдугаарт, зарим хүмүүс хайртай хүмүүс нь эсвэл “ариун хүмүүсийн адил нутгийн иргэд” нь Аврагчийн анхааруулга зөвлөгөөг дагаж, хөршүүдээ өөрийн адил хайрлан, бусдад мөрөөдлөө биелүүлж, зорилгоо ойлгоход нь тусалсан⁴ учраас сүмд эргэж ирдэг.

Энэхүү үйл явцын хөдөлгөгч хүч нь хайрын зарчим байсан бөгөөд үргэлж байх болно.

Төрнэрийн зурган дээрх далайн давалгаанд шидэгдэн, амь дүйн тэмцэлдэж байгаа хүмүүс үнэн хэрэгтээ, өөрт нь туслах хүмүүс ирж, аврахыг хүлээж буй манай идэвхгүй олон гишүүдтэй адил юм. Тэдний зүрх сэтгэл тусламж хүсч байна. Эцэг эхчүүд охид, хөвгүүдийнхээ төлөө залбирдаг. Эхнэрүүд нөхөртөө туслахын

тулд залбирдаг. Заримдаа хүүхдүүд эцэг эхийнхээ төлөө залбирдаг.

Бүрэн нөхөрлөлийн бидэнд санал болгох бүх зүйлүүдээс тэд хүртэж болохын тулд бидэнд идэвх султай гишүүдийг аварч мөн тэднийг Есүс Христийн сайн мэдээний баяр баясалд эргүүлэн авчрах хүсэлтэй байхын төлөө би залбирч байна.

Өндөр настай, бэлэвсэн, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй болон идэвх султай, мөн зарлигуудыг дагадаггүй бидний эргэн тойронд байгаа хүмүүсийг аварч болохын тулд бид тэдгээр хүмүүст хүрэх болтугай. Бид тэдэнд тусламжийн гараа сунгаж, өрөвч энэрэнгүй зүрх сэтгэлээр хандах болтугай. Ингэснээр бид тэдний зүрх сэтгэлд баяр баясгаланг авчирч, мөнх амьдралын замыг дагахад нь бусдад тусалснаар ирдэг агуу сэтгэл ханамжийг мэдрэх болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Дээрх уран зургийн нэр нь *Далайн шуургатай амь дүйн тэмцэлдэж, аюулын харанга дэлдсэн (Цэнхэр гэрлэн дохио өгсөн) усан онгоц руу хөдөлсөн аврах завь ба баг* юм.
2. Матай 4:19
3. Ефес 2:19
4. Матай 22:39-ийг үзнэ үү.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Та айлчилж очдог хүмүүсээсээ сүмд явахад хэцүү байгаа хэн нэгнийг мэддэг эсэхийг асуух талаар бод. Та нэг хүнийг сонгоод түүнийг гэр бүлийн үдэшт эсвэл хоолонд урих зэргээр түүнд хайраа үзүүлэх арга замуудын талаар ярилцаж болно.

Жэн бол Бурханы бэлэг

Хоси С.Килпак

Би ахлах сургуульд хоёр дахь жилдээ сурч байхдаа олон удаа буруу сонголт хийсэн. Буруу сонголтууд ноцтой үр дагаврууд болон аз жаргалгүй байдал руу хөтөлсөн учраас би өөрчлөлт гаргахын тулд зуны амралтаа ашиглахаар шийдэж билээ. Сургууль дахин эхлэхэд намайг хуучин замд буцаан оруулахаар хүлээж байсан муу нөлөөтэй найз нөхдөөс зайлсхийхийн тулд би үдийн хоолоо угаалгын өрөөний сандал дээр эсвэл хоосон танхимд иддэг болов.

Би ингэхдээ огт ганцаарддаггүй байв.

Тэгтэл Бурхан надад нэг бэлэг өглөө. Энэ бэлэг нь Жэнийг надад илгээсэн явдал юм. Жэн намайг алдаа гаргасны төлөө

хэзээ ч шүүдэггүй, харин намайг зөв гэдгийг нь мэддэг зүйлсээ хийхэд урамшуулан дэмждэг байв. Түүнийг сургууль дээр байгаа гэдгийг мэдэх нь надад судруудаа байнга уншиж, гэрчлэлээ хөгжүүлэхэд тусалдаг байв. Би сургууль төгсөх үедээ өөрчлөгдөнө гэж амласандаа хүрснээ өөртөө харуулсан юм.

Би заримдаа хэрэв Жэн надад туслаагүй бол би өнөөдөр хаана байх байсан бол гэж боддог. Би түүнгүйгээр зарчмуудынхаа дагуу үргэлжлүүлэн амьдарч чадах байсан болов уу? Аз болоход, тэр миний дэргэд байж, бүх зүрх сэтгэлээрээ надад туслахад ямагт бэлэн байсан бөгөөд ийнхүү туслах хүсэлтэй байсан учраас би дээрх асуултын хариуг хэзээ ч мэдээгүй юм.

Энэхүү өгүүмлийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Аврах арга замууд

Ерөнхийлөгч Томас С.Монсон, бид бусдад, түүний дотор өндөр настнууд, бэлэвсэн, өвчтэй, идэвх султай гишүүд болон нэмэлт тусламж хэрэгтэй

хүмүүст туслах ёстой гэж заасан билээ. Доорх зургуудыг хараад бусдад туслахын тулд өөрийнхөө хийж чадах зүйлүүдийг харуулсан зургуудыг дугуйл.



Доорх зайнд нь бусдад тусалж болох зарим арга замуудыг бич. Санаа авахын тулд зургуудыг ашигла.

Айлчилж очдог эгч нартайгаа юуг хуваалцвал зохихыг мэдэхийн тулд энэ материалыг залбирч судална уу. Аврагчийн амьдрал, үүрэг зорилгыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн дээшлүүлж, харж ханддаг хүмүүсийг тань хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг www.reliefsociety.lds.org вэбсайтаас үзнэ үү.

Есүс Христийн бурханлаг үүрэг: Бүтээгч

Энэ бол Аврагчийн үүрэг зорилгын тухай өгүүлсэн цуврал нийтлэлийн эхнийх нь юм.

Есүс Христ “тэнгэр ба газрыг бүтээсэн билээ” (3 Нифай 9:15). Тэр үүнийг Тэнгэрлэг Эцэгийн удирдлаган дор санваарын хүчээр хийсэн юм (Мосе 1:33-ыг үзнэ үү).

“Ерөнхийлөгч Томас С.Монсон “Мэргэн ухаант Бүтээгч дэлхийг зохион бүтээж, түүн дээр биднийг байрлуулан. . . Бурханаас бидэнд зориулан бэлтгэсэн бүхнийг хүлээн авахад бид тэнцэхээр байхын тулд өөрсдийгөө нотлон харуулах сорилтын хугацааг өгсөнд бид хэчнээн их талархалтай байх ёстой билээ” гэж хэлжээ.¹ Бид Бурханы зарлигуудыг дагаж, наманчлахын тулд сонгох эрхээ ашигласнаар Түүнтэй хамт амьдрахын тулд эргэж очихоор зохистой болж чадна.

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф Бүтээлтийн тухай өгүүлсэн нь:

“Тэрбээр ертөнцийг бидэнд зориулан бүтээсэн юм! . . .

“Энэ нь хүмүүний хувьд зөрчилдөөнтэй зүйл: Бурхантай



харьцуулахад хүмүүн юу ч биш; гэхдээ Бурханы хувьд бид маш чухал.² Бид Тэнгэрлэг Эцэгийн хувьд маш чухал учраас Есүс Христ дэлхийг бидэнд зориулан бүтээсэн гэдгийг мэдэх нь Тэднийг хайрлах хайраа нэмэгдүүлэхэд бидэнд тусалж чадна.

Судруудаас

Иохан 1:3; Еврей 1:1–2; Мозая 3:8; Мосе 1:30–33, 35–39; Абрахам 3:24–25

ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Амьдралын уралдаан,” *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 91.
2. Дийтр Ф.Угдорф, “Та нар Түүнд чухал,” *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 20.
3. Иосеф Фийлдинг Смит, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 171.
4. *Daughters in My Kingdom*, 171.
5. Иосеф Смит, *Daughters in My Kingdom*, 169.

Итгэл, Гэр бүл, Халамж



Бидний түүхээс

Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас (Мосе 2:26–27-г үзнэ үү) бурханлаг чадвартай юм. Бошиглогч Иосеф Смит Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарт “[өөрсдийнхөө] боломжинд тохирохоор амьдрахыг” зөвлөжээ.³ Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн эгч нарт энэхүү уриалгыг үндэс болгон өөрсдөд нь зориулсан Бурханы зорилгуудыг хэрэгжүүлснээр тэнгэрлэг чадамжиндаа хэрхэн тохирохоор амьдрахыг заадаг билээ. “Тэд өөрсдийгөө хэн бэ? гэдгийг, бусдыг хайрлан халамжлах заяамал чадвартай Бурханы охид гэдгээ жинхэнэ ёсоор ойлгосон үед ариун эмэгтэйчүүдийн чадавхидаа хүрч чадна.”⁴

“Эдүгээ та нар өөрсдийн тань дотор Бурханы байрлуулсан хайр энэрлийн дагуу үйлдэх нөхцөл байдалд байгаа билээ” хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлжээ. “Хэрэв та нар эдгээр зарчмуудын дагуу амьдарвал хэчнээн агуу, хэчнээн алдар суутай байх билээ! Та бүгд онцгой боломжиндоо тохирохоор амьдрах аваас тэнгэр элчүүд та нартай хамтран ажиллахаас татгалзаж чадахгүй.”⁵

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

1. Бид өөрсдийн бурханлаг мөн чанарыг ойлгохыг хичээх нь Аврагчийг хайрлах бидний хайрыг хэрхэн нэмэгдүүлдэг вэ?

2. Бид Бурханы бүтээлүүдийн төлөө талархлаа хэрхэн илэрхийлж болох вэ?

ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ САНААНУУД

Тина Спэнсэр



“Хэн оройн хоолонд ирэхийг таана уу?”

Манай гэр бүл ерөнхий чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө “Хэн оройн хоолонд ирэхийг таана уу?” гэсэн таавар эхэлснийг мэдэгдэж тэмдэг өлгөдөг. Тэгээд бид сүмийн сэтгүүлүүдийн өмнөх чуулганы дугааруудаас бошиглогчид, үзмэрчид болон илчлэгчдийн хамгийн сүүлийн үеийн зургуудыг нэмдэг.

Бид тэр үдэш оройн хоолонд морилох бошиглогчийн үгийг судалж бэлддэг. Заримдаа би олж мэдсэн цөөн хэдэн зүйлүүдээ төлөөлөөлүүлэн гэрээсээ хэдэн юм олж, тавганд хийдэг. Оройн хоолны үеэр намайг тэдгээр зүйлүүдийн талаарх түүхийг ярихад хүн бүр энэ хэн болохыг таахыг хичээдэг. Бусад үед би өмнөх ерөнхий чуулганы үеэр бошиглогчийн хуваалцсан нэг эсвэл хоёр түүхийг ярьдаг.

Бидний хайрт бошиглогч, төлөөлөгчдийн талаар манай хүүхдүүдийн санаж байгаа тэдгээр зүйлс миний гайхлыг төрүүлдэг. Энэ энгийн тоглоом нь эдгээр агуу хүмүүсийг хайрлах миний хайр болон тэдний талаарх миний мэдлэгийг нэмэгдүүлснийг би мэднэ.

Чуулган дээр хэлсэн үгсийн хуулбар

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл Л.Андэрсэн эхнэр Катигийнхаа хамт манай гадасны чуулганд оролцох үеэр Андэрсэн эгч нэгэн түүхийг бидэнтэй хуваалцсан юм. Тэднийг Францад амьдарч байх үед Андэрсэн эгч чуулган дээр хэлсэн үгсийн хуулбарыг бүх хүүхдүүдэд бүр бага насны хүүхдүүдэд хүртэл хийлгэсэн тухайгаа ярьж билээ. Хуулбарын үнэ маш өндөр байсныг мэдээд тэр мэл гайхсан

гэнэ. Тэгтэл “гэр бүл тань бошиглогчдын үгстэй байвал үнэ өртөг нь ямар хамаа байна?” гэсэн бодол санаанд нь зурсхийн орж иржээ.

Энэ түүх надад үнэхээр нөлөөлсөн учир би гэрийнхээ хүн бүрийн тоогоор чуулган дээр хэлсэн үгсийн хуулбарыг хийлгэсэн. Манай охид үнэхээр баярласан шүү. Бид чуулган дээр хэлсэн үгсийг гэр бүлийн үдшийн үеэр болон судар судлахдаа ашигладаг байв. Нэг охин маань чуулган дээр хэлсэн үгсийг уншин, онцгой чухал зүйлсийг тэмдэглэж байхыг харахад надад үнэхээр сайхан байлаа. Саяхан баптисм хүртсэн өөр нэг охин минь чуулган дээр хэлсэн үгсийг надтай хоёулхнаа хамт уншихыг гуйж билээ.

Чуулган дээр хэлсэн үгсээр даалгавар өгдөг байсан нь

Би Нийгмийн Халамжийн Бүлгийн хичээл дээр өмнөх чуулган дээр хэлсэн үгсийг товчлон дүгнэж ирэх даалгаврыг эгч бүрт өгдөг байсан. Зарим эгч нар үгсийг дахин уншдаг байсан бол, бусад нь тэдгээрийг онлайнаас үздэг байв. Хэдэн эгч дараагийн чуулганд илүү сайн бэлтгэгдсэнээ мэдэрсэн тухайгаа ярьсан. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Вашингтонд амьдардаг.

БИЕ МАХБОД БА СЭТГЭЛ САНААНЫ ЭРҮҮЛ МЭНД

Зарим өсвөр үеийнхний хувьд бие бялдраа чийрэгжүүлэх зарчмуудыг хэрэгжүүлдэггүй нь найз нөхөдтэй болох, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэхэд том саад тотгор болдог. Түүнээс гадна, бие махбод ба сэтгэл санааны эрүүл мэнд маш чухал боловч, номлолд үйлчлэхээр бэлтгэхийн тулд үүнийг дутуу анхаарч, дулимаг хөгжүүлдэг нь олонтоо тохиолддог. Энэ дугаарын 52–53-р хуудас дээр Далын Ахлагч Адриан Очоа бие махбоддоо анхаарал тавих нь биеийн болон сэтгэл санааны эрүүл мэндийг хэрхэн хамгаалдаг тухай өгүүлжээ. Бид эрүүл саруул, аз жаргалтай байхын тулд дасгал хийж, Мэргэн Ухааны Үгийг сахидаг байхыг тэр бидэнд сануулсан юм (С ба Г 89-ийг үзнэ үү). Бие махбод ба сэтгэл санааны эрүүл мэндийн зарчмуудад суралцаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд та хүүхдүүдээ тусалснаар тэд өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлж, ирээдүйн үйлчлэлд бэлтгэх чадвартай болно.

Ахлагч Очоа “Бие махбоддоо анхаарал тавих нь таны оюун ухааныг бас адисалж, Бурханы хүүхэд гэдгээ санаж, өөртөө итгэлтэй, аз жаргалтай байхад тань тусалдаг” хэмээн хэлсэн. Бидний сэтгэл санаа, бие махбодын болон сүнслэг талууд бүгд хоорондоо холбоотой байдаг.”

Өсвөр үеийнхэнд заах зөвлөмжүүд

- Ахлагч Очоагийн өгүүллийг хамтдаа уншиж, гэр бүлээрээ бие бялдраа чийрэгжүүлэх бодит төлөвлөгөө гаргаж хэрэгжүүл.
- Өсвөр насны хүүхдүүдтэйгээ хамт *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дээрх “Бие махбод ба сэтгэл санааны эрүүл мэнд” гэсэн хэсгийг унш. Сэтгэл санааны хувьд эрүүл байх гэдэг нь юу гэсэн утгатайг ярилц.
- “Though Deepening Trials” (Сорилтууд ихсэвч) (*Hymns*, no. 122) дууллыг хамтдаа дуулж, амилалт нь бидний бие махбодын чухал ач холбогдлын талаар юу заадгийг ярилц.
- Энэ өгүүлэлд жагсаасан судруудыг судалж, эдгээр нь бие махбод ба сэтгэл санааны эрүүл мэндийн тухай юу зааж байгааг ярилц.

Хүүхдүүдэд заах зөвлөмж

- Хүүхэддээ ариун сүмийн зургийг үзүүл. Төлөөлөгч Паул бидний бие бол “Ариун Сүнсний сүм” (1 Коринт 6:19) гэж заасан нь юу гэсэн утгатайг болон энэхүү мэдлэг бидэнд бие махбоддоо анхаарал тавихад



ХОЛБОГДОХ СУДРУУД

Сургаалт Үгс 16:32

Даниел 1:3–20

Лук 21:19

Ром 12:1–2

1 Коринт 6:19–20

1 Тесалоник 5:14

Алма 38:12; 53:20

Сургаал ба Гэрээ
88:15; 89

хэрхэн тусалж болох тухай ярилц.

- Гэр бүлээрээ амралт чөлөөт цагаа өнгөрүүлэхэд хүүхэд тань оролцож болох амралт, чөлөөт цагийн үр ашигтай үйл ажиллагаануудын жагсаалт хий. Тэгээд эдгээр үйл ажиллагаануудыг гэр бүлийнхээ амьдралын хэсэг хэрхэн болгох төлөвлөгөө гарга.
- Уур, уйтгар гунигийг ойлгож, зохицуулах арга замуудын тухай ярилц. “Хэрвээ сайхан амьдарч байвал” (*Children's Songbook*, 266), “Би Есүстэй адилхан байхыг хичээдэг” (*Children's Songbook*, 78), дуунуудыг эсвэл сэтгэл хөдлөл болон зөв сонголт хийх тухай өөр нэг дууг дуул. ■

СҮМИЙН МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org-аас үзнэ үү.

Гишүүд Санваарын эрх мэдлийн шугамын мэдээлэл авах хүсэлт илгээж болно

Раин Моргэнэг

Сүмийн мэдээ

Сүм одоо гишүүдэд үзүүлэх үйлчлэл болгон санваарын эрх мэдлийн шугамын мэдээллийг хүсэлтийнх нь дагуу өгөх боломжтой боллоо. Санваарын эрх мэдлийн шугам нь сүмийн эхэн үе, бүр Аврагчийн томилсон хүнээс эхлэн таны санваараа авсан томилолт хүртэлх дараалал юм.

Далын албатай санваартан нь гишүүний эрх мэдлийн хувийн шугамд орж болох ч Далын албанд зориулсан тусдаа эрх мэдлийн шугам гэж байхгүй. Түүнчлэн бишоп, патриархын албанд томилогдсон ах нарын санваарын эрх мэдлийн шугамыг тэдний дээд пристийн томилолтоор дамжуулан тооцно.

Зөвхөн Мелкизедек санваарын эрх мэдлийн шугамын талаарх мэдээллийг сүмд хүсэлт гарган авч болно. Харин Аароны санваарын шугам боломжгүй. Гишүүд зөвхөн өөрсдийнхөө, хамт амьдардаг хүүхэд эсвэл одоогоор номлолд үйлчилж байгаа залуу номлогчийн Мелкизедек санваарын шугамын мэдээллийг хүссэн хүсэлт гаргаж болно. Эдгээр баримт нь сүмийн албан ёсны бүртгэл биш юм.

Та өөрийн санваарын эрх мэдлийн шугамын мэдээллийг авахыг хүсвэл хүсэлтэндээ өөрийн албан ёсны овог нэр, төрсөн огноо, гишүүнчлэлийн бүртгэлийн дугаар (ариун сүмийн зөвшөөрлийн бичиг дээрээс эсвэл тойргийнхоо бичиг хэргийн ажилтнаас авч болно), өөрийг тань ахлагч эсвэл дээд пристэд томилсон хүний нэр, таны буцах хаяг ба утасны дугаар эсвэл э-мэйл хаягийг багтаасан байна.

Хүсэлтээ дараах хаягаар илгээнэ үү:

Priesthood Line of Authority

Global Service Center

120 North 200 West

Salt Lake City, Utah 84103-1514, USA

Факс: 1-801-240-6816

Утас: 1-800-453-3860, дотуур утасны

дугаар 2-3500

Э-мэйл: Э-мэйлийг lineofauthority@ldschurch.org руу сэдэв гэсэн хэсэг дээр “PLA”-тэй хамт илгээ. Хариуд нь та нар бөглөөд, буцааж илгээх шаардлагатай маягт хүлээн авах болно (сэдвийн хэсэгтээ “PLA” агуулсан аливаа зурваст автоматаар хариу очдог). ■



Ёслолуудыг гүйцэтгэж байгаа хүмүүсийн санваарын эрх мэдлийн шугамыг Аврагч хүртэл харж болно.



Монгол дахь сүмийн 20 жилийн ойд зориулсан үйл ажиллагааны үеэр дэвүүрт бүжигчид “20” гэсэн тоог үзүүлэн харуулжээ.

Монголд сүм байгуулагдсаны 20 жилийн ойг тэмдэглэжээ

2013 оны 4-р сарын 15-ны даваа гарагт Монгол улсад Сүм байгуулагдсаны 20 жилийн ойн байрыг тэмдэглэхээр 300 гаруй сүмийн гишүүн Улаанбаатар хотын Зайсан толгойд цугларчээ. Гишүүд 1993 онд Монгол оронд сайн мэдээ түгээхээр онцгойлон адисалсан Нийл А.Максвеллийн адислалыг бичсэн бичлэгийг сонсож (1926–2004) мөн 50 гишүүнтэй найрал дуучид дуу дуулав.

1993 онд Ахлагч Максвеллтэй хамт Монголд ирсэн Азийн бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн асан Ахлагч Тай Квок Еэн хэрхэн “Талбайн энэ хэсэгт Их Эзэний гар зогсолтгүйгээр хөдөлж байсныг” анзаарч харжээ.

Уг долоо хоногийн турш ойн баярт зориулсан олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагджээ. 200 эргэж ирсэн номлогч номлолын цугларалтад оролцсан байна. Монголын бараг 10 гишүүн тутмын нэг нь буюу 1000 гаруй гишүүн бүрэн цагийн номлогчоор үйлчилжээ. Баасан гарагийн үдэш Монгол орон даяар баптисмын цуглаан болж нийт 24 хүн баптисм хүртсэн байна. Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс саяхан чөлөөлөгдсөн Мэри Н.Күк эгч Залуу Эмэгтэйчүүдийн галын дэргэдэх ярилцлага дээр үг хэлсэн. Мөн гэр бүлийн түүхийн нээлттэй хаалганы

өдөрлөгөөр Гэр бүлийн мод (Family Tree) шинэ төслийн зааврыг танилцуулсан видео бичлэгийг үзүүлжээ. Урлаг соёлын үйл ажиллагаа нь Монголын баялаг түүх болон Сүмийн олон гишүүдийн авьяас билгийг багтаан харуулсан байна.

Гайти дахь хожмын үеийн гэгээнтнүүд ойн баярыг тэмдэглэв

2013 оны 5-р сарын 1-нд Гайтийн сүмийн гишүүд орон даяар зохиогдсон Help Plant Trees мод тарих том хэмжээний төсөлд оролцжээ. Төслийн эхний өдөр болон дараа дараагийн өдрүүдэд олон тооны зулзаган модыг суулгав. Төсөл дуусах үед нимбэг, жүрж, далдуу, папая, царс зэрэг 400000 гаруй шинэ мод Гайтид ургах болно.

Гайтид болсон газар хөдлөлтөөс сэргээн босгох үйл ажиллагааг дэмжихэд зориулж Сүм тэрхүү моднуудыг худалдан авсан байна. Уг төсөл нь энэ арлын орон дахь сүмийн 30 жилийн ойг тохиолдуулан сүмийн гишүүдэд үйлчлэх боломжийг олгожээ. Гучин жилийн өмнө тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан Ерөнхийлөгч Томас С.Монсон Гайтид зочилж, сэргээгдсэн сайн мэдээг номлохын төлөө уг газар нутгийг онцгойлон адисалсан юм.

Арванхоёр Чуулгын Ахлагч Нийл А.Андэрсэн ойн баярын үеэр Гайтид

байж энэ улсад сүмийн эхлэлийг тавьсан түүхэн дурсгалын пайзыг олонд таниулах үйл ажиллагааг тэргүүлжээ.

Feeding America-д сүмээс 453592 кг хоол хүнсийг хандивлажээ

2013 оны 5-р сард Сүм хожмын үеийн гэгээнтнүүдийн энэрлийн үйл ажиллагааны хүрээнд хүмүүнлэгийн ажлаар Feeding America буюу Америкийн Нэгдсэн Улс дахь өлсгөлөнтэй тэмцэх ашгийн бус хамгийн том байгууллагад 400000 кг гаруй хоол хүнс хандивлажээ. Уг хандив нь лаазалсан жимс, ногоо, шош зэргээс бүрдэж байсан ба энэ нь янз бүрийн олон нийтийн хүнсний агуулах болон түр хоргодох байруудаар дамжуулан Америкийн Нэгдсэн Улс дахь гачигдалтай гэр бүлүүдэд тараагдсан байна.

Feeding America-ийн ерөнхийлөгч, гүйцэтгэх ерөнхий захирал Боб Айкен хэлэхдээ уг хандив нь ойролцоогоор 625000 хоолоор хангана гэжээ. ■

Гайтийн гишүүд болон номлогчид арын хэсэгт харагдаж буй Гайтийн нийслэл хот Port au Prince-гийн өндөр ууланд мод тарив.



ЖЭЙСОН СВИНСЕНИЙ ЗУРАГ




Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч
Квинтин Л.Күк

Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) Шотландад номлогчоор үйлчилж байхад нь тохиолдсон нэг түүхийг олон удаа ярьсан байдаг. Тэр номлолд ирснээсээ хойш удалгүй гэрээ санаж, ойролцоох түүхийн дурсгалт газар Шерлинг Цайзыг үзэж, хэдэн цагийг тэнд өнгөрүүлдэг байжээ. Тэр хамтрагчтайгаа түүхэн дурсгалт цайзыг үзээд буцаж явахдаа, “Чи хэн ч байлаа гэсэн, үүрэгт ажлаа сайн хий” хэмээн Шекспирийн хэлсэн бололтой эдгээр үгсийг чулуун дээр сийлэн хаалган дээрээ хадсан байшингийн дэргэдүүр өнгөрдөг байв.

Ерөнхийлөгч Маккэй энэ үйл явдлыг эргэн санаж, “Би өөртөө эсвэл доторх Сүнсэндээ, “Чи бол Есүс Христийн



ҮҮРЭГТ
АЖЛАА
САЙН
ХИЙ

*Зөв шударга бай. Гэр бүлээ төлөв-
шүүл. Гэр бүлээ тэтгэх тохиромж-
той арга замыг ол. Дуудлагатаа
үйлчил. Бурхантай уулзахаар
бэлтгэ.*



АХЛАГЧ КВИНТИН Л. КУХИЙН ГЭРЭЛ ЗҮРГИЙГ КРЭГ ДАЙМОНД, ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СКОТТ ДЭЙВИС

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн. Түүгээр ч барахгүй, чи бол энд Их Эзэн Есүс Христийн төлөөлөгч шүү дээ. Чи Сүмийн төлөөлөгч байх үүрэг хариуцлагыг хүлээн авсан хүн” хэмээн өөртөө хэлсэн гэж билээ. Тэгээд би тэр өдрийн үдээс өмнө хийсэн зүйлийнхээ [тухай] бодлоо. Бид хоёр түүхийн дурсгалт газар үзэж, түүхэн заавар, мэдээлэл олж авсан, үүнд миний сэтгэл их догдолсон. . . . Гэвч энэ чинь номлолын ажил биш шүү дээ. . . . Би нөгөөх чулуун дээрх надад хандсан захиасыг хүлээн авлаа. Тэгээд бид тэр үеэс хойш Шотланд дахь номлогчдын хувьд үүрэгт ажлаа сайн хийхийг хичээдэг болсон.”¹

Энэхүү маш чухал захиас түүнд асар их нөлөө үзүүлсэн бөгөөд Ерөнхийлөгч Маккэй үүнийг амьдралынхаа үлдсэн хугацаанд сүнслэг удирдамж болгон ашигласан ажээ. Тэр ямар ч үүрэг хүлээлээ гэсэн чадах бүхнээ хамгийн сайнаар хийж байхаар шийджээ.

Үнэн дүр төрхөө нуухаас зайлсхий

Сүмийн залуу үеийнхэн та нарт байгаа сайныг үйлдэх агуу чадварыг харахад та нарын ирээдүйн төлөө миний санаа зовдог зүйл юу байх билээ? Би та нарт ямар зөвлөгөө өгч болох вэ? Нэгдүгээрт, та нар үнэн дүр төрхөө нууж баг өмсөн өөрөө хэн билээ гэдгээсээ мөн ямар хүн болохыг хүсдэгээсээ огт өөр хүн болж харагдах хүчтэй дарамт шахалттай учрах болно.

Сүмийн түүхийн эхэн үед Бошиглогч Иосеф, Эмма хоёр 11 настай ихрүүд Жозеф, Жюлия нартайгаа хамт Огайогийн Хайрамд Жон Жонсон, Алис Жонсон нарын гэрт байжээ. Хоёр хүүхэд нь хоёул улаан бурхнаар өвчилсөн байв. Иосеф бяцхан хүүтэйгээ хамт үүдний ойролцоо дугуйтай намхан орон дээр унтаж байв.

Нүүрээ хараар будсан хэсэг хүмүүс шөнө хаалгаар дайран орж ирээд Бошиглогчийг чирж гарган, зодож, түүний болон Сидней Ригдонгийн биенд давирхай түрхжээ.

Танхайрагчдын энэхүү дайралтын хамгийн эмгэнэлтэй үр дагавар нь аавыг нь гадаа чирж гаргах үеэр бяцхан Жозефыг шөнө хүйтэн агаарт гадаа гаргаснаас тэр хүнд хатгаа авсан явдал юм. Үүний балгаар бяцхан хөвгүүн хэдхэн хоногийн дараа энджээ.²

Бошиглогч, түүний ах Хайрум хоёрын амийг хөнөөхөд оролцсон хүмүүс бас үнэн дүр төрхөө нуухын тулд нүүрээ хараар будсан байлаа.³

Хүн үнэн дүр төрхөө нуух нь хэзээ хэзээнээс илүү амар хялбар болсон өнөө үед баг өмсөхгүй байж, “итгэлдээ үнэнч байх” нь чухал зарчмууд юм. Амь



Ахлагч Л.Том Пэрри Японд байхдаа үүргээ сайн биелүүлсэн ажээ.

насаараа хохирогчид итгэлдээ үнэнч байсан учраас егүүтгэгдсэн юм.⁴

Биднийг буруу сонголт хийхээс хамгаалдаг агуу хамгаалалтуудын нэг нь үнэн дүр төрхөө нуух аливаа баг өмсөхгүй байх явдал мөн. Хэрэв танд үнэн дүр төрхөө нуумаар санагдвал, энэ нь аюулын ноцтой дохио, хийх ёсгүй зүйлийг танаар хийлгэх гэсэн Сатаны арга хэрэгсэлүүдийн нэг гэдгийг мэдэгтүн.

Үзэн ядалт, хорсол, муйхар санаагаар дүүрэн, нэргүй нийтлэлүүдийг хүмүүс өнөө үед онлайн тавьж байгаа нь тэд үнэн дүр төрхөө нуудгийн нийтлэг жишээ мөн. Зарим хүмүүс үүнийг *шатаалт* гэдэг.

Төлөөлөгч Паул бичсэн нь:

“Бүү мэхлэгд. Муу нөхөр сайн хэвшлүүдийг эвддэг.

“Та нар ямар байх ёстой шиг эрүүл ухаантай бай.

Нүгэл үйлдэхээ боль. Учир нь заримд нь Бурханы тухай мэдлэг байхгүй байна” (1 Коринт 15:33–34).

Чөтгөрийн харилцаа нь зөвхөн муу зан чанар биш гэдэг нь тодорхой юм. Хэрэв хожмын үеийн гэгээнтнүүд хичээвэл, Бурханы тухай мэдлэггүй эсвэл Аврагчийн тухай гэрчлэлгүй хүмүүст тэд сайнаар нөлөөлж чадна.

Хүний нэр төрийг гутаан доромжлох, хэн нэгнийг муу хүн гэж бусдад ойлгуулахын тулд интернетийг аливаа хэлбэрээр ашиглах нь хүлээн зөвшөөрч болшгүй үйлдэл юм. Хүмүүс үнэн дүр төрхөө нууж баг өмссөнөөрөө ийм төрлийн үйлдэлд оролцох илүү их магадлалтай байдаг. Энэ нь ойлголт мэдлэгээ нэмэгдүүлэх зорилгоор буурь суурьтай ярилцах боломжийг үгүй болгодог. Энэ нь бас Аврагчийн заадаг үндсэн зарчмуудад харш юм.

Аврагч Өөрийгөө дэлхийг яллахын тулд бус харин түүнийг аврахын тулд ирсэн гэдгийг тайлбарласан билээ. Тэгээд Тэрбээр яллах гэдэг нь юу гэсэн утгатайг ийн дүрслэн тайлбарлажээ:

“Тэрхүү ялалт ийм билээ. Гэрэл ертөнцөд ирэхэд хүмүүсийн үйлс бузар муу учир тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм.

“Учир нь өөрийнх нь үйлс ил гарчих вий гэж бузрыг үйлдэгч хүн бүр гэрлийг үзэн ядаж, гэрэл рүү гарч ирдэггүй.

“Харин үйлс нь Бурханы дотор үйлдэгдсэн гэдгийг ил харуулахын тулд үнэнийг үйлдэгчид гэрэл рүү ирдэг гэлээ” (Иохан 3:19–21; мөн шүлэг 17–18-ыг үзнэ үү).


Зөв шударга хүмүүс үнэн дүр төрхөө нуухын тулд баг өмсөх шаардлагагүй юм.

Үнэн итгэлийнхээ дагуу үйлд

Та өөрийн зан чанарыг хөгжүүлж, Христтэй илүү адилхан болоход туслах зүйлсийг хийхэд цаг заваа зориулснаар үнэн итгэлийнхээ дагуу үйлдэх болно. Та нарын хэн нь ч өөрийн амьдралыг “Бурхантай уулзахаар бэлтгэх” (Алма 34:32) цаг гэхээсээ илүү зугаа цэнгэл, тоглоом наадмын үе гэж үздэггүй гэдэгт би найдаж байна.

Үүрэгт ажлаа биелүүлэх болон цагийг үр бүтээлтэй ашиглахын гайхамшигт жишээг бид Дэлхийн II Дайны төгсгөлөөр Япон дахь АНУ-ын эзэмшлийн зэвсэгт хүчинд тэнгисийн цэрэг байсан Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Л.Том Пэрригийн амьдралаас харж болно. Ахлагч Пэрри дараах түүхийг Аврагчийн тухай онцгой гэрчлэлээ бичихдээ хуваалцжээ.

“Дэлхийн II Дайн төгсөж, энх тайвны гэрээнд гарын үсэг зурсны дараа Японы эрэгт очсон анхны усан



*Буруу сонголт хий-
хээс таныг хам-
гаалдаг найдвартай
хамгаалалтуудын нэг
нь үнэн санаа бодлоо
нуусан баг өмсөхгүй
байх явдал мөн.*

цэргүүдийн нэг нь би байлаа. Миний амьдралд тохиосон хамгийн гунигтай үйл явдлын нэг нь сүйрч балгас болсон Нагасаки хотод очсон явдал байв. Хотын ихэнх хэсэг бүрэн устаж сүйрсэн байлаа. Зарим цогцсуудыг оршуулж ч амжаагүй байв. Хотод эзэмшлийн цэрэг орж ирсний дараа бид штабаа байгуулаад ажилдаа орсон билээ.

“Нөхцөл байдал үнэхээр хүнд байсан бөгөөд биднээс цөөхөн нь илүү ихийг өгөхийг хүсч байсан юм. Бид хариуцсан санваартан руугаа очиж, Христийн сүмүүдийг сэргээн босгоход туслах эрхийг бидэнд олгохыг хүссэн юм. Дайны үеийн засгийн газрын хязгаарлалтын улмаас эдгээр сүмүүд үйл ажиллагаагаа бараг зогсоосон байв. Бид юу ч үгүй болтлоо эвдэрч сүйрсэн барилга байгууламжийг засан, Христийн шашны ёслолуудыг дахин хийх боломжтой болгохын төлөө сайн дурын бүлэг байгуулж, чөлөөт цагаараа цуглааны байруудыг засварлаж, сэргээн будахаар боллоо.

“... Бид дайны турш үйлчлэх боломжгүй байсан сүмийн удирдагчдыг олж, тэднийг сүмдээ буцаж ирэхийг уриалсан юм. Тэдгээр хүмүүс Христэд итгэх итгэлээ дахин эрх чөлөөтэйгөөр үргэлжлүүлж чадсан бөгөөд энэ нь бидний хувьд агуу үйл явдал болсон юм.

“Бид Нагасаки хотоос гэртээ харих боллоо. Би үүнийг хэзээ ч мартахгүй. Гэртээ харих галт тэргэнд суух үеэр биднийг тэнгисийн бусад явган цэргүүд шоолж байлаа. Тэдэнд баяртай гэж хэлэх найз охид нь хажууд нь байлаа. Тэд биднийг Японд байхын баяр цэнгэлийг амссангүй хэмээн шоолж байв. Тэд биднийг зөвхөн ажил хийж, хана шавардан цагийг дэмий өнгөрөөсөн гэж боддог байлаа.

“Яг энэ мөчид галт тэрэгний буудлын ойролцоох довыг даван Христийн шашинтан 200 гаруй япон хүн ‘Урагшаа, Христийн цэргүүд ээ’ дууг дуулан ирж, бидэнд баахан бэлэг өгсөн юм. Тэд төмөр замын дагуу эгнэн зогсож, галт тэрэг хөдлөх үед бид гараа сунган салах ёс гүйцэтгэж билээ. Бидний сэтгэл бүр ярьж ч чадахааргүй болтлоо их хөдөлж байв. Учир нь бид дайны дараа тэр улсад Христийн сүмийг сэргээхэд өчүүхэн ч болов хувь нэмэр оруулсандаа туйлын баяртай байсан билээ.⁵

Цаг заваа хэрхэн ашиглах сонголтоо тунгаан бодож, санаачилгатай бай. Би та нарыг сүсэг бишрэлийнхээ тухай хүн бүхэнд зарлаад бай, эсвэл гаднах байдлаараа итгэлтэй хүний дүр эсгэж бай хэмээн хэлээгүйг та нар Ахлагч Пэрригийн жишээнээс харж болно. Ийм байвал танд өөрт тань бас сүмд ичгүүртэй хэрэг болно. Та нар ямар хүмүүс болох ёстой билээ, тийм л хүмүүс болох талаар би ярьж байна.

Тохирох зорилго тавь

Миний гурав дахь зөвлөгөө та нарын анхаарлаа төвлөрүүлбэл зохих зорилгуудын талаар юм. Ахлагч Пэррийг Японд тэнгисийн цэргийн хүчинд алба хашиж байхтай ойролцоо нэгэн үед Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Байд К.Пакэр Дэлхийн II Дайны төгсгөлөөр Японд агаарын цэргийн хүчинд алба хааж байжээ.

Би 2004 онд Ерөнхийлөгч Пакэр болон бусад хүмүүсийг дагалдан Японд очсон юм. Тэрбээр өөрийн зарим алхмуудыг эргэн харж, тэр үед гаргасан шийдвэрүүд болон зарим туршлагаа тунгаан бодсон юм. Би түүний



Ерөнхийлөгч Байд К.Пакэр зөв зорилгууд тавьж ажиллах чадваргаар адислагджээ.

зөвшөөрснөөр зарим бодол санааг нь хуваалцъя.

Ерөнхийлөгч Пакэр Окинавагийн эргээс хол орших нэгэн арал дээр болсон үйл явдлын тухай өгүүлсэн юм. Тэр энэ арлыг цөл дэх өөрийн уул гэж үзсэн ажээ. Түүний хувийн бэлтгэл болон бусад гишүүдтэй уулзсан нь сайн мэдээний сургаалуудад итгэх итгэлийг нь гүнзгийрүүлсэн байна. Гэвч түүнд нэг л зүйл дутагдаад байлаа. Энэ нь үнэн гэдгийг нь аль хэдийн мэдэрсэн зүйлийнх нь баталгаа баттай мэдлэг байв.

Ерөнхийлөгч Пакэрын намтрыг бичигч энэ тухай өгүүлэхдээ: “Өөрийн эрж хайсан амар амгалангийн баталгааны оронд тэрбээр гэм зэмгүй хүмүүсийн эсрэг тамын дайныг биеэр туулсан юм. Тэрээр ганцаараа байж тунгаан бодохоор нэг өдөр далайн арал дээрх өндөр толгой дээр гарчээ. Тэр тэнд нэгэн цагт сайхан байшин байсан бололтой эвдэрхий

байшингийн үлдэгдэл, түүний ойролцоо хаягдсан амтат төмсний талбайг харлаа. Тэр бас хатсан төмснүүдийн дунд хоёр хүүхэдтэйгээ хамт алагдсан нэгэн эхийн хүүр байхыг харжээ. Харсан зүйл нь түүнийг гүн уй гашууд автуулсны зэрэгцээ өөрийн гэр бүлийг бас бусад бүх гэр бүлийг хайрлах мэдрэмж түүнд төрсөн ажээ.”⁶

Тэр дараа нь түр хугацааны хоргодох байранд орж, бясалган, тунгаан бодож, залбирчээ. Ерөнхийлөгч Пакэр энэ үйл явдлыг эргэн санаж, сүнсний баталгаа хэмээн миний нэрлэсэн зүйлийг дүрсэлсэн юм. Амьдралдаа өөрийн хийх ёстой зүйлсэд тэрээр сүнсээр нөлөөлөгдсөнөө мэдэрсэн ажээ. Тэрээр одоо үйлчилж байгаа ариун, дээд дуудлагатаа дуудагдана гэж огт төсөөлж байгаагүй нь мэдээж юм. Түүний зорилго нь Аврагчийн сургаалд онцгой ач холбогдол өгөн, багш болох байсан ажээ. Тэр зөв шударгаар амьдрах болно гэсэн шийдвэр гаргав.

Энэхүү шийдвэр нь тэрээр зөв зохистой эхнэр авч, өнөр өтгөн гэр бүлээ хамтдаа өсгөн хүмүүжүүлэх болно гэсэн тод томруун байдлаар түүнд ирсэн ажээ. Энэ залуу цэрэг сонгосон ажил нь боломжийн нэмэгдэл, хангамжтай байна гэдгийг мөн хайрт хань нь зарим нэг материаллаг юмгүй амьдрах хүсэлтэй байж өөртэй нь адил эрхэмлэх зүйлстэй байх хэрэгтэй гэдгийг ухаарч ойлгожээ. Донна Пакэр эгч Ерөнхийлөгч Пакэрт төгс хань нь байсан, одоо ч байгаа билээ. Тэд хэзээ ч багтаж ядсан их мөнгөтэй байгаагүй ч өөрсдийгөө ядуу зүдүү гэж боддоггүй байлаа. Тэд 10 хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд их золиослол хийсэн ажээ. Одоо тэд 60 ач зээ, 80 гаруй ачинцар, зээнцэртэй болоод байна.

Бидний зорилго дэлхийн эрхэмлэдэг зүйлс дээр олонтоо үндэслэгддэг учраас би энэхүү үнэн түүхийг хуваалцлаа. Авралын ёслолуудыг хүлээн авсан гишүүдийн хувьд нэн чухал элементүүд нь нэлээд энгийн юм. Зөв шударга бай. Гэр бүлээ төлөвшүүл. Гэр бүлээ тэтгэх тохиромжтой арга замыг ол. Дуудлагатаа үйлчил. Бурхантай уулзахаар бэлтгэ.

Аврагч сургахдаа, “элбэг хангалуун нэгний амь өөрийнх нь өмч хөрөнгөнөөс хамаардаггүй юм” (Лук 12:15) гэжээ.

Улс орон ба нийгмээ цогцлон байгуул

Хувийн харьцаа хандлага, зан байдал, гаргадаг шийдвэрүүдээс гадна, хэрэв та нар ямар үеийнхэн байх ёстой, тийм л байх юм бол, та нар амьдардаг улс орноо, нийгмээ цогцлон байгуулах болно. Та нарын үеийнхэн шударга ёсыг болон шашин шүтэх эрх чөлөөг хамгаалах хэрэгтэй. Бидний өвлөсөн Иудей-Христийн шашны өв бол Тэнгэр дэх бидний Эцэгийн төлөвлөгөөнд зөвхөн үнэ цэнэтэй



Бидний өвлөсөн Иудей-Христийн шашны өв бол Тэнгэр дэх бидний Эцэгийн төлөвлөгөөнд зөвхөн үнэ цэнэтэй төдийгүй амин чухал юм. Бид энэхүү өвийг ирээдүйн үеийнхэнд зориулж хамгаалах хэрэгтэй.

төдийгүй амин чухал юм. Бид энэхүү өвийг ирээдүйн үеийнхэнд зориулж хамгаалах хэрэгтэй. Бид сайн хүмүүстэй, түүний дотор бүх шашны хүмүүстэй ялангуяа биеэ авч яваа байдлаараа Бурханы өмнө хариуцлагаа ухамсарладаг сайн хүмүүстэй нэгдэн нийлэх хэрэгтэй. Эдгээр нь “Чи хэн ч байлаа гэсэн, үүрэгт ажлаа сайн хийж бай” гэсэн зөвлөгөөг ойлгодог хүмүүс юм. Иудей-Христийн шашинтны үнэт зүйлс ба шашин шүтэх эрх чөлөөг амжилттайгаар өргөжүүлэн хөгжүүлэх нь танай үеийнхнийг ямар хүмүүс байх ёстой вэ тийм л агуу үеийнхэн болгоно.

Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн чуулга өнөөдөр дэлхийд бий болсон сорилт бэрхшээлүүдтэй холбогдуулан, та бүхэн амьдарч байгаа улс орныхоо улс төрийн үйл явцад хэрхэн зохих ёсоор оролцох тухайд онцгой санаа тавьдаг билээ. Сүм улс төрийн тэмцэлд төвийг сахидаг бөгөөд намууд болон тэдний нэр дэвшигчдийг дэмждэггүй. Гэвч манай гишүүд сайн засгийн газрыг хамгаалах зарчим дээр үндэслэн, өөрсдийн сонгосон улс төрийн нам болон түүний нэр дэвшигчдийг дэмжихэд бүрэн оролцохыг бид хүсэн хүлээдэг билээ. Энэ талаарх бидний сургаал тодорхой юм: Сайн бөгөөд “үнэнч шударга . . . мөн ухаалаг хүмүүс хичээнгүйлэн эрэлхийлэгддэг байх ёстой” (С ба Г 98:10).

Бид та нарт маш их итгэдэг. Өмнөх үеийнхний байгуулаагүй хаант улсыг та нар байгуулж чадна гэдэгт Сүмийн удирдлага бат итгэлтэй байдаг билээ. Бид та нарыг хайрладаг, та нарт итгэдэг төдийгүй бас та нарын төлөө залбирч, та нарыг адисалдаг билээ. Та нарын үеийнхний амжилт Сүмийг цаашид төлөвшүүлэх болон хаант улсын өсөлт хөгжилтөд туйлын чухал гэдгийг бид мэднэ. Бид та бүхнийг баг өмсөхөөс зайлсхийснээр үүрэгт ажлаа сайн хийж, үнэн дүр төрхийнхөө дагуу үйлдэн, зөв зорилгууд дэвшүүлж, улс орноо болон нийгмээ цогцлон байгуулахын төлөө үргэлж залбирдаг. ■

2012 оны гуравдугаар сарын 4-нд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургууль дээр болсон Сүмийн Боловсролын Системийн галын дэргэдэх цугларалт дээр залуучуудад хандан хэлсэн үгээс. Хэлсэн үгийг англи хэлээр бүрнээр нь уншихыг хүсвэл www.lds.org/fundamental-premises-of-our-faith хаягаар орно уу lds.org/broadcasts/archive/ces-devotionals/2012/01?lang=eng.

ЭШЛЭЛҮҮД

1. Дэвид О.Маккэй, Францис М.Гиббонс, Дэвид О. Маккэй: *Бурханы бошиглогч, дэлхийн төлөөлөгч* (1986), 45.
2. Марк А.Стэйкэр, “Remembering Hiram, Ohio,” *Ensign*, 2002 оны 10-р сар, 32, 35-ыг үзнэ үү.
3. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 24-ийг үзнэ үү.
4. “Итгэлдээ үнэнч байх нь,” *Hymns*, no. 254.
5. А.Том Пэрри, “Joy—for Us and Others—Comes by Following the Savior,” <http://lds.org/prophets-and-apostles/what-are-prophets-testimonies?lang=eng>.
6. Люсил К.Тэйт, Бонд К.Пакэр: *A Watchman on the Tower* (1995), 58–59.

Гари Картэр ба Сюзан Картэр

Ариун сүмийн ажилтнуудын хувьд бид хувийн хишгээ хүлээн авахаар ариун сүмд ирж байгаа залуу насанд хүрэгчидтэй ажиллахаар адислагдсан билээ. Ариун сүмийн бэлтгэлийн семинар нь тэдэнд тустай байсан ч зөв шударга эцэг эх ба удирдагчдын нөлөө ариун сүмийн гэрээнүүдийг хийхээр тэднийг бэлдэхэд нь туслахад илүү чухал үүрэг гүйцэтгэлийг бид олж мэдсэн билээ. Эцэг эх, удирдагчдын хувьд бид өсвөр үеийнхэнд зөвхөн хэдэн сар үргэлжилдэг бүрэн цагийн номлолын үйлчлэлд бэлтгэхэд нь туслаад зогсохгүй, үүрд мөнхөд үргэлжилдэг ариун сүмийн гэрээнүүд хийж сахихад нь бас тэдэнд туслах хэрэгтэй байна. Анхны алхмуудыг тэдний бага наснаас нь эхлэх хэрэгтэй.

Хүүхдүүдийг бэлтгэх нь

Эцэг эхчүүд өөрсдөө ариун сүмд очин, шүтэн биширч, ариун сүмийн ажлын тухай гэрчлэлээ хуваалцснаар ариун сүмийн ач холбогдлыг хүүхдүүдэд харуулж чадна. Ариун сүмд олон удаа орох боломжгүй газруудад ч гэсэн эцэг эхчүүд хүүхдүүдэд ариун сүмд орох хүслийг бий болгон төлөвшүүлж чадна.

Ерөнхийлөгч Ховард В.Хантэр (1907–95) эцэг эхчүүдэд заахдаа: “Ариун сүмд мэдэрдэг сүнслэг мэдрэмжүүдээ хүүхдүүдтэйгээ хуваалцдаг байцгаая. Их Эзений өргөөний зорилгын тухай баяр талархалтайгаар хэлдэг зүйлсээ хүүхдүүдэд чин сэтгэлээсээ илүү ая тухтай орчинд заадаг байцгаая” гэсэн байдаг.¹ Ариун сүм бол бидний залбирлынхаа хариултуудыг авч, Бурханы хайрыг мэдэрдэг газар гэдгийг бидний хүүхдүүд мэддэг байх хэрэгтэй.

ӨСВӨР НАСНЫХАН БА АРИУН СҮМИЙН ГЭРЭЭНҮҮД

*Бүрэн цагийн номлогчдын
насанд тавигддаг шаардлагыг
доошлуулснаар эдүгээ хэдэн
арван мянган өсвөр насныхан
ариун сүмийн гэрээнүүдийг
хийж байна.*

Эцэг эх нь хүүхдүүдэд тэд 12 нас хүрэх үедээ хязгаартай ашиглах ариун сүмийн эрхийн бичгээ хүлээн авахын тулд тэсэн ядан хүлээдэг байхыг мөн үүнийг хүлээн авахуйц зохистой амьдрах ёстойг зааж чадна. Эдгээр өсвөр үеийнхэн ариун сүмд орох цаг нь болоход зөвшөөрлийн бичгээ баяр хөөр, бахархалтайгаар ариун сүмд үзүүлдгийг бид ажигласан.

Өсвөр үеийнхнийг бэлтгэх нь


Хүүхдүүд нь 12 нас хүрэх үедээ гэр бүлийнхээ нэрсийг ариун сүмд авчирч болохын тулд гэр бүлийн түүхээ судлах ажилд оролцоход тэдэнд тусалж болно. Арванхоёр

Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар гэр бүлийн түүхийн ажилд оролцдог өсвөр үеийнхэнд “Өвөг дээдсээ хайрлах та нарын хайр, талархал өсөн нэмэгдэх болно. Та нарын гэрчлэл болон Аврагчид хөрвөх хөрвөлт тань гүн гүнзгий, бат бөх болно. Та нар улам өргөжин тэлж байгаа Сатаны нөлөөнөөс хамгаалагдах болно гэдгийг би та нарт амлаж байна” гэжээ.²

Бид энэхүү амлалт биелэгдэж байгаагийн олон жишээг харж байна. Саяхан нэг залуу эмэгтэй эмэг эхийнхээ нэрийг уйгагүй хайсны дараа түүний төлөө ёслолуудыг хийлгэхээр ариун сүм явсан тухайгаа бидэнд ярьсан. Тэр эмээгийнхээ өмнөөс баптисм хийлгэх үед, дараагийн амьдралдаа түүнтэй уулзах болно гэсэн тод томруун мэдрэмж түүнд төрсөн гэж ярилаа. Иймэрхүү үйл явдлууд нь өсвөр үеийнхний гэрчлэлийг хүчирхэгжүүлж, ариун сүмийн ёслолуудад цаашид оролцох хүслийг тэдэнд бий болгоно.

Эцэг эх, удирдагчид нь үзэмж сайтай, даруухан хувцас өмсдөг байвал, өсвөр үеийнхэн ч бас тэднийг дуурайх





болно. Өсвөр үеийнхэн ямархуу байдлаар хувцасладаг нь, мөн бие махбоддоо хэрхэн анхаарал тавьдаг нь тэд ямархуу шавь нар вэ? гэдгийг харуулдаг. Өсвөр үеийнхэн, өөрсдийнх нь хувцаслаж байгаа байдал болон бие махбоддоо хэрхэн хандаж байгаа нь тэднийг ямархуу шавь болохыг харуулж байгааг ойлгох хэрэгтэй.

Эцэг эх нь ариун сүмд хийх гэрээнүүдийг ойлгоход нь өсвөр үеийнхэнд тусалснаар тэднийг ариун сүмд орохоор бэлтгэхэд нь тусалж чадна. “Ариун журам ба ариун явдлын хуулийг чанд сахин, энэрэнгүй, ач буянтай, хүлцэнгүй тэвчээртэй, цэвэр ариун байж, ур чадвар, материал баялаг хоёуланг нь үнэнийг дэлгэрүүлж, [хүмүүний гэр бүлийг] дэмжихэд зориулах, үнэний зарчмын төлөө тууштай ажиллахаа үргэлжлүүлэх, газар дэлхий өөрийн Хаан, Их Эзэн Есүс Христийг хүлээн авахад бэлэн болох агуу бэлтгэлд бүх талаар хувь нэмрээ оруулахыг эрэлхийлэх” амлалтууд ариун сүмийн гэрээнүүдэд байдаг билээ.”³ Эцэг эх нь өсвөр үеийнхэнд эдгээр гэрээнүүдийг дагаснаар тэд амьдралынхаа турш хувийн болон хүчирхэг адислалуудыг хүлээн авах болно гэдгийг гэрчилж чадна. Мөн эцэг эх нь тэдэнд эдгээр адислал ба гэрээнүүд аль аль нь Есүс Христийн Цагаатгалын ачаар бидэнд боломжтой болсныг ойлгоход тэдэнд тусалбал, эдгээр гэрээнүүд өсвөр үеийнхний хувьд илүү утга учиртай байх болно гэдгийг гэрчилж болно.

Ариун сүмийн адислалуудыг хүлээн авахаар бэлдэхэд нь хүүхдүүдэд болон өсвөр үеийнхэнд тусалж болох олон арга замууд байдаг. Тэд хэдий чинээ их бэлтгэлтэй байна, төдий чинээ амар амгалан байж, Сүнсний мэдрэн, хувийн хишгээ хүлээн авах үед сүнслэг агуу мэдрэмжийг мэдрэх болно. Сэтгэл санааг өргөсөн ариун сүмийн мэдрэмж нь тэднийг Христийн тууштай шавь нар, заадаг хүмүүстээ ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахаар бэлтгэхэд нь туслах хүслээр өдөөгдсөн илүү сайн номлогчид болгоно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Ховард В.Хантэр, “Follow the Son of God,” *Ensign*, 1994 оны 11-р сар, 88.
2. Дэвид А.Бэднар, “Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд уруугаа эргэх болно,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 28–31.
3. Жэймс Э.Талмэйж, *Preparing to Enter the Holy Temple* (2002), 34–35.

БИДНИЙ НОМЛОЛЫН АГУУ ӨВ

*Өнгөрсөн ба одоо үеийн бүх номлогчид,
бусад хүмүүсийн амьдралыг илүү сайхан
болгох итгэл найдвартайгаар үйлчилдэг.*

**Ларэнэ Портэр Гаунт
ба Линда Дэккэр Лопэз**

Сүмийн сэтгүүлчид

Өнөөгийн номлогчид дэлхийг Их Эзэний тухай мэдлэгээр дүүргэхэд агуу өвийг залгамжлан авч, хэрэгжүүлж байна (Исаиа 11:9-ийг үзнэ үү). Абрахамаас Паул, Паулаас Аммон, Аммоноос Вилфорд Вудрафф хүртэлх судрууд болон сүмийн түүхэн дэх номлогчид өнөө үеийн номлогчдыг үүрэг хариуцлагын хүч нөлөө ихтэй загвараар хангаж байна.

Бид гишүүн номлогчид байна уу, бүрэн цагийн номлолын үйлчлэлд бэлтгэж байна уу, номлолд үйлчилж байна уу эсвэл номлолоос буцаж ирсэн үү, ялгаагүй эдгээр үлгэр жишээнүүдээс зориг болоод сүнслэг нөлөөг хүлээн авч чадна.

Библи болон Агуу Үнэт Сувд дахь бидний номлолын өв

Иона гэх мэт Хуучин Гэрээний номлогчид хүмүүст сэрэмжлүүлгийн дуу хоолойг хүргэхээр дуудагддаг байлаа (Езекиел 3:17–19-ийг үзнэ үү). Бид Ионагийн үлгэр жишээнээс наманчлал ба дуулгавартай байдлын ач холбогдлыг хардаг. Абрахамын түүх бидэнд Мелкизедек санваарын уг гарал ба хүчний тухай заадаг.

Петр, Паул гэх мэт Шинэ Гэрээний номлогчид Есүс Христийн сургаалуудыг хамгаалахын төлөө ажиллаж байлаа. Гэсэн хэдий ч, цаг хугацаа улиран өнгөрөхөд дэлхийг урвалт нөмөрсөн юм. Бурхан сайн мэдээг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн билээ. Бид эдүгээ дээрх номлогчдын нэгэн адил Есүс Христийн сургаалуудыг хамгаалан, хуваалцахаар ажиллаж байна.



Иона Ниневегийн наран шарлагын газарт, Даниэл А.Люис. Иона наманчилж, Иехова бүх газарт хаанчилдаг бөгөөд Өөрийн хайрыг ганицхан үндэстэн эсвэл нэг л хүмүүст үзүүлдэггүй тухай номлон, баталж явалаа (Иона 1–4-ийг үзнэ үү).

СЭРЭМЖЛҮҮЛГИЙН ДУУ ХООЛОЙ

“Их Эзэн нигүүлсэнгүй учраас хүмүүсийг аюулаас сэрэмжлүүлэхийн тулд үйлчлэгчдийг дууддаг. . . . Ионагийн тухай бодоод үз л дээ. Нүгэл үйлдсээр байгаад аюулыг харж чадахгүй харалган болсон Ниневегийн хүмүүсийг сэрэмжлүүлэх Их Эзэний дуудлагаас тэрээр эхлээд зугтаасан шүү дээ. Ёс бус хүмүүс зуун зууны туршид бошиглогчдыг эсэргүүцэж, заримдаа тэднийг алж байсныг Иона мэдэж байлаа. Гэвч Ионаг итгэлээр жигүүрлэн урагш давшихад Их Эзэн аюулгүй байдал, амжилт ололтоор түүнийг адисалсан билээ.”

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Хэнри Б.Айринг, “Сэрэмжлүүлгийн дуу хоолойгоо өргөцгөөе,” *Лиахона*, 2009 оны 1-р сар, 3.





Петр Иохан хоёр Иерусалим дахь удирдагчдын өмнө, Симон Вэддэр. Петр, Иохан хоёрыг зөвлөлийн өмнө авчрахад ахлах тахилч тэдэнд, “Энэ нэрээр дахин сургаал заахгүй байхыг бид та нарт хатуу тушаасан. Гэтэл та нар Иерусалимыг сургаалаараа булж орхилоо. . . . Тэгэхэд нь Петр . . . Бид хүнийг дагахаасаа илүү Бурханыг дагах ёстой” (Үйлс 5:28–29) гэж хариулжээ.

Төлөөлөгч Паул, Карэл Скрэта. Паул өөрийн аяллуудын үеэр болон захидлууддаа Аврагчийн тухай хүчтэй гэрчлэлийг Бага Ази болон тэр үед хүмүүсийн мэддэг байсан дэлхийн ихээхэн хэсэгт хэлж явлаа.



BPK, BERLIN / GEMÄLDEGALERIE ALTE MEISTER, STAATLICHE KUNSTSAMMLUNGEN, DRES / EIKE ESTEL / HANS-PETER KLUT / ART RESOURCE, NY



Мелкизедек Абрамыг [Абрахамыг] адисалсан нь, Волтэр Рэйн. Мелкизедек Абрамыг адисалсан нь (Эхлэл 14:18–20-ийг үзнэ үү) (С ба Г 84:14-ийг үзнэ үү). Их Эзэн өөр нэг удаа Абрам дээр хүрч ирэн хэлсэн нь, “Чиний дараах чиний үр удамд . . . харь нутагт чамайг миний нэрийг гэрчлэх тохинуулагч болгохоор би зорьж байгаа болно. . . . Чибээр өөрийнхөө дараах үр удамдаа тэд өөрсдийн гарт энэ тохинуулал хийгээд санваарыг бүх үндэстнүүдэд гэрчлэх адислал байх болно” (Абрахам 2:6, 9).



© ГАРИ Л.КАПП, ХУУЛБАРЛАЖ БОЛОХҮҮИ



ҮЛ ИТГЭГЧДЭД ЗААХ НЬ

“Мозаягийн хөвгүүд . . . леменчүүдийн дунд очсон юм. Эдгээр итгэлтэй номлогчид ёс заншил нь сүнслэг байдлын өсөлт хөгжилтөд хүргэхгүй хүмүүст заасан ч гэсэн, эдгээр леменчүүдэд хүчтэй өөрчлөлт гарахад нь тусалсан билээ. . . . ‘Тэдний номлолд итгэн мөн Их Эзэнд хөрвүүлэгдсэн леменчүүд . . . хэзээ ч итгэл алдраагүйг’ (Алма 23:6) бид мэднэ.

Далын Ахлагч Жэймс Б.Мартино, “Хөрвөлтийг авчирдаг наманчлал,” *Ensign*, 2012 оны 9-р сар, 58.

Аммон Лемонай Хааны өмнө, *Гари Л.Калп*. Мозаягийн хөвгүүдийн нэг Аммон Хаан Лемонай сүргийг хамгаалсан билээ. Хаан Аммоноос тэр Бурханаас илгээгдсэн үү гэж асуухад Аммон өөрийгөө “тэд шударга бөгөөд үнэн болох тэрхүү мэдлэгт авчрагдаж болохын тулд [Лемонай] хүмүүст” (Алма 18:34) сайн мэдээг заахаар Ариун Сүнсээр дуудагдсан хүн гэж хариулсан ажээ.

Мормоны Номон дахь бидний номлолын өв

Алма, Амюлек, Мозаягийн хөвгүүд болон лемен хүн Самуел нар бол Мормоны Номоос бидний олж болох агуу номлогчдын загвараас зөвхөн хуруу дарам цөөхөн нь юм. Бид тэднээс наманчлал, итгэл, дуулгавартай байдал ба эрэлхэг зоригийн үлгэр жишээг олж хардаг. Бид тэдний нэгэн адил манай номлолын үйлчлэлийг удирдахад Бурханаас ирдэг сүнслэг удирдамж болон илчлэлтэд итгэн найдаж болно.

Тэр миний бодгальд баярт мэдээг авчирсан, *Волтэр Рэйн*. Нэгэн тэнгэр элч лемен хүн Самуел дээр айлчлан ирж, Аврагчийн ирэлтийн талаар “баярт мэдээг [Самуелын] бодгальд” (Хиламан 13:6–7) авчирсан ажээ. Самуел нифайчуудад номлох дуудлагынхаа хэсэг болгон Зарахемла хотын хэрмэн дээр гарч, тэдгээр баярт мэдээг хүмүүстэй хуваалцжээ.



Сургаал ба Гэрээн дэх бидний номлолын өв

Сайн мэдээний Сэргээлтийн дараа номлогчид маш чухал хэрэгтэй болов. Дан Жөүнс, Оорсон Хайд, Парли П.Пратт зэрэг номлогчид Мормоны Ном болон Есүс Христийн сайн мэдээг хуваалцдаг байлаа. Бошиглогч Иосефын дүү Самуел зэрэг зарим хүмүүс гэртээ ойрхон үйлчилж байлаа. Бусад хүмүүс Тайланд, Сандвич Арлууд (Хавай), Дани, Англи зэрэг холын орнуудад сайн

мэдээг хуваалцахаар явж байв.

Эдгээр анхны номлогчид ихэвчлэн олон өөр номлолд урт хугацаагаар үйлчилдэг байв. Тэд яг өнөөгийн бидэн шиг эцэг эх, хайртай нэгнээ, эхнэр, хүүхдүүд, ач зээ нараа орхин явдаг байлаа. Тэд өнөөдөр бидэнд итгэл, эрэлхэг зориг, дуулгавартай байдал, тэвчээр, хичээл зүтгэлийн үлгэр жишээ болж байна.



Мормон номлогчид, Арнольд Фрайбэрг, Кристэн Далсгаардын эх зураг дээр үндэслэн бүтээжээ. Есүс Христийн сайн мэдээг хөдөөгийн гэртээ цугласан Данийн нэгэн гэр бүлд зааж байгаа эхэн үеийн хожмын үеийн гэгээнтэн номлогчийн дүр зураг бол 19-р зууны номлолын ажлын нийтлэг хэв шинж юм. Номлогчид бас гудамжны булангуудад эсвээс хотын цуглааны танхимуудад заадаг байлаа.



Вилфорд Вудрафф Бэнбөү ферм дээр болох баптисмуудад бэлтгэсэн нь, Ричард А.Муррэй. Их Эзэн Вилфорд Вудраффыг 1840-өөд оны үед Английн Хэрэфордшир дэх Жон Бэнбөүгийн ферм рүү удирдсан юм. "Тэнд хүмүүс юмсын талаар эртний дэг жаягаар залбирдаг байсан юм" гэж Вилфорд бичжээ. "Үр дүнд нь би тэнд очсоноос хойш эхний 30 өдөрт 600 хүнд баптисм хүртээсэн . . . Тэр улсад 8 сар үйлчлэхдээ би 1800 хүнийг Сүмд авчирсан. Яагаад? Яагаад гэвэл тэнд Сайн мэдээг сонсоход бэлтгэгдсэн хүмүүс байсан юм" ("Discourse," Deseret Weekly, 1896 оны 11-р сарын 7, 643).

Бүр 1851 оны
орчим шинээр
ирсэн номлогчид
Сандвич Арлуу-
дын (Хавай)
уугуул оршин
суугчдад бап-
тисм хүртээ-
жээ. Энэ гэрэл
зургийг 1851
оноос нэлээд
хожуу авсан
байна.



ХУУЛГАРЛАЖ БОЛОХГҮЙ

Бидний номлолын өв дээр барих нь

Ерөнхийлөгч Томас С.Монсон 2012 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн номлолд үйлчлэх на-сыг наашлуулсан тухай зарласнаас хойш хэдэн арван мянган хожмын үеийн гэгээнтэн номло-лын талбарт ирээд байна.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн 2013 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр номлолын ажлын тухай гэрчлэлээ хэлж, сайн мэдээг сонсоход бэлэн байгаа хүмүүсийг олоход туслах замаар энэхүү гайхамшгийн чухал хэсэг болоход бидний хүн

нэг бүрийг уриалсан билээ: “Их Эзэн илүү олон номлогчдыг номлолд үйлчлэхэд нь сүнсээр нө-лөөлөхийн хажуугаар Түүний номлогчдыг хүлээн авах шударга, сайн хүмүүсийн зүрх сэтгэлийг нь нээж, оюун ухааныг нь бэлдэж байгаа билээ. Та нар тэднийг аль хэдийн таньдаг эсвэл удахгүй тэдэнтэй танилцаж болох юм. Тэд танай гэр бү-лийн гишүүн эсвэл хөрш чинь байж болно. Тэд гудамжаар таны хажуугаар өнгөрдөг хэн нэгэн эсвэл сургуульд хамт сурдаг, онлайнаар тантай холбогддог байж болно. (“Энэ бол гайхамшиг,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 88). ■

Сайн мэдээг гудамжинд хуваалцсан нь, *Кэн Спэнсэр Энэ хоёр номлогч АНУ-ын Нью Жерси дэх Нью Брунsvикийн номын дэлгүүрийн үүдэн дээр нэг хүнтэй сайн мэдээг хуваалцаж байна.*



СҮМИЙН ТҮҮХИЙН МҮЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ



ТАНЫ НОМЛОГЧИЙН ЭНГЭРИЙН ТЭМДЭГ

“Та гадуур хувцсан дээрээ ном-логчийн энгэрийн тэмдэгтэй бүрэн цагийн номлогч биш бол, Паулын хэлсэнчлэн, ‘бэхээр бус харин амьд Бурханы Сүнсээр’ зүрхэндээ бичих цаг болоод байна.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн “Энэ бол гайхамшиг,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 89.



Сүмийн түүхийн музейн зөвшөөрлөөр нийтлэв

Леменчүүд сарнай лугаа адил цэцэглэн хөгжих болно, Хоселито Жезуз Асэвэдо Гарсия. Энэхүү дүр зураг испаниар ярьдаг хүмүүсийн дундах номлолын ажлын сүнсийг харуулж байна. Хүмүүс өдөр тутмынхаа ажил үүргийг гүйцэтгэхээр явж байхад хоёр номлогч сайн мэдээг заахаар бэлтгэдэг. Жишгигхэн байшингууд болон нутгийн амьтдын дунд байрласан Перугийн Лима Ариун сүм сүмийн өсөлт хөгжилтийг төлөөлдөг.



© Ив. Жүэй Инг чэний зөвшөөрлөөр нийтлэв

Гандан бууршгүй номлогчид, Жүэй Инг Чэн Тайвань дахь сүмийн гишүүд газар газрын гишүүн номлогчдын адил сайн мэдээ болон судруудаас ирдэг баяр баясгаланг хуваалцахаар эрэлхийлдэг. Судрууд ширээн дээр байна; хуйлаастай бичгүүдийг агуулсан өндөр цэнхэр шүүгээн дотор Тайваний Тайпэй Ариун сүмийн зураг байна.



Сүмийн түүхийн музейн зөвшөөрлөөр нийтлэв

Сиерра Леон дахь хожмын үеийн гэгээнтэн номлогчид, Эмил Вилсон. Сиерра Леонд анхны номлол 2007 оны 7-р сарын 1-нд Фрийтаунд зохион байгуулагджээ. Фрийтаун 2012 оны арванхоёрдугаар сарын 2-нд сүмийн 3000 дахь гадас болов.



Далын Ахлагч
Эдуардо Гаваррэт

ТУЛААНД БЭЛТГЭСЭН НЬ

*Бид Аврагч, Эзэдийн Их Эзэнд итгэл найдвараа тавьснаар
бэлтгэгдэж, тулаанд бүдэрч ялагдахгүй байх болтугай.*

1485 онд III Ричард Английн хаан байв. Тэр үед улс төр тогтворгүй байсан бөгөөд Ричард хаан сэнтийгээ нэг бус удаа хамгаалах шаардлагатай болсон ажээ. Харин тэр 8,000-10,000 хүнтэй армитай, туршлагатай цэргийн жанжин, эрэлхэг зоригт, ухаалаг дайчин эр байв.

Мөн тэр жил Английн хаан ширээнд санаархагч, Ричмондын Өөрлийн Хэнри Тюдор Ричардтай сөргөлдөн: Босвөртийн Талбай гэдэг газарт түүнтэй тулалджээ. Хэнри, Ричардтай адилгүй нь дайн байлдааны туршлага нимгэнээс гадна цэрэг нь ердөө 5,000 хүнтэй байв. Гэвч иймэрхүү тулалдаануудад, түүний дотор Ричардын эсрэг тулалдаанд оролцож явсан сайн зөвлөхүүд язгууртнууд түүнд байлаа. Тулалдааны өглөө болоход Ричард ялах болно гэдэг нь юм бүхнээс тодорхой байлаа.

Нийтийн мэдэх нэгэн эмгэнэлт домог 1485 оны 8 р сарын 22-нд болсон үйл явдлын тухай товчхон өгүүлсэн байдаг. Тэр өглөө Ричард Хаан болон түүний цэргүүд Хэнригийн цэрэгтэй тулалдахаар бэлтгэж байлаа. Тулалдаанд ялагч нь Английн хаан болно. Ричард тулалдааны өмнөхөн хайртай аргамаг хүлэг нь бэлэн байгаа эсэхийг үзээд ир гэж агтчинаа явуулсан аж.







“Морийг түргэн тахал” гэж агтчин төмрийн дарханд тушаасан гэнэ. “Хаан цэргийнхээ түрүүнд аргамаг хүлгээ унан тулалдахыг хүсч байна.”

Төмрийн дархан түүнийг хүлээх хэрэгтэй гэжээ. “Би сүүлийн хэдэн долоо хоног хааны цэргийн бүх морьдыг тахалсан. Харин одоо төмөр авахаар явах хэрэгтэй байна” гэж дархан хариулжээ.

Тэвчээр муутай агтчин хүлээж чадахгүй гэж. “Хааны дайснууд одоохон давшаад ирнэ, бид тэднийг тулалдааны талбарт тосон тулалдах ёстой.” “Байгаа юмаараа морийг тахал.”

Ингэж тушаахад төмрийн дархан чадах бүхнээ хийж, морины дөрвөн тахыг савхан төмрөөр хийж, тахуудыг алхаар давтсаны дараа морины туурайнд гурвыг нь хадсан аж. Гэвч дөрөв дэх тахыг хадах гэтэл хадаас байсангүй.

“Одоо нэг эсвэл хоёр хадаас хэрэгтэй байна. Бас хадаасуудыг давтахад цаг хэрэгтэй шүү дээ” гэж төмрийн дархан агтчинд учирлажээ.

Гэвч, агтчин хүлээж чадсангүй, “Тулалдааны бүрээ үлээж байна шүү дээ!” “Байгаа юмаараа аргалж болохгүй юу?” гэв.

Төмрийн дархан чадах бүхнээ хийгээд ч дөрөв


дэх тах морины хөлд бөх тогтоно гэсэн баталгаа өгч чадахгүй гэжээ.

“Тахыг дээрээс нь хадчих” гэж агтчин тушаав. “Бушуулаач, тэгэхгүй бол Ричард Хаан та бид хоёрт хоёуланд нь уурлана шүү.”

Тулалдаан удалгүй эхлэв. Ричард Хаан цэргүүдээ зоригжуулахын тулд тулалдааны талбар дундуур хөндлөн гулд давхин, “Урагшаа давшаад! Урагшаа! Урагшаа!” гэж хашгиран тулалдаж байлаа.

Гэтэл Ричард тулалдааны талбарыг бүхэлд нь хартал хэсэг цэрэг нь ухарч байв. Тэрээр бусад цэргүүд нь ухрахаас айж, ухарч байгаа цэргүүд дээр очиж, тулалдаанаа үргэлжлүүлэхэд тэднийг зоригжуулахын тулд тэдний зүг хуй салхи мэт хурдан давхилаа. Гэвч Ричардыг тэдэнд хүрэхээс өмнө морь нь бүдэрч таварцаглан унахад хаан газарт хол шидэгджээ. Төмрийн дархны айж болгоомжлон, муухан хадсан нөгөөх тах хааныг яаран давхихад морины хөлнөөс мултарч унасан ажээ.

Ричардыг газраас харайн босоход морь нь босоод давхиад явчихаж. Хэнригийн цэргийг дайран ирэхэд Ричард илдээ агаарт өндөрт өргөн даллаж, “Морь! Морь! Хаант улсаа би ганцхан мориноос өглөө!” хэмээн хашгирч байжээ.



ӨЧҮҮХЭН ЗҮЙЛСИЙГ САНАГТУН

“Та нарыг дагаасай хэмээн Христийн хүсдэг бошигло-лын сургаалуудад дуулгавартай бай.

Сайн мэдээний баттай зарчмуудыг хэрэгжүүлэхийн оронд алдаа дутагдал гаргаж, ирээдүйн аз жаргалаа бүү алд. Өчүүхэн жижиг зүйлс том зүйлс рүү хөтөлдгийг санагтун. Ач холбогдолгүй мэт санагдах өчүүхэн жижиг болчимгүй үйлдэл эсвэл ийм үйлдлийг тоохгүй байх нь том асуудлууд руу хөтөлж мэднэ. Хамгийн чухал нь, байнгын хэвшил болсон энгийн, сайн зуршлууд нь арвин баялаг адислалуудаар дүүрэн амьдрал руу хөтөлдөг.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт, “Гэр орон дахь амар амгалангийн төлөө,” *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 33.

Гэвч нэгэнт оройтсон байлаа. Тэр үед Ричардын цэргүүд Хэнригийн дайран ирсэн цэргүүдээс айж, зугтааж байлаа. Ингээд тэд ялагдах нь тэр. Тэр үеэс хойш хүмүүс

*Хадаасгүй бол тах хэрэггүй,
Тахгүй бол морь хэрэггүй,
Морьгүй бол тулалдаанд ялагдана,
Тулалдахгүй бол хаант улсыг алдана,
Тиймээс морины тахны хадаас юм бүхнээс илүү чухал юм гэсэн нэгэн зүйр үгийг ярьдаг болсон гэнэ.¹*

Зарчмуудаа бататгах нь

Би энэ түүхийн тухай эргэцүүлэн бодоод, муухан хадсан морины тахны хадаас мэтийн өчүүхэн зүйл үйл явдал орвонгоороо эргэхэд хэрхэн нөлөөлж болохыг ойлгосон юм. Бид хадаасгүй морины тахыг сайн мэдээний зарчмуудтай зүйрлүүлж болно. Сайн мэдээний зарчмууд болон тэдгээртэй холбоотой үнэт зүйлс ба практик үйл ажиллагаанууд хангалтгүй байх нь биднийг уруу таталт болон нүгэл хилэнцийн эсрэг тулалдааны талбарт гар мухардаж, хүчин мөхөсдөхөд хүргэж болно.

Бидний амьдралд бас манай гэр бүлүүдэд ямар зүйлс хэвшил болоогүй байна вэ? Бид хувийн болон гэр бүлийн залбирлыг үл тоомсорлодог бил үү? Судруудыг хичээнгүйлэн судлахад хайрамжгүй ханддаг уу? Гэр бүлийн үдшийг тогтмол хийдэг бил үү? Аравны нэгээ бүрэн төлдөг бил үү? Ах эгч нартаа үйлчилдэг үү? Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахидаг бил үү? Ариун сүмд ордог бил үү? Бид хөршүүдээ хайрладаг уу?

Бид бүгд амьдралдаа үнэлэлт өгч, өөртөө юу дутагдаж байгааг ямар зарчим эсвэл дадал хэвшлийг хувийн амьдрал болон гэр бүлдээ илүү бат бөхөөр *төлөвшүүлэх* хэрэгтэй байгааг мэдэх ёстой. Бид тэрхүү зарчим эсвэл дадал хэвшлийг олж тогтоосны дараа уг зарчмаар бүрэн дүүрэн амьдарч, зөв зүйлийг дэмжин хамгаалахад өөрийгөө болон гэр бүлээ илүү сайн бэлтгэхийн төлөө сулхан хадсан *хадаасыг чангалахын* тулд тууштай, шаргуу ажиллах хэрэгтэй.

Их Эзэн Сургаал ба Гэрээнд “Авралын дуулгыг, мөн та нар дээр миний юүлэх Сүнсний минь иддийг, мөн та нарт илчлэх миний үгийг авагтун” (27:18) хэмээн зөвлөсөн байдаг.

Аврагч Өөрийн итгэлтэй үйлчлэгчдэд, “Тэдний гар миний мутар байх болно, мөн бибээр тэдний халхавч мөн бамбай нь байх болно; мөн бибээр тэдний бүсийг бүслэх болно, мөн тэд миний төлөө эрэлхэгээр тулалдах болно; . . . мөн зэвүүцлийнхээ галаар тэднийг хамгаалах болно би” (С ба Г 35:14) хэмээн амласан юм.

“Хүлэг морьдыг тулаанд мордоход бэлэн болгосон ч, “ялалт нь ЭЗЭНий гарт байдаг” (21:31) гэдгийг бид үргэлж санаж явах ёстой. “Христэд ирэгтүн мөн түүгээр төгөлдөржигтүн” (Моронай 10:32) гэсэн Моронайн урилгыг бид дагах ёстой. Бид Аврагч, Эздийн Их Эзэнд итгэл найдвараа тавьснаар нүгэл хилэнцийн эсрэг тулаанд бүдэрч ялагдахгүй байх болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. “For Want of a Horseshoe Nail,” хянан тохиолдуулсан Вилиам Ж.Бэннэт, *The Book of Virtues: A Treasury of Great Moral Stories* (1993), 198–200-г үзнэ үү.

АВРАЛЫН АЖЛЫГ ЯАРАВЧЛУУЛАХ НЬ

Бид бусдыг урьж, тэднийг хайрлан, тэдэнд үйлчилснээр Есүс Христийн жинхэнэ шавь нар болж, авралын ажлыг түргэсгэхэд тусалдаг.

Бүрэн цагийн номлогчид онлайнаар ажиллаж, цуглааны байруудын хөтөч хийж байгаа нь сэтгэл догдлуулам зүйл хэдий ч энэхүү өөрчлөлт нь өргөн цар хүрээтэй авралын ажлын зөвхөн өчүүхэн хэсэг нь юм. Гишүүд бид авралын ажлыг түргэсгэх энэхүү өргөн цар хүрээнд өөрсдөө багтаж байгаа нь бүр ч илүү чухал юм. Шинэ хөтөлбөрт идэвхтэй оролцохыг биднээс хүсээгүй, харин энэ нь биднийг Есүс Христийн жинхэнэ шавь нар байхыг л уриалдаг. Бидний үүрэг бол эргэн тойрныхоо хүмүүсийг хайрлаж, тэдэнд үйлчлэх тусламж хэрэгтэй хамт олноо тайтгаруулах, найз нөхдөө баптисмд урих, өндөр настай хөршдөө гэрээс гадуурх ажилд нь туслах, идэвх султай гишүүнийг хоолонд урих эсвэл хөршдөө гэр бүлийн түүхийн ажлаа хийхэд нь туслахад идэвхтэй оролцох явдал юм. Энэ бүхэн нь бидний идэвх султай гишүүд болон өөр итгэлд харьяалагддаг хүмүүсийг амьдрал ахуйдаа болоод улмаар сайн мэдээний гэрэлд урих тохиромжтой бөгөөд баяртай арга зам мөн. Бид тэдэнтэй хамт цагийг хөгжилтэй өнгөрүүлж, өөрсдийн амьдрал дахь нандин хормуудыг тэдэнтэй хуваалцах нь бидний хэнийх нь ч хувьд “хүмүүний бодгалиудыг аврахын тулд [Есүс Христийн] талбайд хөдөлмөрлөж” (С ба Г 138:56) болох хамгийн үр дүнтэй арга зам байж болно.

Авралын ажил гэж юу вэ?

Авралын ажил бол “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Мосе 1:39) Тэнгэрлэг Эцэгийн ажил юм. Энэхүү чухал ажилд гишүүдийн хийх номлогчийн ажил, хөрвөгчдийг идэвхтэй байлгах, идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх, ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажил тэрчлэн сургаалыг заах зэрэг нь орно.¹ Бид сайн мэдээний эдгээр асуудлууд хоорондоо уялдаа холбоогүй гэж бодох нь элбэг тохиолддог. Гэвч 2013 оны 6-р сарын 23-нд болсон *Авралын ажил: Дэлхий даяарх удирдагчдын шууд нэвтрүүлгээр* Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассэл М.Нэлсон “энэ ажил үнэхээр салшгүй юм. Эдгээр ажлууд салангид биш бөгөөд бүгдээрээ авралын ажлын нэгээхэн хэсэг юм” гэж заажээ.²

“Авралын ажлыг яаравчлуулах нь” гэсэн нийлэмж үг нь шууд нэвтрүүлгийн вэбсайтын (hasteningthework.lds.org) нэр бөгөөд: “Болгоогтун, бибээр өөрийн ажлыг зохих цагт нь яаравчлуулах болно” (С ба Г 88:73) гэсэн Их Эзэний амлалттай холбоотой юм.



ГЭРЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД СТОКЭР

Санваарын нэн чухал ёслолууд болох баптисм, гишүүний баталгаа, эрэгтэйчүүдийг санваарт томилох болон ариун сүмийн ёслолууд зэрэг нь Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих бидний аяллын онцгой чухал үйл явдлууд мөн. Бид авралын ажлуудад оролцсоноороо өөрсдөө гэрээний замыг дагахын хамт энэ замыг дагахад нь бусдад сүнслэгээр нөлөөлдөг билээ.

Гишүүд ба номлогчид санваарын түлхүүрүүдийн дор хамтран ажилладаг

Их Эзэний Сүмийн гишүүдийг Түүний авралын ажилд бүрэн татан оролцуулахад уриалан дуудах тулгуур

зарчим дээр дахин анхаарал төвлөрүүлэх цаг нь болоод байна. Гадасны ерөнхийлөгчид болон бишопууд өөрсдийн харьяалагдах Сүмийн нэгжүүдэд номлолын ажлын түлхүүрүүдийг атгадаг³ бөгөөд Христийн жинхэнэ шавь нарын хийх ёстой ажил болох сайн мэдээний гэрлийг хуваалцахад гишүүдэд тусалдаг. Номлолын ерөнхийлөгчид өөрсдийн удирддаг номлогчдын ажлыг удирдан чиглүүлэх боломжийг тэдэнд олгодог санваарын түлхүүрүүдийг атгадаг.⁴ Бүрэн цагийн номлогчид сайн мэдээг хүлээн авахад бэлэн болсон хүмүүст заахын тулд бэлтгэгдсэн байдаг. Тэд гишүүдэд гишүүний номлолын ажилд нь тусалдаг, харин гишүүд номлогчдод заахад нь



тусалдаггүй. Бүрэн цагийн болон гишүүн номлогчид нь сайн мэдээг хүлээн авахад Их Эзэний бэлтгэсэн хүмүүсийн амьдралд сургаалыг хүргэхэд тийнхүү хамтрагчид байдаг билээ.

Ерөнхийлөгч Томас С.Монсон шууд нэвтрүүлгийн үеэр “Эдүгээ гишүүд болон номлогчид Түүнд хүмүүсийг авчрахын төлөө Их Эзэний талбайд хөдөлмөрлөхийн тулд хүчээ нэгтгэн, хамтарч ажиллах цаг болжээ. Тэрбээр сайн мэдээг хуваалцах олон янзын арга замыг бидэнд зориулан бэлтгэсэн бөгөөд хэрэв бид Түүний ажлыг хийхээр итгэлтэйгээр үйлдэх аваас Тэр бидний ажилд туслах болно” гэж хэлсэн.⁵

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл Л. Андэрсэн хайрын ач холбогдлын тухай ярьжээ. “Бид эв нэгдэл ба итгэлээрээ хамтран ажилладаг, тэрхүү итгэл нь Их Эзэн бидний алхмуудыг удирдана гэдэгт итгэх итгэл бөгөөд бид өөр хоорондоо болон номлогчидтой эв нэгдэлтэй байхыг өдөөгч хүч нь [Есүс Христийг] болон

бие биеэ хайрлах хайр, тэрчлэн үйлчилдэг хүмүүсээ хайрлах бидний хайр юм.”⁶

Тойргийн зөвлөлийнхөн удирдаж, тойргийн номлолын удирдагч зохион байгуулдаг

Тойргийн зөвлөл бишопын удирдлаган дор тойргийнхоо авралын ажлыг төлөвлөж, удирдан зохион байгуулснаар гишүүдийн хүч чармайлтад дэмжлэг үзүүлэн, туслан, зохицуулдаг.⁷

Тойргийн номлолын удирдагч тойргийн зөвлөлийн гишүүний хувьд “сонирхогчдыг олж заах, тэдэнд баптисм хүртээх тойргийн ажлыг зохицуулна. Тэрээр энэ ажлыг бүрэн цагийн номлогчидтой хамтран зохицуулна.”⁸

Ахлагч Нэлсон тойргийн номлолын удирдагчдад хандан хэлэхдээ: “заах хүмүүсийг хайж, хаалга тогшин цагаа үрэхгүйн тулд төлөвлөгөөний дэвтрээ үр өгөөжтэй боломжууд болон уулзалтуудаар дүүргэхэд нь [номлогчдод] тусал... [Та нар] бол номлогчид, тойргийн



зөвлөл ба тойргийн гишүүдийг холбох тэдний хоорондох холбогчид юм” гэж хэлжээ.⁹

Амжилтын жинхэнэ хэмжүүр

Хожмын Үеийн Гэгээнтнүүд бид Их Эзэн Өөрийн ажлыг яаравчлуулж буй өнөө үед амьдарч байгаа адислагдсан хүмүүс. Бурханд биднийг энэ цаг үед газар дэлхийд байрдуулсан зорилго байгаа учраас бид өөрсдийн хийж чадна гэж бодож байгаагаасаа илүү ихийг хийх чадвартай юм. Бидний нөхөрлөл болон тусламж хэрэгтэй байгаа хүмүүст нинжин сэтгэл ба хайраар тусалбал бид бүтэлгүйтэхгүй байх болно. Бид оюун ухаан, зүрх сэтгэлдээ ирсэн сүнсний өдөөлтийг дагаж, сайн мэдээн дээр төвлөрсөн амьдралдаа бусдыг урьснаар номлолын ажилд амжилт гарна. Хүмүүс баптисм хүртэж Сүмд идэвхтэй болохгүй байсан ч гэсэн урилга нь амжилтын хэмжүүр мөн. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жэффри Р.Холланд эдүгээ номлогчдын агуу арми номлолын талбарт ирж байгаа тухай “Бид “Тэд энд ирж байна” гэж хэлэх ёстой цаг нь одоо тохиож байна. Бид бүгд тэнгэрээс илгээсэн энэхүү нөөцийг хамгийн үр дүнтэй байж болох арга замаар төлөвлөж, ашиглах ёстой” хэмээн хэлжээ.¹⁰

Бид бүгд авралын ажлыг түргэсгэхэд өөрсдийн гүйцэтгэх үүргийг улам тодорхой ойлгох цаг ирээд байна. Бид гишүүний номлолын ажлыг хийх, хөрвөгчдийг идэвхтэй хэвээр байлгах, идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцох болон сайн мэдээг заах явдлыг амьдралынхаа салшгүй хэсэг болгосноор агуу баяр баяслыг мэдэрч, 21-р зуунд Сүмийг хүчирхэгжүүлэхэд бидэнд хэрэгтэй сүнсний бэлгүүдээр хишиг хүртээгдэх болно. ■


Эшлэл

1. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 5-р бүлгийг үзнэ үү.
2. Рассэл М.Нэлсон, *Авралын ажил: Дэлхий даяарх удирдагчдын шууд нэвтрүүлэг*, 2013 оны 6-р сарын 23, hasteningthework.lds.org.
3. *Гарын авлага 2*, 5.1.6; 5.1.9-ийг үзнэ үү.
4. *Гарын авлага 2*, 5.1.6-г үзнэ үү.
5. Томас С.Монсон, *Авралын ажил*, hasteningthework.lds.org.
6. Нийл Л.Андэрсэн, *Авралын ажил*, hasteningthework.lds.org.
7. *Гарын авлага 2*, 5.1.2-ыг үзнэ үү.
8. *Гарын авлага 2*, 5.1.3.
9. Рассэл М.Нэлсон, *Авралын ажил*, hasteningthework.lds.org.
10. Жэффри Р.Холланд, *Авралын ажил*, hasteningthework.lds.org.

26 хэл дээрх Авралын ажил: Дэлхий даяарх удирдагчдын шууд нэвтрүүлэг видео бичлэгийг hasteningthework.lds.org-аар орж үзнэ үү. Та бас 59 хэлээр архивласан шууд нэвтрүүлгийг lds.org/broadcasts-аас олж үзэж болно. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* номыг lds.org/manual/handbook –ээс 29 хэлээр олж уншиж болно.



*Рожэр Ранд-
рианаризон
номлогчдыг ма-
шиндаа суулган
хүргэж өгснөөр
дагалдагчийн
аян замаа
эхэлжээ.*



Амар амгаланг ТОГТООГЧ БОЛОХ НЬ

*Ариун сүм, номлол ба үйлчлэл
нь Рожэр болон түүний гэр бүлд
мөнхийн гэр бүл болохоор урагш
ахихад нь тусалжээ.*

Маттью Д.Флиттон

Сүмийн сэтгүүлүүд

Гэр бүлийнх нь амьдралаас ямар нэг зүйл алга болсныг Рожэр Рандриана-ризон мэдсэн байв.

“Тэр бүлээ удирдах ямар нэг зүйлийг олоход туслаач хэмээн би Бурханд хандан залбирсан” гэж тэр хэллээ. “Би гэр бүлээ сайн зүйл рүү удирдах ямар нэг зүйлийг, зөв замаар удирдах ямар нэг зүйлийг хүсч байлаа.

Тэр гурван хүүхэд хоёр хөвгүүн Рандрианандри, Сэдинирина, охин Нирина-гаа хэрхэн өсгөн хүмүүжүүлэх талаар санаа тавьдаг байлаа. Түргэн уур нь гэр бүлд нь асуудал төвөг уддагт тэр урамгүй байдаг байсан. Тэр энэрэнгүй сэтгэлт эцэг байхыг хүссэн.

“Би ямар хүн болсноо мэдсэн учраас өөрчлөгдөх ёстой гэж шийдсэн” гэж тэр хэллээ.

Хэдэн жилийн өмнө Рожэрын барилгын компани дампуурсан учраас тэр Мадагаскарын Антананаривод таксины жолоочоор ажилладаг болжээ. Нэг өдөр тэр хоёр систер номлогчдод таксигаараа үйлчилсэн гэнэ.

“Тэд машин дотор орж ирсэн хойноо миний нэрийг бас намайг гэр бүлтэй юу? гэж асуув. “Тэд надаас та Бурханыг мэддэг үү, Түүнд хандан залбирдаг уу? гэж асуув.”

Номлогчид Рожэртэй хамт таксигаар явж байхдаа түүнд дуу дуулж өгөн, сүмд урьжээ. Тэр хэдэн удаа сүмд очихыг хичээсэн ч цуглаануудын цагийн хуваарьт тааруулж ирж чадсангүй, тэгээд номлогчидтой холбоо тасарсан ажээ.

Таван сар орчмын дараа нэг өдөр Рожэр гэртээ ажил хийж байтал хашааных нь гадаа хоёр номлогч хэн нэгэнтэй ярилцаж байхыг сонсчээ. Рожэр тэднийг өөртэй нь ярилцахаар ирснийг мэдэж байв. Өөрөөс нь асуусан тэдний ямар ч асуултад тийм гэсэн хариулт өгөх ёстойг тэр мэдэрчээ.

Номлогчид өөрсдийгөө танилцуулсны дараа түүнээс Бурханы тухай мэдэх юу? гэж асуув. Тийм ээ, мэднэ. Тэр Бурханд хандаж залбирахыг хүссэн үү? Тийм



Сайн мэдээг гэр бүлээрээ судалсан нь Рандрианаризоны гэр бүлд хамтдаа ойр дотно байж өсч хөгжихөд нь тусалжээ.

ээ, Тэр номлогчидтой ярилцахыг хүссэн үү? Тийм ээ, тэгсэн. Хэзээ? Одоо. Тэд 20 минутын дараа эргэж ирнэ гээд гарсан гэж номлогчид хэлжээ. Тэд буцаж ирэхдээ Рожэрын ойролцоо амьдардаг нэг гишүүнийг дагуулж ирэв.

Энэ номлогчид Рожэрт нэг сарын турш олон удаа гэрт нь ирж заасан ажээ. Гэр бүлийнх нь үлдсэн гишүүд сүмийн тухай сонссон зүйлүүдийнхээ улмаас, номлогчидтой хамт сайн мэдээг судлахыг хүссэнгүй. Рожэр сайн мэдээг нэг сар судалсны дараа номлогчидтой хамт сүм рүү очсон гэнэ. Өөрийг нь найрсгаар хүлээн авсан нь түүнд онцгой сэтгэгдэл төрүүлсэн ажээ. “Гишүүд намайг аль дээр үеэс таньдаг юм шиг хүлээн авсан” гэж тэр хэллээ.

Рожэр сүмээс гэртээ ирээд, сарын дараа баптисм хүртэнэ гэдгээ гэрийнхэндээ хэлээд тэд сүмд нэгдэх эсэхээ шийдэх нь чөлөөтэй гэдгийг бас сануулжээ. Гэрийнхэн нь түүнтэй нэгдэхийн тулд хүлээхийг түүнээс хүсэв. Тэд цуглаануудад оролцоод бас сэтгэл догдлон баяртай байсан гэнэ.

Сүмийн цуглаануудад анх удаа оролцсон нь Рожэрын ууган хүү Рандрианандид удаан үргэлжилсэн сэтгэгдэл үлдээжээ. “Намайг сүмд анх удаа очиход хүмүүс маш даруухан байсанд би их гайхсан” гэж тэр хэллээ. “Эхлээд, тэд сүмд ирэхдээ зохистой хувцасласан байв. Үүний дараа би хүмүүс тэнд бусад хүмүүст харуулахын тулд биш, харин үнэхээр зорилготойгоор цугласныг ойлгосон.”

Рандрианаризоныхон 2003 оны 2-р сарын 20-нд гэр бүлээрээ баптисм хүртжээ. Тэр үед Нирина 8-тай,

Сэдинирина 17-той, Рандриананди 19-тэй байлаа. Тэднийхэн ням гарагт ажилахаа больж, сайн мэдээний дагуу амьдрахыг эн тэргүүнд тавьсан байна.

Өөрчлөлтүүд

“Би баптисм хүртсэнийхээ дараа манай гэр бүлд олон өөрчлөлт гарсныг харсан” хэмээн Рожэрын эхнэр Арэлина хэлэв. “Манай гэр бүл сүнслэг болж, сайн мэдээгээр амьдарснаар материалаг болон сүнслэг олон адислал ирсэн юм.”

Материалаг адислалын тухайд гэвэл, Рожэр бизнесээ дахин хөл дээр нь босгоход Тэнгэрлэг Эцэг өөрт нь тусалсанд талархалтай байдаг ажээ. Тэр хоёр жил такси жолоодож, гэр бүлээ тэжээхийн тулд тааралдсан ажлуудыг хийж явсны эцэст барилгын ажлыг гэрээгээр гүйцэтгэх болсон ажээ. “Бурханыг дагахаар шийдсэн үед Тэрээр намайг үргэлж адисалдагт би итгэдэг” гэж тэр хэллээ.

Харин хөвгүүд нь тэдний харсан хамгийн том өөрчлөлт аавынх нь зан авирт гарсныг харсан хэмээн ярьж байна. Тэд одоо аавыгаа даруу байдал, нинжин сэтгэлийн үлгэр жишээ болгон дүрсэлж байна. Сайн мэдээ түүнд өөрчлөгдөх хэрэгтэй гэдэгт нь итгүүлсэн гэж Рожэр ярьдаг. Рожэр сайн мэдээг судалж эхэлснээсээ хойш амьдралаа сайн сайхан зүйлсээр дүүргэхийг хичээдэг болжээ.

“Би сайн мэдээний сургаалуудын ачаар дүрсхийн уурладгаа огт больсон” гэж тэр хэллээ. “Заримдаа уруу

татаалтууд тулгардаг ч сайн мэдээ миний зүрх сэтгэл, оюун ухаан, сүнсний хэсэг болж, надад тайван байхад тусалдаг.”

Сэтгэл зовоосон асуудал гарах үед Рожэр гэр бүлийн гишүүдээ тайвшруулж, Аврагчийн нэгэн адилаар үйлдэхийг тэдэнд сануулдаг цорын ганц хүн нь ажээ.

“Аав маань даруусч, гэр бүлдээ хайраар санаа тавьдаг болсон” гэж Сэдинирина хэлэв. “Аав минь ингэж өөрчлөгдсөнийг хараад би Тэнгэрлэг Эцэг, сайн мэдээ болон сүмийн гишүүн болсондоо би маш их баяртай байдаг.”

Мөнхийн гэр бүл

Рожэр, Арэлина хоёр 2006 онд Ариун Сүмийн ерөнхий ивээн тэтгэлтийн сангийн тусламжтайгаар ариун сүмд лацдан холбогдохоор Өмнөд Африкийн Иоханнесбург рүү явжээ.

2009-2011 онд Сэдинирина, Рандриананди хоёр Өмнөд Африкийн Кэйптаунд Сэдинирина, Рандриананди Иоханнесбургт номлолд үйлчилсэн ажээ. Тэдний үйлчлэх хүслийн хэсэг нь өөрийнх нь гэр бүлд гарсан шиг тийм өөрчлөлт бусад гэр бүлүүдэд гарахад туслах явдал байв.

“Үүн шиг гайхамшиг тохиож болно, мөн энэ нь номлогчид манай гэрт ирсний ачаар тохиосон юм” гэж Рандриананди хэллээ. “Тиймээс хаа сайгүй байгаа гэр бүлүүдэд яг ийм зүйлийг хийх хүсэл надад төрсөн юм.”

Энэ шийдвэр Рандрианаризоны гэр бүлд өөр нэг адислалыг авчирсан юм. Сэдинирина, Рандриананди хоёр Иоханнесбургийн Номлогчдыг Бэлтгэх Төвд ес хоногийн турш байжээ. Рожэр Өмнөд Африк руу Арэлина, охин Нирина нартайгаа хамт нисэхээр төлөвлөснөөр эднийх гэр бүлээрээ ариун сүмд лацдан холбогдох боломжтой болжээ. Тэр үед 14-тэй байсан Нирина мэдэрсэн мэдрэмжээ дүрслэн ярих нь үнэхээр хэцүү байсан гэж ярилаа.

“Энэ нь миний итгэлийг бэхжүүлж, Бурханд илүү ойр байгаагаа мэдрэхэд надад

тусалсан” гэж тэр хэллээ.

Өнөөдөр энэ гэр бүлийн гишүүд эргэн тойрныхоо хүмүүсийг төлөвшүүлэн, хүчирхэгжүүлэхийн төлөө ажиллаж байна. Рожэр тойргийнхоо бишпоор үйлчилж байгаа бол Арэлина Хүүхдийн Хэсэгт Бурханд итгэх итгэл хөтөлбөр дээр ажиллаж байна. Сэдинирина гадасны бичиг хэргийн ажилтны туслах. Рандриананди бол тойргийн бичиг хэргийн ажилтны туслах. Нирина тойргийн хөгжмийн удирдагчаар үйлчилж байна.

Сайн мэдээ Рандрианаризоньхны гэр бүлийн залбирлуудын хариу юм. Энэ нь өнгөрсөн үеийн сэтгэл санааны зовлонг эдгээж, тэднийг хооронд нь улам ойртуулан, үүрд мөнхөд хамтдаа байх боломжийг тэдэнд олгосон ажээ. Энэ нь бусдыг хэрхэн хайрлахыг Рожэрт заасан юм. “Гэр бүлийн амьдрал бол хайраар дүүрэн амьдрал” гэж тэр хэллээ. ■

Иоханнесбургийн Ариун сүмд лацдан холбогдохоор Өмнөд Африк руу явсан нь Рандрианаризоны гэр бүлийг хүчирхэгжүүлжээ.



АРИУН СҮМИЙН ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭЛТИЙН САН

“Ариун сүмүүд гишүүдийн амьдарч байгаа газруудаас маш хол дэлхийн зарим хэсгүүд байсаар байгаа учраас гишүүд ариун сүм рүү аялахад шаардлагатай зардлаа төлөх хангалттай мөнгө олж чадаагүй байна. Тиймээс тэд ариун сүмүүдэд гүйцэтгэдэг эрхэм нандин, мөнхийн адислалуудыг хүртэх боломжгүй байгаа юм. Энэ хэрэгт туслахын тулд Ариун сүмийн Ерөнхий ивээн тэтгэлтийн сан гэж нэрлэгддэг сан бидэнд байдаг. Энэ сан нь өөрийн зардлаараа ариун сүм рүү явах боломжгүй, болон энэ боломжийг удаан хугацааны турш хүсэн хүлээсэн хүмүүст зориулан ариун сүм явахад нь зөвхөн нэг удаа тусламж үзүүлдэг. Энэ санд хандив өргөхийг хүссэн хэн боловч бишопт өгдөг хандивын хуудсан дээрх мэдээллийг бөглөж болно.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон,
“Бид дахин уулзлаа” Лиакона,
2010 оны 11-р сар, 5

МАТТЮ ЭРГЭЖ ИРЭХ БОЛОВ УУ?

Манай тойрогт сүнсэлэг байдлын хувьд хүчирхэг залуу эрэгтэйчүүд олон байдаг байв. Гэвч манай хүү Маттью авто машин болон механик сонирхдог, үүнийгээ Маттьютай хуваалцаж сүмийн гишүүн бус нэг залуутай танилцсан юм. Харамсалтай нь, энэ залуугийн гэр бүл шашныг үнэлдэггүй ажээ. Эцэг эх хоёр нь гэртээ архи уух, тамхи татахыг зөвшөөрдөг бөгөөд ёс суртахууны хувьд цэвэр ариун байх нь чухал гэдэгт итгэдэггүй.

Маттью Хөвгүүдийн Скаутад дээд зэрэглэлийн болзлыг хангасан ч, Скаутын ёс суртахууны жишгүүдээр амьдрахаа больсон учраас уг зэрэглэлийг түүнд гардуулах хуралд очоогүй ажээ. Би түүний Скаутын бүх шагналыг цуглуулж, жаазанд хийлээ. Тэгээд жаазан дахь шагналуудыг тэр хэзээ нэгэн цагт үнэлэх болно гэж бодоод далд хийв. Маттью 16-тай байхдаа тамхи татаж, архи уун, хууль бус эм тариа хэрэглэдэг болов. Тэр сургуулиа хаяж, найз охинтойгоо

өөр газар руу нүүв. Бид түүнийг хоёр жил бараг харсангүй.

Бид бүр яахаа ч мэдэхээ болиод байлаа. Бид түүнийг гэр бүл болон итгэлдээ эргэн ирэх эсэхийг мэдэхгүй байлаа. Гэвч бид дуулгаваргүй хүүгийнхээ төлөө Алмагийн үзүүлсэн үлгэр жишээг дагахаар шийдсэн юм. Алма хүүтээ үргэлж хайрлан, тэрээр “үнэний мэдлэгт авчрагдаж” (Мозая 27:14) болохын тулд итгэлтэйгээр залбирдаг байлаа.

Их Эзэн Маттьюгийн амьдралд хөндлөнгөөс оролцохын төлөө бид байнга залбирч, түүнийг хэчнээн их хайрладгаа үгээр болон үйлдлээр илэрхийлэх боломж бүрийг ашигладаг байлаа. Бид хүүтээ гэртээ ирэхэд түүнийг шүүмжилсэн эсвэл шүүсэн гэж бодохоор ямар нэг зүйлийг огт хэлдэггүй, зүгээр л түүнтэй уулзсандаа баяртай байгаагаа илэрхийлдэг байсан.

Маттью нэг өдөр гэртээ ирээд бидэнтэй ярилцахыг хүсч байгаагаа хэллээ. Тэр сүмийн тухай

асуусан нэг охинтой үдэшлэг дээр танилцсанаа ярилаа. Хариултыг нь мэдэхгүй гэж тэр охинд хэлэхээс өмнө Маттьюгийн амнаас үгс аяндаа урсан гарсан гэнэ. Маттью түүнийг асуултууд асуухад тэр дор нь хариулж байгаагаа анзаарчээ. Маттью хэлсэн зүйлсээ хэрхэн мэдсэнээ санасангүй, гэвч түүний хэлсэн үгс үнэн гэдгийг мэдэж байлаа. Тэр сайн мэдээнд итгэсэн хэвээр байсан атлаа, яагаад ийм байдлаар амьдарч байснаа гайхжээ.

Гурван хоног тунгаан бодсоны эцэст тэр амьдарч байсан амьдралынхаа хэв маягийг орхихоор шийдсэн гэнэ. Тэр сайн мэдээний дагуу амьдрах шинэ амьдралаа эхлэхэд туслалцаа хүсэхээр гэртээ ирсэн ажээ.

Маттью өөртэй нь адил сорилтыг даван туулсан, өөр нэг мужид амьдардаг үеэл рүүгээ утасдаж өөртэйгөө хамт байхыг хүсчээ. Үеэл нь зөвшөөрч Маттью түүнтэй хамт сүмийн цуглаанд оролцож эхэлсэн ба наманчлалын үйл явцдаа тусламж авахын тулд бишоптойгоо уулзжээ. Тэр хайр, дэмжлэгийг мэдэрч, сүмийн идэвхтэй гишүүн болсон.

Хэсэг хугацааны дараа тэр нүдэнд дулаахан, шударга нэгэн эмэгтэйтэй танилцав. Тэд бие биедээ хайр сэтгэлтэй болж, ариун сүмд гэрлэсэн.

Би тэдний анхны хүүхдийг төрөхөд айлчилж очихдоо хүүгийнхээ Скаутын шагналуудыг хийсэн жаазаа авч очив. Маттьюгийн сэтгэл догдолж, жаазыг гэрийнхээ ил харагдах газарт бахархалтайгаар өлгөсөн юм.

Залуу Алмад тохиолдсон шиг хүү дээр минь тэнгэр элч хүрч ирээгүй. Гэвч Маттью үнэнд эргэж ирсэн нь үнэхээр гайхамшиг байлаа. ■
Нэрийг нууцлав



Би Маттьюгийн Скаутын бүх шагналыг цуглуулж, жаазанд хийсэн. Тэгээд тэр хэзээ нэгэн цагт үүнийг үнэлэх болно гэж бодоод жаазыг далд хийв.

БИ ГЭРТЭЭ БАЙГАА ЮМ ШИГ БАЙЛАА

Миний бие үйлчлэлийн төслийн багт орж эмнэлгийн тусламж хэрэгтэй хүмүүст туслахаар өөр хэдэн эмчийн хамт Руандад очсон юм. Хоёр долоо хоногийн дараа, миний аялал дуусах ойртоод байсан үед би гэрээ учиргүй их саналаа. Би гэр бүлээ, ая тухтай ороо, гэр орноо их санаж байв.

Африкт байсан сүүлчийн ням гарагт би сүмд очихын тулд ажлын хуваариа зохицуулах боломжтой байв. Руандад сүмийг албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй байсан ч, би цуглааны цаг болон цуглаан болох газар руу очих замыг сүмийн вэб-сайтаас олсон юм.

Замыг заахдаа хачирхалтайгаар дүрсэлжээ: “Яамны барилгаас чулуу дэвссэн зам хөндлөн уруудан яв. Нээлттэй хаалга байгаа. Тэгээд шатаар урууд.”

Заасан чиглэлийг даган явж байтал, миний сайн мэдэх нэгэн дууллын ая тодхон сонсогдлоо. Шатаар уруудаж явтал “Бат бөх суурь” (*Сүмийн дуулал*, х. б) дууллын үгс миний чихэнд сонстов. Шат нэгэн жижигхэн барилгын үүдэнд төгсөхөд орох хаалганы дэргэд инээмсэглэсэн хэдэн арван хүн зогсож байх нь харагдлаа. Цугларагсдын хувьд би

гадны хүн байсан ч өөрийгөө тэдний хэсэг болохыг тэр даруй мэдрэв. Руандагийн хэдэн арван ах, эгч нар өөдөөс минь угтан ирж надтай гар барихад ганцаардлын хүнд дарамт мөрөн дээрээс авагдаж гэртээ байгаа юм шиг мэдрэмж төрөв!

Би барилга руу ороод Калифорни дахь манай тойргийн цуглааны байраас ялгарах юмгүй байранд гурван цагийн цуглаанд оролцлоо. Аароны санваартнууд ариун ёслол түгээж,

Цугларагсдын хувьд би гадны хүн байсан ч өөрийгөө тэдний хэсэг болохыг тэр даруй мэдрэв. Руандагийн хэдэн арван ах, эгч надтай гар барихаар өөдөөс минь угтан ирлээ.

Аврагч дээр төвлөрсөн үгсийг хэллээ. Бүр ням гарагийн ангид манай тойрогт заадагтай яг адил хичээлийг тэр долоо хоногт заав.

Хамгийн чухал нь, тэр цуглаануудад оролцож байхдаа би Их Эзэний Сүнсний хүчтэйгээр мэдэрсэн юм. Өөрт нь үйлчлэхийн тулд чадах бүхнээ хийхийг хичээж буй эдгээр сайхан хүмүүсийг Их Эзэн тааламжтайгаар инээмсэглэн харж байгаа нь мэдээж юм. Өмнөх жил нь энд болдог байсан цуглаануудад ердөө хэдхэн хүн оролцдог байсныг би мэдсэн. Миний тоолсон 100 гаруй хүмүүсээс тэн хагас нь инээмсэглэсэн хүүхдүүд байлаа.

Руанда улс номлолын ажилд нэгэнтээ үүд хаалгаа нээсэн болохоор тоо нь улам өсөн нэмэгдэж байгаа Руандагийн сонирхогчдод сэргээгдсэн Сүм бол бүх дэлхий, бүх тив, бүх хүмүүс болон Бурханы хүүхэд бүрийн хувьд Бурханы хаант улс мөн гэдгийг Сүнс гэрчлэхэд номлогчид агуу амжилт олох болно гэж би бодож байна. Сүм Калифорнийн эргийн төв хэсэгт байна уу, төв Африкт чулуун замын дэргэд байна уу гэдгээс үл хамааран би сүмд хэчнээн их талархалтай байдаг билээ. ■
Стефен Сэйнсбери, АНУ, Калифорни



ТАНАЙХ ЯАГААД РЕКСБУРГТ ШИЛЖИЖ ИРСЭН ЮМ БЭ?

Нөхөр бид хоёр сүмийн гишүүд цөөтэй газар хэдэн арван жил амьдарсны дараа, гишүүн бус хоёрхон гэр бүлтэй АНУ-ын Айдахогийн Рексбургийн ойролцоо шилжиж ирсэн юм. Тэр хоёр гэр бүлийн нэгтэй нь хөрш болон амьдрах сайхан боломж бидэнд тохиосон билээ.

Биднийг машинтайгаа анх ирэх үед тэр айлын аав нь зүлгээ хадаж байв. Нөхөр бид хоёр түүнтэй танилцахаар зүлгэн дээгүүрээ алхаж очлоо. Би түүнтэй гар барихдаа “Танай гэр бүл яагаад Рексбургт ирсэн бэ?” гэж асуулаа.

“Миний зорилго бол Христэд авчрах хэрэгтэй энэ хотыг бид онцгойлон сонирхсон юм” гэж тэр хариулав.

Нүүр рүү минь хувингаар хүйтэн ус цацах шиг санагдсан ч би инээмсэглэв. Би яг тэр мөчид шинэ хөршийнхөө юу гэж хэлсэн эсвэл хийсэн нь хамаагүй, бид тэр гэр бүлд хэзээ ч байгаагүй *хамгийн сайн* хөрш нь болохоор шийдсэн

юм. Бид тэдэнтэй харилцсан бүхий л харилцаандаа Аврагчийн адилаар эелдэг уриалгахан, хайр, хүндэтгэлээр хандахыг хичээдэг байлаа.

Найман жилийн турш манай хоёр гэр бүл олон үйл ажиллагаанд бие биенээ урьсан юм. Бид тэдний ээжийг Нийгмийн Халамжийн Бүлгийн олон үйл ажиллагаанд урьж оролцуулсан. Тэр намайг болон хожмын үеийн гэгээнтэн манай олон хөршийг өөрийнхөө сүмийн ивээн тэтгэдэг Христэд итгэгч эмэгтэйчүүдийн үйл ажиллагаанд урьсан. Нөхөр бид хоёр тэдний хүүхдүүдийн бүжгийн болон төгөлдөр хуурын тоглолтонд уригдав. Тэдний гэр бүлийг хөршүүд маань гадаа хооллохдоо мөн үдэшлэгтээ урьж оролцуулдаг байлаа. Тэдний том хүүхдүүд ажлаасаа гэртээ ирэхэд унаа хэрэгтэй болсон үед эцэг эхтэйгээ холбоо барьж чадаагүй үедээ бидэн рүү утасддаг байв.

Хүүхдүүд нь хожмын үеийн гэгээнтнүүдэд хэтэрхий сайн

ханддаг болчихвий гэж эцэг эх нь санаа зовсондоо хөвгүүддээ манай тойргийн Скаутын хөтөлбөрт оролцохыг зөвшөөрдөггүй байв. Гэвч тэд манай гэрийг аюулгүй газар гэж үзсэн учраас ач нарыг маань манайд ирсэн үед хүүхдүүдээ манайд ирж тоглохыг зөвшөөрдөг байлаа.

Хөршүүд маань бидэнд “буруу замаар явж байгааг” ойлгоход туслахаар хичээх бүрт бид тэдний итгэл бишрэл, амьдралын хэв маяг болон үр хүүхдээ хэрхэн хүмүүжүүлдгийг нь дээд зэргээр хүндэлдгээ тэдэнд хэлдэг байв. Тэгээд бид Аврагчийн сургаалууд дээр төвлөрдөг бидний итгэл бишрэлд бусад хүмүүс бас хүндэтгэлтэй хандахыг хүсэн хүлээдэг гэдгээ нэмж хэлдэг байлаа.

Тэр гэр бүлийн ээж, хожмын үеийн гэгээнтнүүд “өөр Христэд” итгэдэг гэдгээр шалтаглан бидний итгэл дэх ялгааг өөрсдийгөө биднээс улам холдуулахад ашиглахыг хичээхэд нь Есүс бол бурханлаг бөгөөд Бурханы хайртай Хүү гэдэгт бидний хэн хэн нь адилхан итгэдэг шүү дээ хэмээн би сануулдаг байв. Бид хоёрын харилцаа яваандаа элэгсэг дотно, нөхөрсөг болсон юм.

Тэдний гэр бүл сүмд нэгдээгүй бөгөөд тэндээс нүүсэн юм. Гэвч, хэрэв тэд, “Бид мормончуудын дунд амьдарч байлаа. Тэд сайхан сэтгэлтэй, хүндэтгэл хүлээхээр сайн хүмүүс” гэж хэлэх юм бол бид тэдний сайн хөршүүд байж, хожмын үеийн гэгээнтнүүдийн талаарх бодолдоо илэн далангүй, шударга байхад нь тэдэнд туслах талаар амжилт олсон хэрэг хэмээн би бодно. ■

Сандра Раш, АНУ, Айдахо,



Би яг тэр мөчид шинэ хөршийнхөө юу гэж хэлсэн эсвэл хийсэн нь хамаагүй, бид тэр гэр бүлд хэзээ ч байгаагүй *хамгийн сайн* хөрш нь болохоор шийдсэн юм.

ХАЙРЦАГТАЙ ЗУРАГНУУД

Хэдэн жилийн өмнө нөхөр бид хоёр хотын хогийн цэг дээр хогоо буулгаж байгаад тэнд ажиллаж байсан эмэгтэйчүүдийн нэг нь нэг хайрцгийг аваад хог шатаах зуух руу хийхийг харлаа. Тэгтэл нөгөөх хайрцаг гэнэт задарч, дотроос нь баахан зураг газарт унав.

Үүнийг хараад хайрцагтай зургуудыг авах хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж надад төрлөө. Би зурагнуудыг авахад туслахын тулд машинаас үсэрч буув. Гэрэл зургуудыг андуурч хаясныг тэр эмэгтэй бид хоёр хоёул мэдсэн болохоор би эзнийг нь олохоор оролдоод үзье гээд зурагнуудыг авч явья гэж эмэгтэйд хэллээ.

Би хайрцаг доторх хэдэн зуун зургийг онгичсоор Канадын Альбертын Варбург дахь нэг хүний хаягтай дугтуй олов. Би дараагийн хэдэн жилийн турш дугтуйн дээрх овгийн нэр нь адил хүмүүст нэлээд хэдэн захидал бичсэн ч хариу хүлээж авсангүй.

Манай гэрийнхэн интернетэд орж хайлт хийсний эцэст би Варбургт түүхийн нэгэн нийгэмлэг байдгийг олж мэдэв. Би зурагнуудын ар дээрх нэрүүдийг мэдэх хүн байна уу гэж тэнд ажилладаг хүмүүсээс лавлав.

Сарын дараа түүхийн нийгэмлэгийн холбоо барьсан нэг хүн над руу утасдлаа. Тэр хүний эгч нь бидэнтэй ойрхон амьдардаг гээд эгчдээ зургуудыг үзүүлж болох уу гэж асуулаа. Мэдээж болно гэж бид хариулсан.

Маргааш нь Флоид Хооторн, Бет Хооторн гэдэг хожмын үеийн хоёр гэгээнтэн зургуудыг үзэхээр ирэв. Намайг хайрцгийг онгойлгоход Хооторн ах, “Өө, тэр мөн байна” гэж хамгийн дээд талд байсан зураг руу

заав. Энэ нь Хооторн эгчийн өвөөгийн зураг ажээ.

Хооторн ах, эгч хоёр зургуудыг нэг нэгээр нь гаргаж ирэн, зураг бүр дээрх хүмүүсийн тухай түүхүүдийг бидэнд ярьж билээ. Хооторн ах, эгч хоёр зургуудыг хаясан хүнтэй ямар холбоотойгоо болон зургууд яагаад хог хаядаг газарт очсон тухай огт мэдэхгүй байлаа.

Тэгтэл нөгөөх хайрцаг гэнэт задарч, дотроос нь баахан зураг газарт унав. Үүнийг хараад хайрцагтай зурагнуудыг авах хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж надад төрлөө.

Гэрэл зургуудыг Хооторны гэр бүлд буцааж өгөхөд Тэнгэрлэг Эцэг надад тусалсан гэдэг хүчтэй мэдрэмж надад төрсөн юм. Гэр бүлийн түүхийн ажил бол бидний хийх ёстой хамгийн чухал ажлуудын нэг мөн. Хэрэв бидэнд энэ ажлыг хийх хүсэл байвал Их Эзэн бидэнд үүнийг хийхэд туслах болно. ■

Синди Хэгги, Канад, Альберта



Би хэрхэн АМЖИЛТТАЙ номлогч болж чадах вэ?

Хамтрагч бид хоёр хэчнээн шаргуу ажилласан ч хүн бүр бидний захиасыг эсэргүүцэж байлаа. Бид амжилттай номлогчид болохын тулд юу хийж болох байсан бэ?

Лорэн Бангэртэр Вайлд

Би номлолдоо ирээд жил гаруй болж байхад онцгой хүнд үе тулгарч билээ. Хүйтэн өвөл дөнгөж өнгөрч, бид уйтгартай, дүнсгэр хаврын дунд үетэй золгоод байлаа. Хамтрагч бид хоёр хэчнээн шаргуу ажилласан ч, бидний ярилцсан хүн бүр бидний захиасыг тэр даруй эрс эсэргүүцэж байв. Бид бусад номлогчидтой уулзаад тэдний ажил урагштай байгааг мэддэг байлаа. Бид яагаад амжилт олж чадахгүй байсны ямар ч шалтгааныг би олж чадсангүй. Би номлолын талбарт ирээд тэр орны хэлээр хангалттай удаан хугацаанд ярьсан байлаа, бас хамтрагч бид хоёр сайн найзууд болж, гишүүдийн итгэлийг олсон байв. Мөн бид Сүнсний дагаж, номлолын дүрмүүдийг ягштал биелүүлэхийг хичээдэг байсан.

Гэвч бид хэчнээн хичээгээд ч хийсэн юм бүхэндээ эсэргүүцэлтэй тулгардаг байв. Үүнээс хэдэн долоо хоногийн дараа миний таагүй бодол санаа намайг дийлсэн байлаа. Төлөвлөгөө гаргаж байхдаа би “Номлолын ажил хийхийн утга учир юу юм бэ? Хэн ч биднийг сонсохгүй байна шүү дээ!” хэмээн дуу алдлаа. Надаас илүү

өөдрөг үзэлтэй хамтрагч маань, “Итгэлээ харуулахын тулд зорилго тавья. Адислалуудаа тоолж зорилгынхоо биелэлтийг шалгацгаая” гэлээ.

Би түүний санааг тунгаан бодоод номлогчийн хувьд амжилтаа дүгнэх буруу арга хэрэглэж байснаа ойлгов. *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамжид* амжилттай номлогчдын зан чанаруудын жагсаалт¹ байдаг бөгөөд тэдгээр бүх зан чанаруудыг номлогчид хянах боломжтой юм. Манай номлолд харьяалагдаж байгаа хүмүүс сайн мэдээний захиасыг хүлээн авах эсэхийг би хянаж чадахгүй, харин би ямар номлогч байхаа сонгож чадна. Миний хамтрагч надад Есүс Христэд итгэх агуу итгэл болон Түүний адислалуудад талархалтай байх нь намайг аль хэдийнээ амжилттай номлогч болгосон арга замуудыг танин мэдэх боломжийг надад олгосон юм.

Итгэл бидэнд гайхамшгуудыг олж харахад тусалдаг

Өөртөө итгэл дутагдаж байгааг хүлээн зөвшөөрсөн нь намайг даруусгасан юм. Би итгэлээ хүчирхэгжүүлж болох зүйлсийг хайж,

төлөвлөгөөний дагуу болохгүй байгаа юмсыг олж мэдээд сэтгэлээр унадаг байжээ. *Миний сайн мэдээг номло* удирдамжид: “Сэтгэлээр унах нь итгэлийг тань сулруулна. Хэрэв та хүлээлтээ бууруулбал, номлолын ажлын үр дүн буурч, таны хүсэл суларч, Сүнсний дагах нь улам хэцүү болно” гэж заадаг.² Би амжилт олж чадаагүйгээсээ болоод итгэлээ сулруулснаа ойлгосон.

Тэгээд би зүрх сэтгэлийн өөрчлөлт, илүү их итгэлийн төлөө залбирч эхэллээ. Би Мормон 9:21 шүлэг дээрх: “Христэд эргэлзээгүйгээр итгэх хэн боловч, тэрбээр Эцэгээс Христийн нэрээр юуг ч гуйсан тэр нь түүнд өгөгдөх болно; мөн энэ амлалт нь бүгдэд, бүр дэлхийн хязгааруудад ч адил буюу” гэсэн амлалтад найдсан билээ. Энэ амлалт хамтрагч бид хоёр хэрэгтэй үедээ мэдэрсэн адислал болон гайхамшгуудын төлөө илүү их эрч хүчтэйгээр залбирахдаа “Таны хүсэл биелэгдэг” гэж үргэлж хэлэхэд намайг хөтөлсөн юм. Эдгээр залбирал надад хариултауд нь бидний хүсэн хүлээгээгүй арга замаар ирсэн байлаа ч Тэнгэрлэг Эцэг итгэлийн залбиралд үргэлж хариулдаг



АМЖИЛТТАЙ НОМЛОГЧ БОЛОХ НЬ

Та дараах чанаруудыг эзэмшсэнээр амжилттай номлогч болсноо мэдэх болно:

- Сүнс өөрөөр тань дамжуулан хүмүүст гэрчилгэийг мэдэрдэг байх.
- Хүмүүсийг хайрлаж, тэднийг аврахыг хүсдэг байх.
- Чанд дуулгавартай байх.
- Христийнхтэй адил зан чанаруудыг хөгжүүлдэг байх.
- Нүглийн үр дагавруудаас хүмүүсийг сэрэмжлүүлдэг байх. Үүрэг авч, түүнийгээ биелүүлэхэд хүмүүсийг урьдаг байх.
- Хүмүүс таны захиасыг хүлээн авах эсэхээс үл хамааран боломж олдох бүрт сайныг үйлдэн бусдад үйлчилдэг байх.

Миний Сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамжаас (2004), 10–11.

ИХ ЭЗЭНЭЭР ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХӨӨР ЭРЭЛХИЙЛ



“Та бүхнийг Их Эзэнээр хүлээн зөвшөөрүүлэхийн тулд хичээснээр, Түүний амлагдсан адислалуудыг хүлээн авахыг би чин сэтгэлээсээ хүсч байна. . . . Бид албан тушаал, нийгэмд эзлэх байр суурь, мөнх бус гачигдал, зовлон зэргээс үл хамааран, Түүгээр хүлээн зөвшөөрөгдсөнөө мэдэж [болно]. Тэр биднийг хайрлах хайраар хүлээн зөвшөөрсөн нь биднийг урамшуулан, бидний түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлж, энэ амьдралд тулгарах асуудлуудыг шийдэхэд бидэнд туслах болно. Бидэнд тулгарах сорилтуудаас үл хамааран, бид амжилттай байж, [Мозая 2:22-ыг үзнэ үү], амар амгаланг мэдрэх болно [Мозая 2:41-ийг үзнэ үү].”

Далын Ахлагч Эрик В.Копишкэ, “Их Эзэнээр хүлээн зөвшөөрөгдөх нь,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 122.

гэдгийг мэдсэнээр өөрчлөгдсөн төлөвлөгөө болон саад бэрхшээлүүдийг илүү их итгэлтэйгээр хүлээн авахад надад тусалсан юм. Амьдралын маань турш Их Эзэний биднийг удирдаж байсан арга замуудыг би таньж мэдэх чадвартай болсон юм.

Би итгэлээ хүчирхэгжүүлэхийн төлөө ажилласнаар: хэрэв та хүлээлтээ нэмэгдүүлбэл, номлолын үр дүн дээшилж, таны хүсэл өсөн нэмэгдэж, Сүнсийг илүү сайн дагах боломжтой болно гэсэн *Миний сайн мэдээг номло* удирдамж дээрх үгс үнэн болохыг мэдсэн юм. Түүнээс гадна, би өдөр тутам тохиолддог гайхамшгуудыг таньж мэдэн, талархалтай байснаар номлолын ажил болон номлогчийн үйлчлэлийн талаар илүү өөдрөг үзэлтэй болсон.

Талархал бол атаа жөтөөний эсрэг зүйл

Их Эзэн бидний төлөө гайхамшгуудыг өдөр бүр үйлддэгийг надад харуулж эхэлсэн гэвч би чин сэтгэлээсээ талархалтай байх ухамсартай хүч чармайлт гаргах хүртлээ тэдгээр гайхамшгуудыг таних чадваргүй байсан юм. Талархал илэрхийлэх нь зүгээр нэг сайн хэвшил эсвэл сайхан харьцаанаас илүү чухал зүйл. Би Их Эзэнд болон бусад хүмүүст талархал илэрхийлсэн үедээ хүч чадалтай болдог байлаа. Бусад номлогчид амжилттай байгаа бол атаархахын оронд тэдний төлөө баярладаг болсноо би мэдсэн юм (Алма 29:14, 16-г үзнэ үү). Би өөртөө дутагдаж байгаа зүйл эсвэл буруу болсон зүйл дээр биш харин өөртөө байгаа болон зөв болсон зүйл дээр анхаарал төвлөрүүлдэг болсон.

Талархал нь өөрийгөө бусад хүмүүстэй харьцуулахаас зайлсхийхэд бидэнд тусалдаг. “Би өөрийнхөө хийх ажлыг сайн хийхгүй байна” эсвэл “Тэд үүнийг хийхдээ надаас илүү” гэж өөртөө хэлэх үед үргэлж

өөрийгөө амжилттай номлогч гэж мэдэрдэггүй байсан. Бидэнд даган дууриах зөв шударга үлгэр жишээг өгдөг Их Эзэний загвар байхад Сатаны хууран мэхлэлт нь биднийг өөрсдийн үнэ цэнэ, амжилтаа тодорхойлохын тулд бусадтай өөрсдийгээ харьцуулахад уруу татдаг. Гэвч *Миний сайн мэдээг номло* удирдамж энэхүү нөхцөл байдлыг: “Өөрийгөө бусад номлогчидтой, өөрийнхөө хүч чармайлын үр дүнг гадна талаас нь хараад тэднийхтэй харьцуулахаас зайлсхий” хэмээн тодорхой дүрсэлсэн байдаг.³ Чухамдаа, талархал нь бардамналаас зайлсхийхэд надад тусалж, Их Эзэн Өөрийн ажлыг хариуцдаг гэдгийг надад сануулсан юм. Миний нөхөд болох номлогчид илүү амжилттай байх шиг санагдсан учраас би тэдэнд атаархах хэрэггүй байлаа.⁴

Амжилтын жинхэнэ хэмжүүр

Би үзэл бодолдоо ийм өөрчлөлт гарахаас өмнө Их Эзэн бидний залбирлуудад хариулж, бидний номлолын ажлыг адислах өөр бусад арга замуудыг эрж хайхыг умартан, адислалын ганцхан онцгой хэлбэр дээр хамаг анхаарлаа чиглүүлсэн байлаа. Эцэстээ, Их Эзэн манай бүс дэх номлолын ажлыг бидний хүсэн хүлээгээгүй, гайхалтай арга замаар адисалж эхэлсэн юм. Бид захиасаа хүлээн авах хүсэлтэй хүмүүсийг олсон ч өөрийнхөө амжилтыг бусдын сонголтуудаар хэмжих ёсгүйг би тэр үед ойлгосон юм.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) номлолын ажлын тухай: “Чадах бүхнээ хамгийн сайнаар, бүр хамгийн сайнаар хий. Залбирлаа хэлж, шаргуу ажилла, тэгээд ургацыг Их Эзэнд үлдээ” гэж хэлсэн номлолын нэгэн ерөнхийлөгчийн зөвлөгөөг хуваалцжээ.⁵ *Миний сайн мэдээг номло* удирдамж амжилттай номлогчдын тухай “Бодгалиудыг



Олон талаар, номлогчийн хувьд миний номлолын амжилтыг миний наманчлах хүсэл, ажлаа үргэлжлүүлэх шийдвэрээр хэмжин дүгнэж болно.

Христэд авчрахын тулд чадах бүхнээ хамгийн сайнаар хий, тэгээд суралцаж, төгөлдөржихийг чин сэтгэлээсээ эрэлхийл” гэсэнтэй адил үгийг хэлсэн байдаг.⁶

Би наманчлах хүсэлтэй байхын хэрээр, би хамгийн сайнаараа хийсэн гэж Их Эзэний өмнө чин шударгаар хариуцлага хүлээхийн хэрээр хүмүүс бидний захиасыг хүлээн авсан эсэхээс үл хамааран би амжилттай номлогч байж чадсан гэдэгтээ өөртөө итгэлтэй байж болно. Олон талаар, номлогчийн хувьд миний номлолын амжилтыг миний наманчлах хүсэл, ажлаа үргэлжлүүлэх шийдвэрээр хэмжин дүгнэж болно.

Би номлолынхоо энэ үеэс эхлэн олон гайхамшигийг өдрийн тэмдэглэлдээ бичсэн. Би илүү их итгэлтэй, талархалтай байхыг хичээснээр илүү сайн төлөвлөгөөтэй болж, сэтгэлээр унахаас зайлсхийн, Сүнснийг ажилдаа илүү ихээр мэдэрсэн билээ. Би

Миний сайн мэдээг номло удирдамжид заадаг “Та чадах бүхнээ хийсэн үед ч гэсэн санаагаар унах явдал тохиолдож болно, харин өөртөө гутрах явдал тохиолдохгүй” гэсэн зүйл үнэн гэдгийг олж мэдсэн. Сүнс өөрөөр тань дамжуулан ажиллаж байгааг мэдэрсэн үед та Их Эзэн баяртай байгааг бас мэдэрч чадна.⁷ Ингээд Их Эзэн надтай хамт байгааг мэдэрсэн үед би аливаа хүнд сорилтыг хүлцэн тэвчиж чаддаг болсон юм. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Мэинд амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. *Миний Сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамж* (2004), 10–11-ийг үзнэ үү.
2. *Миний сайн мэдээг номло*, 10.
3. *Миний сайн мэдээг номло*, 10.
4. Жэффри Р.Холланд, “Талбайд хөдөлмөрлөгсөд,” *Лиахона*, 2012 оны 5-р сар, 31.
5. Гордон Б.Хинкли, “Find the Lambs, Feed the Sheep,” *Liahona*, 1999 оны 7-р сар, 120.
6. *Миний сайн мэдээг номло*, 11.
7. *Миний сайн мэдээг номло*, 11.

ТУРШЛАГАА ХУВААЛЦАНА УУ

“Би номлолоосоо саяхан буцаж ирсэн. Гэтэл би тодорхой зорилгогүй болсон юм шиг санагдах юм. Би юу хийх ёстой вэ?”

Эргэж ирсэн номлогчид оо, та нар номлолоосоо гэртээ ирж мөн сургууль, ажил эсвэл бусад үйл ажиллагаануудад хэрхэн шилжсэн талаараа бидэнтэй хуваалцана уу. Хуваалцах туршлагаа liahona@ldschurch.org э-мэйл хаягаар эсвэл онлайнаар liahona.lds.org-д ирүүлнэ үү. Овог нэр, төрсөн огноо, тойрог эсвэл салбарын нэрийг бичнэ үү.



Миний сайн мэдээг номло удирдамжийг дагадаг номлогч болох нь



Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
Ахлагч
Дэвид А.Бэднар

*Та нар үүнийг хийж чадна!
Та нарын төлөөлж, Түүнд
үйлчилдэг Их Эзэн энэ ажлыг
та нар хийж чадна гэдгийг
мэддэг. Та нар үүнийг хийж
чадна гэдгийг би мэднэ.*

Төлөөлөгч бол ямагт энэ ажлын тэргүүн эгнээнд явдаг байнгын номлогч юм. Энэхүү шаалтаа-наар би хожмын үеийн энэхүү гай-хамшигт ажлын үйлчлэгч нөхдөдөө хандан үг хэлж байгаадаа туйлын баяртай байна.

**МИНИЙ САЙН МЭДЭЭГ НОМЛО
УДИРДАМЖИЙГ ДАГАДАГ
НОМЛОГЧ ГЭЖ ХЭН БЭ?**

Миний сайн мэдээг номлодог номлогч бол Аврагчийн үүрдийн сэргээгдсэн сайн мэдээг Түүний арга замаар тунхагладаг хүмүү-сийн бошиглол ба гар тавилтаар дуудагддаг Их Эзэний үйлчлэгч юм (С ба Г 50:13–14, 17–24;

С ба Г 68:1-ийг үзнэ үү).

Миний сайн мэдээг номло удир-дамжид дүрслэгдсэн номлогчийн олон талт зорилго бол “Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх итгэл, наманчлал, баптисм ба Ариун Сүнсний бэлэг хүлээн авах болон эцсийг хүртэл тэвчихэд бусдад тус-лах замаар тэднийг Христэд ирэхэд урих” явдал юм.¹

Сайн мэдээг эрх мэдэлтэйгээр тунхаглах болон авралын ёслолуудыг гүйцэтгэх ариун үүрэг хариуц-лагыг Адам Едений Цэцэрлэгээс хөөгдсөнөөс хойш хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд “Агуу Иехова ажил хийгдэж дууслаа” гэж хэлэх хүртэл үргэлжлэх болно.²

МИНИЙ САЙН МЭДЭЭГ НОМЛОХ НОМЛОГЧ БОЛОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Миний сайн мэдээг номлох
номлогчид болоход тавигдах үндсэн
таван шаардлагын тухай би ярья.

Шаардлага 1: Миний сайн мэдээг номлох номлогчид Есүс Христэд үйлчилж, Түүнийг төлөөлдгөө ойлгодог.

Миний сайн мэдээг номлох
номлогчид хэнийг төлөөлдгөө,
яагаад үйлчлэх ёстойгоо бас юу
хийх ёстойгоо мэддэг, ойлгодог.
Бүрэн цагийн номлогчид үйлч-
лэхээр дуудагдагдахдаа Их Эзэн
Есүс Христийн үйлчлэгч, төлөө-
лөгчөөр зохих журмын дагуу адис-
лагддаг. Бид Есүс Христийн үнэн
бодит байдал, бурханлаг чанар,
үүрэг зорилгын тухай бүх үндэс-
тэн, ястан, хэлтэн болон хүмүүст
Түүний нэрээр гэрчилдэг билээ
(С ба Г 133:37-г үзнэ үү).

Бид Их Эзэнийг хайрладаг. Бид
Түүнд үйлчилдэг. Бид Түүнийг дага-
даг. Бид Түүнийг төлөөлдөг.

Түүний зорилгууд бидний зо-
рилгууд байх ёстой. Түүний санаа
тавьдаг зүйлс бидний санаа тавьдаг
зүйлс байх ёстой. Түүний ажил бид-
ний ажил байх ёстой. Түүний арга
замууд бидний арга замууд байх
ёстой. Түүний хүсэл бидний хүсэл
болох нь улам ихсэх ёстой.

Бид Гэтэлгэгчийн төлөөлөгчдийн
хувьд Түүний сэргээгдсэн сайн
мэдээний тулгуур сургаал болон
зарчмуудыг энгийн бөгөөд тодор-
хойгоор номлодог. Бид хувийн
санаа бодол эсвэл хувийн үзэл ба-
римтлаалыг төлөөлдөггүй. Бид сэр-
гээгдсэн энгийн үнэнийг Их Эзэний
арга замаар Түүний Сүнсний хүчээр
тунхаглан, гэрчилдэг.



Миний сайн мэдээг номлох
номлогчид Аврагчийг төлөөлөх
болон Түүний тухай гэрчлэх үүрэг
хариуцлага нь хэзээ ч төгсөхгүй гэд-
гийг ойлгодог билээ. Та боддог бүх
зүйлдээ, хийдэг бүх зүйлдээ, өөрөө
ямар хүн болохоор хичээдэг тэр бүх
зүйлдээ Тэнгэрлэг Эцэгийг санаж,
одоо болон хойшид үргэлж харил-
цаатай байх Түүний бүх хүүхдүү-
дэд Түүнийг зохих ёсоор төлөөлөх
болно гэдгээ санагтун.

Шаардлага 2: Миний сайн мэдээг номлох номлогчид бол зохистой хүмүүс юм.

Миний сайн мэдээг номлох
номлогчид болох зайлшгүй чухал

урьдчилсан нөхцөл бол тэд Авраг-
чийн өмнө зохистой байх явдал мөн.

Энгийн хэдэн үнэнийг өөрийнхөө
мэдэхээр тодорхой тайлбарлахыг
надад зөвшөөрнө үү.

- Бид бол дэлхийн Гэтэлгэгч болон Аврагчийн эрх мэдэл олгогдсон төлөөлөгчид билээ.
- Бид бол Түүний сэргээгдсэн үүр-
дийн сайн мэдээг тунхаглахаар
дуудагдсан хүмүүс.
- Бид дэлхийн зүйлээр бохирлог-
дож болохгүй, харин Түүнийг эрх
мэдэлтэйгээр төлөөлж, Түүний
ариун нэрээр хүч болоод эрх
мэдэлтэйгээр үйлддэг билээ.
- Хэрэв бид өөрсдөө нүгэлд ороо-
цолдох юм бол, нүглийн боолч-
лолыг ялахад нь бусдад тусалж
чадахгүй (С ба Г 88:86-г үзнэ үү).
- Хэрэв бид өөрсдөө зохих ёсоор,
бүрэн дүүрэн наманчилж сураа-
гүй бол наманчилж сурахад нь
бусдад тусалж чадахгүй.
- Бид гагцхүү зохистой байсан цагт
л хүчтэйгээр зааж, номлож чадна.
- Бид зөв шударга хүсэл бодол,
Бурханы төлөөлөгчийн хувьд
үйлдэх зохистой байдлынхаа
талаар Түүний өмнө хариуцлага
хүлээх болно.

Биднээс эдүгээ төгс болсон бай-
хыг шаарддаггүй. Гэвч Израилын
Гэтэлгэгчийн өмнө цэвэр ариун
байж, цэх шулуун алхахыг бидэнд
зарлиг болгосон билээ. “Их Эзэний
сав тээгчид та нар цэвэр ариун
байгтун” (С ба Г 38:42).

Наманчлал бол цөхрөл гутралын
биш харин итгэл найдвар, эдгэр-
рэлтийн зарчим мөн. Наманчлал
бол айдсын биш харин өөрийгөө
даруусгах зарчим мөн. Наманчлал
нь байнгын өндөр шаардлагатай,

тайтгаруулагч, хатуу чанд бөгөөд илааршуулагч үйл явц юм. Наманчлал бол бидний хайрлаж, үйлчлэн дагадаг Их Эзэний Цагаатгалаар боломжтой болсон үнэлж баршгүй бэлэг юм.

Та ноцтой нүгэл үйлдсэн ч Есүс Христийн Цагаатгал болон чин сэтгэлийн наманчлалаар дамжуулан дахин цэвэр ариун бөгөөд зохистой болж чадна.

Бүрэн наманчлах хэрэгтэй өсвөр үеийнхэн байгаа. Наманчлах цаг нь одоо юм. Наманчлах өдрөө бүү хойшлуул, бүү хойшлуул, хэзээ ч бүү хойшлуул.

Наманчилсан, наманчлахаа үргэлжлүүлж байгаа бөгөөд Их Эзэнээр хүлээн зөвшөөрөгдөхийн тулд шаардлагатай бүх зүйлийг хийсэн эсэхээ мэдэхгүй байгаа залуучууд бий (С ба Г 97:8-ыг үзнэ үү). Их Эзэн та нарыг төгс байхыг биш, харин цэвэр ариун бай хэмээн шаарддагийг санагтун. Ариун Сүнс таны амьдралд



дахин ажилаж эхлэх нь Их Эзэн таныг уучилсны хамгийн баттай нотолгоо юм. Учир нь “Их Эзэний Сүнс ариун бус дугануудад үл оршдог” (Хиламан 4:24). “Бүх хүмүүнийг уучлах” (С ба Г 64:10) зарлигт өөрийгөө уучлах нь багтдагийг санагтун.

Миний сайн мэдээг номлох номлогчид бол гэрээнүүддээ хүндэтгэлтэй ханддаг, зарлигуудыг дуулгавартай сахидаг, Их Эзэн Есүс Христийн дагалдагчид юм. Түүнийг үргэлж санаж, Түүнийг төлөөлөхийн тулд цэвэр ариун бөгөөд зохистой байхыг үргэлж санаж яв.

Шаардлага 3: Миний сайн мэдээг номлох номлогчид мөнх амьдралын үгсийг эрхэмлэн дээдэлдэг.

Би та бүхнийг “амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцлөхийг” (С ба Г 84:85) урьж байна. Мөнх амьдралын үгсийг эрхэмлэн дээдлэх нь өнгөц суралцаж, цээжилж, хөнгөн хуумгай судлахаас илүү чухал бөгөөд зөвхөн “Христийн үгс дээр найрлах,” (2 Нифай 31:20; мөн 2 Нифай 32:3-ыг үзнэ үү) явдал юм. Эрхэмлэн дээдлэх гэдэг нь миний хувьд анхаарал төвлөрүүлж ажиллах, шимтэн судлах, тунгаан бодож, залбирах, сурсан зүйлээ амьдралд хэрэгжүүлж, дээдлэн үнэлэх, түүнээсээ баяр баясал, таашаалыг олох явдал мөн.

Аммон, Аарон, Омнер, Химнай хэмээх Мозаягийн дөрвөн хөвгүүн хэрхэн дөрвүүлээ гайхамшигтай номлогчид болж хэрхэн “үнэний мэдэлт хүчтэй болсныг санагтун; учир нь тэд судруудыг хичээнгүйлэн судалсан байв” (Алма 17:2).

Эдгээр итгэлтэй номлогчид мөнх амьдралын үгсийг үнэхээр үргэлж эрхэмлэн дээдэлдэг байв. Тэд хувиараа болон хамтдаа судар судлах явдлыг үл тоомсорлож, үүрэг хариуцлагадаа хөнгөн хуумгай ханддаггүй байлаа. Сүнслэг мэдлэг ба ойлголт тэдний бодгальд гүнзгий нэвтэрч, Ариун Сүнсний хүчээр сайн мэдээний сургаалууд болон зарчмууд тэдний зүрх сэтгэлд бат бөх шингэжээ.

Та бид Аврагчийн төлөөлөгчдийн хувьд шаргуу ажилаж, сэргээгдсэн сайн мэдээний, ялангуяа Мормоны Номын сургаалууд болон тулгуур зарчмуудыг зүрх сэтгэл, оюун ухаандаа шингээн төлөвшүүлэх байнгын үүрэг хариуцлагатай билээ. Бид ингэснээр Ариун Сүнс “бүх зүйлийг [бидэнд] сануулах болно” (Иохан 14:26) мөн бидэнд заах болон гэрчлэх хүчийг өгөх болно гэсэн амагдсан адислалыг хүлээн авах болно. Гэвч бид Сүнсэнд ажиллах боломжийг бүрдүүлж өгсөн үед л Тэр бидэнтэй хамт байж биднээр дамжуулан ажиллах болно. Бидний сураагүй юмсыг



санахад Тэр бидэнд тусалж чадахгүй шүү дээ (Алма 31:5-ыг үзнэ үү).

Миний сайн мэдээг номлох номлогчид мөнх амьдралын үгсийг байнга эрхэмлэн дээдэлж, үгийн нөлөөлөх хүчинд найдвар тавьдаг. Иймээс тэдний үг хүчтэй байдаг билээ. Түүнийг үргэлж санагтун, Түүнийг төлөөлөхийн тулд үргэлж зохистой байж, үгийн хүчийг эрхэмлэн дээдэлж, түүнд найдвар тавь.

Шаардлага 4: Миний сайн мэдээг номлодог номлогчид Ариун Сүнс бол жинхэнэ төгс багш гэдгийг ойлгодог.

Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүн бөгөөд Тэр бол бүх үнэнийг гэрчлэгч, жинхэнэ төгс багш юм. Бидний заадаг хичээлүүд болон хуваалцдаг гэрчлэлүүд сонирхогчийн хувьд өөрөө үйлдэх, өөрөө суралцахад нь бэлтгэл болдог.

Номлогчид бидний хамгийн чухал нэг үүрэг бол сонирхогчдыг ёс суртахууны сонгох эрхээ ашиглах болон Аврагчийн сургаалуудын дагуу үйлдэхэд урих явдал мөн. Үнэний гэрчлэл хүлээж авахын төлөө Мормоны Номын талаар залбирч судлах, Сүмийн цуглаануудад оролцох, зарлигуудыг сахих зэрэг сүнслэг үүргүүдийг авч, сахих нь итгэлээ ашиглан, үйлдэж, өөрчлөгдөхийг сонирхогчоос шаарддаг.

Бид хэчнээн чин сэтгэлээсээ үйлчилээ ч гэсэн сонирхогчдын зүрх сэтгэлд үнэнийг хүчээр оруулж чадахгүй. Бид чадах бүхнээ хамгийн сайн хийж, хичээн чармайсан үед үнэний захиасыг хүмүүсийн *зүрх сэтгэлд* хүргэж чадна (2 Нифай 33:1-ийг үзнэ үү). Чухамдаа, сонирхогч зөв шударга байдалд үйлдэх хэрэгтэй, тэр үүгээрээ үнэнийг *зүрх сэтгэлдээ* урьдаг. Зөвхөн энэ арга

замаар л үнэний шударга эрэлчид болон жинэ хөрвөгчид асуултуудын хариуг өөрөө олох сүнсний хүч чадлыг хөгжүүлж чадна.

Сонирхогчдод итгэлээр болон Ариун Сүнсний хүчээр суралцахад туслах нь бидний үүрэг учраас энэ ажил хэзээ ч миний тухай эсвэл таны тухай байдаггүй. Бид номлогчийн үүргээ биелүүлэхийн хамт, Өөрийн эрхэм ажил үүргээ гүйцэтгэхэд нь Ариун Сүнсэнд саад болохгүйн тулд чадах бүхнээ хийх хэрэгтэй. Чухамдаа, Аврагчийн төлөөлөгчдийн хувьд бид зааж байгаа захиас, ашиглаж байгаа заах арга, эсвэл биеэ авч яваа байдал, гадаад үзэмж гэх мэт бид хийдэг аливаа зүйлдээ, бусдын анхаарлыг зориуд, санаатайгаар өөртөө татдаг бол энэ нь Ариун Сүнсийг үр дүнтэй заахад саад учруулдаг, санваарыг урвуулан ашиглаж байгаа нэг хэлбэр юм.

“Тэрээр үнэнийг Сүнсээр номлох уу эсвэл ямар нэг өөр арга зам бий

юү? “Хэрэв энэ нь ямар нэг өөр замаар болбоос энэ нь Бурханаас бус болой” (С ба Г 50:17–18).

Түүнийг үргэлж санагтун; Түүнийг төлөөлөхийн тулд зохистой байгтун; Түүний үгийг эрхэмлэн дээдэл; жинхэнэ төгс багш Ариун Сүнсэнд бүх үнэнийг гэрчлэх боломжийг олго.

Шаардлага 5: Миний сайн мэдээг номлодог номлогчид багшлах нь зүгээр нэг ярьж, хэлэхээс илүү чухал зүйл гэдгийг ойлгодог.

Аврагч Чидун Уулан дээр сууж байхдаа: “Юу хэлэх тухайд урьдаас бүү санаа зов. Харин тэр цагт та нарт юу өгөгдөнө, түүнийг хэл. Яагаад гэвэл яригч нь та нар биш, харин Ариун Сүнс юм” (Марк 13:11) хэмээн заасан билээ.

Аврагч энэ эрин үеийн эхний өдрүүдэд номлогчдыг “амаа нээгтүн, мөн тэдгээр нь дүүргэгдэх болно” (С ба Г 33:8, 10), “энэ хүмүүст дуу



хоолойгоо өргөгтүн; зүрх сэтгэлд тань миний тавих бодлуудыг яригтун, мөн та нар хүмүүсийн өмнө мадлагдах нь үгүй; Учир нь тиймээ, та нар юу хэлэх ёстой нь яг тухайн цагт та нарт өгөгдөх болно” (С ба Г 100:5–6) гэж зааварласан юм.

Эдгээр судрууд нь сонирхогчдод үнэнийг сурахад нь тусалж, номлоход зориулсан хамгийн хэцүү бас тодорхой загварыг онцолсон.

Миний сайн мэдээг номлодог номлогчид бид зөвхөн хичээл заадаггүй, харин хүмүүст заадгийг мэддэг. Бид сайн мэдээний сэдвүүдийн талаар цээжилсэн захиасуудаа эш татаж заадаггүй. Харин бид үнэнийг эрэлхийлэгчдийг зүрх сэтгэлийн хүчтэй өөрчлөлтийг мэдрэхэд урьдаг. Бид зөвхөн хэлж ярьснаар заадаггүй гэдгийг ойлгодог.

Сайн мэдээг Их Эзэний арга замаар номлоход ажиглах, сонсох, ялган таних нь ярихын өмнө угтвар нөхцөлүүд болдог. Энэхүү хоорондоо холбоотой дөрвөн үйл явцын дэс дараалал чухал юм. Ялган танихын өмнө идэвхтэй ажиглах, анхааралтай сонсдог бол ярихын өмнө ажиглах, сонсох, ялган таних үйлдэл хийгддэгийг ажиглагтун. Энэхүү загварыг ашиглах нь сонирхогчдын хэрэгцээг мэдэж, тэдэнд заах боломжийг номлогчдод олгодог билээ.

Бид ажиглаж, сонсон, ялган таньсан үед “хүн болгонд хэмжигдэх тэрхүү хэсэг нь яг тэр цагт” (С ба Г 84:85) аль нэг сонирхогчийн онцгой хэрэгцээг тогтооход чухалчлан авч үзэх үнэнүүд болоод өгөх хариултауд бидэнд өгөгдөх болно. Бид гагцхүү ажиглаж, сонсон, ялган таньснаар үйлчилдэг хүмүүстээ хамгийн ашиг тустай зүйлсийг хэлэх мөн хийхэд Сүнсээр удирдагдах болно.



Ажиглах нь ялган таних сүнсний бэлгийг хүлээн авахад нэн чухал бэлтгэл болдог. Ялган таних нь өөр хүний хуурмаг санаа бодол, нинжин сэтгэл эсвэл сонирхогчид туслахад хэрэгтэй дараачийн зарчмыг сүнсний мэлмийгээр харахын *хамт* зүрхээр мэдрэх явдал юм. Ялган таних нь тайлбар буюу асуултан дахь үгээр илэрхийлээгүй санааг, эсвэл гэрчлэл болон сургаал үнэн эсэхийг мөн Ариун Сүнсний хүчээр ирдэг итгэлтэй байдал ба амар амгаланг сүнсний чихээр сонсохын *хамт* зүрх сэтгэлээрээ мэдрэн сонсох явдал мөн.

Миний сайн мэдээг номлох номлогчид итгэлээр үйлдэж, үнэнийг мэдэхэд нь сонирхогчдод туслахын тулд Сүнсээр удирдуулдаг. Түүнийг үргэлж санагтун; Түүнийг төлөөлөхийн тулд зохистой байгтун; Түүний үгийг эрхэмлэн дээдэл; Ариун Сүнсэнд бүх үнэнийг гэрчлэх боломжийг олго; үнэнийг эрэлхийлэгч шударга хүмүүст Есүс Христийн тухай гэрчлэхдээ ажиглаж, анхааралтай сонсож, ялган тань.

ТА НАР ҮҮНИЙГ ХИЙЖ ЧАДНА!

Та нар миний захиасыг уншаад бусад өсвөр үеийнхэн миний ярьсан зүйлийг хийж чадна бас хийх болно гэдэгт итгэх болно. Гэвч та нар үүнийг хийж чадах болов уу хэмээн

эргэлзэж мэднэ. Сонсогтун. Та нар үүнийг хийж чадна!

Та нарын хүн нэг бүртэй хэдэн хормыг ч болов хамт өнгөрүүлэх зүрхний минь хүсэл гүйцэлдэх болоосой. Би та нарын гарыг барьж, та нарыг өөр рүүгээ ойртуулан, нүд рүү тань харж байгаад “Та нар үүнийг хийж чадна!” гэж хэлэхсэн. Та нарын төлөөлж, Түүнд үйлчилдэг Их Эзэн та нар үүнийг хийж чадна гэдгийг мэддэг. Үүнийг та нар хийж чадна гэдгийг би мэдэж байна. Би Түүний үйлчлэгчийн хувьд та нар Түүнээс тусламж хүлээн авах болно гэдгийг амлаж байна. Та нар Түүний тусламжтайгаар, Түүний хүч чадлаар үүнийг хийж чадна гэдгээ үргэлж санагтун!”

Би та нарт хайртай. Та нарын болох ёстой тийм хүмүүс болохоор хичээсэн үед Их Эзэний дуу хоолой болон удирдамжийг таньж, итгэлээр хариулдаг болохын төлөө би залбирч байна. Тэгвэл та нар Их Эзэн Есүс Христийн үнэхээр хүчирхэг, үр өгөөжтэй төлөөлөгчид байх болно. ■

Прово дахь Номлогчдыг бэлтгэх төв дээр 2011 оны 6-р сарын 24-нд болсон онцгой цугларалт дээр хэлсэн үгээс

ЭШЛЭЛҮҮД

1. *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамж* (2004), 1.
2. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 142.

ЗҮГЭЭР Л ИНЭЭМСЭГЛЭЭД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛ

Хэйл Мэри Тайбул

Би нэг зун Филиппиний Байкол дахь нэг арал дээр дадлага хийсэн юм. Далайн үзэсгэлэнт байдал гайхамшигтай сайхан байснаас би өглөө бүр далайг ширтэн зогсдог байлаа.

Харин орой болохоор айдаг байв. Учир нь буудал дахь хүмүүс архидан, үдэшлэг хийдэг байлаа. Дадлага хийж байсан биднийг иймэрхүү үдэшлэгүүдэд олон удаа урьсан. Үдэшлэгт оролцохгүй байх нь тэдэнд хүндэтгэлгүй хандсан болох учир бид үдэшлэгт нь оролцох ёстой байв.

Анхны үдэшлэг нь шинэ дадлага хийж байгаа хүмүүст баяр хүргэх үдэшлэг байлаа. Би үдэшлэгт оролцохоос айж байлаа. Учир нь тэд надад архи уухыг санал болгох нь бараг ойлгомжтой байсан бөгөөд би хэрхэн татгалзахаа сайн мэдэхгүй байлаа. Би тойргийнхоо нэг найз руу утасдсан бөгөөд тэр миний итгэлийг нэмэгдүүлсэн гайхамшигтай сайхан зөвлөгөө өгсөн юм.

Үдэшлэг эхлэхэд тэд надад архи уухыг санал болгосон ч аз болоход шахсангүй. Хамт дадлага хийж байсан нөхөд маань архи уухгүй байх миний шийдвэрийг зөвшөөрсөн учир тэр шөнийн хувьд архи уух дараачийн саналуудаас татгалзах нь амар байлаа. Дараа нь өөр нэгэн үдэшлэгийн үеэр компаний ерөнхийлөгч ирсэн юм. Тэр нэг шил ламбаног (наргилын

самраар хийдэг тэр нутгийн дарс) авчрав. Тэр орж ирээд удалгүй дарс аягалж байхыг би харав. Тэгээд тэр “Та нар архи ууж сурах хэрэгтэй” гэж хэлээд дадлага хийгчдийн нэгэнд аягатай дарсыг өгөв. Тэр эмэгтэй дарсыг тэр дор нь уучихав.

Миний зүрх хүчтэй цохилж эхлэв. Удахгүй миний ээлж болно. “Би ууж болохгүй. Би ууж болохгүй” гэж амандаа шивнэлээ. Тэгтэл

*Би архи уух саналаас
татгалздаг байсан, гэтэл
компаний ерөнхийлөгч ганц
аяга дарс уухыг надад
санал болгов.*

ерөнхийлөгч надад аягатай дарс өгч байгааг би харлаа. Би юу хийхээ мэдэхгүй байв. Хамт дадлага хийж байсан нөхөд маань миний юу хийхийг хүлээн харж байлаа. Би ерөнхийлөгч рүү инээмсэглэн, “Уучлаарай, эрхэм ээ, би архи уудаггүй” гэж даруухнаар хэллээ.

Түүний урам хугарна гэдгийг би мэдэж байв. Тэр надаас яагаад архи уудаггүйг асуухад “Би Мормон хүн” гэж хариулав.

“Би ийм шашны тухай сонсоогүй юм байна. Харин хоол хүнсний нэг төрөл юм шиг сонсогдлоо” гэж түүнийг хэлэхэд бүтд инээлдэв.

Би ч бас инээв, гэхдээ түүнийг хошигносонд биш, харин би зөв зүйл хийснээ мэдэж байсан болохоор инээсэн юм.

Архи уухыг хэн ч надад дахин санал болгосонгүй. Гэвч найз нар минь хүртэл намайг шоолсон хэвээр байлаа. Тэр байтугай нэг хүн надад сүмийн гишүүд архи уудаггүй гэж төсөөлөгдөхгүй байгаа болохоор намайг худал хэлж байна гэж хэлсэн юм. Тэр үед би сүмийн гишүүдэд тохиолддог дарамт шахалтуудыг мэдэрсэн юм.

Тэр арал дээр дадлага хийсэн нь зөвхөн эрдэм мэдлэгийн талаар төдийгүй бас сүнслэг байдлын хувьд надад олон сургамж өгсөн юм. Элэглэн тохуурхах нь хэзээ ч зогсохгүй байж болох ч Их Эзэний Сүнс намайг үргэлж зөвийг хийхэд удирдах болно гэдгийг би мэдсэн юм. ■

Энэ өгүүллийг бичигч Филиппиний Метро Манилад амьдардаг.





Далын
Ахлагч
Адриан Очоа

Бие махбод, сэтгэл санааны хувьд өөртөө итгэлтэй байхыг хүсдэг үү? Байнгын дасгал туслах болно.

ХҮЧ ЧАДАЛТАЙ, ЭРҮҮЛ ЧИЙРЭГ, УХААЛАГ БАЙ

Би саяхан дасгалын талаар нэгэн сонирхолтой зүйл уншсан юм. Хэрэв та өглөө эрт босч, бэлтгэлийн хувцсаа өмсөөд “Би энэ хувцсаа өмсчихөөд, явган явахаар гадаа гарахад санаа сэтгэл сайхан байвал одоо гүйдэг хэрэг ээ” гэж боддог бол үүнийг ойлгохоосоо ч өмнө сайн дасгал хийж байна гэсэн үг юм. Үүнтэй адилхан энгийн санааг хэрэгжүүлэх нь дасгал хийх сайн хэвшлийг хөгжүүлж, бие бялдартаа анхаарал тавихад тань тусалж чадна. Олон хүний хувьд аливаа зүйлийг эхэлж, түүнийгээ байнгын хэвшил болгох нь хамгийн хэцүү байдаг. Хэрэв дасгал зөвхөн таны биеийг төдийгүй бас сэтгэл санаа, оюун ухааныг адисална гэдгийг санах юм бол энэ нь бие бялдраа улам чийрэгжүүлэх хүсэлтэй болоход тань туслах болно. Та тогтмол дасгал хийснээр хүчтэй, өөртөө итгэлтэй, эрүүл чийрэг, эрч хүчтэй, эрүүл хүн болно.

Өдөө чийгийн улаан хорхойгоор наймаалсан нэгэн шувууны тухай түүхийг би санаж байна. Ийм замаар хоолоо олж идэх нь амар байсан бөгөөд тэр шувуу үй олон өдтэй гэж боддог байжээ. Сайхь шувуу өглөө эрт босч чийгийн хорхой ангуучлахгүй болсондоо баярлан өдөө наймаалахаа үргэлжлүүлсээр байв. Тэргэнц удаа ч болов хөдлөлгүй, өдөржингөө үүрэндээ суусаар байлаа.

Сайхь шувуу үүндээ бүр дасчихсан байв. Гэвч амин чухал өднүүд нь дууссан учраас нисч чадахгүй болсноо тэр эцэстээ ойлгожээ.

Ийм явдал муу зуршил, залхуурал, донтуулагч бодисуудад урхидуулсан хэнд ч гэсэн тохиолдож болно. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос бид эдгээр зүйлс “таны бие бялдар, сэтгэл, сэтгэл санаа болон сүнсний сайн сайхан байдалд хор хөнөөл учруулдаг тухай уншдаг. Тэдгээр нь таны гэр бүл, найз нөхөдтэйгээ харилцах харилцаанд муугаар нөлөөлж, өөрийгөө үнэлэх мэдрэмжийг сулруулдаг. Тэдгээр нь өөрсдийнхөө төлөө зөв сонголт хийх чадварыг тань хязгаарладаг.”¹ Идэвхтэй байж, зөв хооллох нь дээрх муу зуршлуудаас зайлсхийхэд бидэнд тусалдаг. Хэрэв сайхь шувуу нисч, чийгийн хорхойгоо ангуучилсаар байсан бол хэзээ ч өдгүй болохгүй байсан. Үүнтэй адил хэрэв бид “булчингаа ажиллуулж” тогтмол дасгал хийдэг байвал бидэнд хор хохирол учруулж, доройтуулдаг зүйлсээс зайлсхийх чадварыг өөртөө хөгжүүлнэ.

Зарим хүмүүс бие махбодын эрүүл мэндийн асуудалтайгаа тэмцэж байхад бусад хүмүүс сэтгэл санааны эрүүл мэндийн асуудалтай тэмцдэг. Амьдрал хүнд хэцүү байж болно. Зарим үед бидэнд айж

түгших, сэтгэлээр унах, өөрийгөө чамлах мэдрэмж төрж болно. Гэвч биеийн болон сэтгэл санааны эрүүл мэндийн хувьд дасгал хөдөлгөөн болон биеийн хүчний хөдөлмөр нь эерэг үзэл бодолтой байхад тусалдаг. Бие махбоддоо анхаарал тавих нь бас таны оюун ухааныг адисалж, өөрийгөө Бурханы хүүхэд гэдгээ санаж, өөртөө итгэлтэй, аз жаргалтай байхад тань туслах болно. Бидний сэтгэл санаа, бие махбод болон сүнслэг байдал бүгд хоорондоо холбоотой юм. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд заасан нь: “Та нарын сэтгэл санааны эрүүл мэнд бас чухал бөгөөд таны сүнсний болон бие махбодын сайн сайхан байдалд нөлөөлдөг. Сэтгэл дундуур эсвэл гунигтай байх нь энэхүү мөнх бус амьдралын нэг хэсэг юм. Гэсэн хэдий ч хэрэв та нар удаан хугацааны турш гунигтай, итгэл найдваргүй, түгшсэн, сэтгэл санаагаар унасан бол эцэг эх болон бишоптойгоо ярилцаж тусламж хүсээрэй.”²

Бидний эргэн тойронд яагаад их эрч хүчтэй, баяр баясгалантай хүмүүс байдаг вэ? Нэг гол шалтгаан нь зуршил юм. Хэрэв бид бие махбоддоо сүнслэг үзэл бодлоос авч үзэн, “хүний бие бол Бурханы бэлэг бөгөөд ариун сүм” гэдгийг ойлгох юм бол бид бие махбоддоо хайрлаж, ариунаар нь авч явах болно.³

Миний хувьд *ариун* гэдэг нь цэвэр, тэжээн тэтгэгддэг, хүч чадалтай гэсэн утгатай юм. Бидэнд бие махбодоо ариун байлгахад Тэнгэрлэг Эцэгийн тусалдаг арга замуудын нэг нь Мэргэн Ухааны Үгийг бидэнд өгсөн явдал юм. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд: “Та нар [Мэргэн Ухааны Үгэнд] дуулгавартай байснаараа хортой донтолтуудаас ангид байж амьдралаа хянаж чадна хэмээн тайлбарлажээ. Та эрүүл бие, саруул ухаан, Ариун Сүнсний удирдамж зэрэг адислалуудыг хүлээн авна. Та Их Эзэнд үйлчлэхэд бэлтгэгдэх болно. Мэргэн Ухааны Үгийг зөрчсөнөөр та илүү аз жаргалтай, нэр хүндтэй, бусдын анхаарлыг илүү ихээр татах болно хэмээн танд бодогдуулах Сатан эсвэл бусад хүмүүст бүү хуурт.”⁴ Та Мэргэн Ухааны Үгийг дагаснаар “мэргэн ухаан хийгээд мэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг олж авах” (С ба Г 89:19) боломжийг өөрт тань


олгох бие махбод, оюун ухаандаа аль алинд нь анхаарал тавьж байгаа гэдгээ санагтун.

Өдөө худалдаж дууссан залхуу шувуу шиг байхын оронд бэлтгэлийн хувцсаа өмсөөд, дасгалаа идэвхтэй хий. Дасгал тогтмол хий. Дуртай спортынхоо клубт элс эсвэл хамт гүйдэг эсвэл амралт чөлөөт цагийн бусад үйл ажиллагаануудад хамт оролцдог найз нөхөдтэй бол. Та бие бялдраа хөгжүүлэх зүйлсийг хийснээр зөвхөн бие махбодоо төдийгүй бас оюун ухаанаа дасгалжуулдаг. Дасгал нь бас сэтгэл санааны эрүүл мэндийг бэхжүүлдэг. Хамгийн чухал зүйл бол та хэр зэрэг түргэн гүйдэг эсвэл хэр зэрэг сайн тамирчин бэ гэдэг нь биш, харин дасгалыг тогтмол хийдэг байх явдал мөн. Та тогтмол дасгал хийснээр зөвхөн аз жаргалтай байх төдийгүй улам их хүч чадалтай, эрүүл чийрэг, ухаалаг болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (товхимол, 2011), 27.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 27.
3. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 25.
4. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 25.

Өдөө чийгийн хорхойнуудаар худалдсан залхуу шувуу шиг бүү бай.





ТҮҮНИЙ Замыг ДАГА

Аврагчтай адилхан болох нь алгуураар
хэрэгжих насан туршийн үйл явц
бөгөөд та өдөр бүр жижиг
алхмуудаар эхлэх хэрэгтэй.

Мэлиса Зэнтэно

Сүмийн сэтгүүлүүд

Судрууд биднийг Есүс Христтэй адилхан болж, “Түүний хэрхэн явсанчлан өөрөө бас тийн явдаг” (1 Иохан 2:6) байхад урамшуулан дэмждэг билээ. Гэвч энэхүү эхний алхмыг хийх нь ялангуяа та хэрхэн эхлэхээ мэдэхгүй байгаа бол хэцүү байж болно.

Миний сайн мэдээг номло: Номлолын үйлчлэлийн удирдамж номоос та тусламж олох болно. Энэхүү удирдамжийг та зөвхөн бүрэн цагийн номлогчдод зориулсан гарын авлага гэж та бодож магадгүй, гэвч энэ нь Аврагчтай адилхан болох зорилго тавьж хэрэгжүүлэхэд тань тусалж чадах агуу ном юм. 6-р бүлэг нь Христийн есөн онцгой зан чанарыг ойлгож, эзэмшихэд тань туслах зорилготой юм.

Христийнхтэй адил зан төлөвийг хөгжүүлэхийн тулд *Миний сайн мэдээг номло* удирдамж болон судруудыг хэрхэн ашиглах тухай зөвлөмжүүд энэ бүлэгт байдаг.

- Эхлэхийн тулд *Миний сайн мэдээг номло* удирдамжийн 6-р бүлгийн төгсгөл дэх Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлэх нь-ээс үзнэ үү (хуудас 140). Энэ үйл ажиллагаа нь ямар зан чанарууд эдүгээ таны



НЯМ ГАРАГИЙН ХИЧЭЭЛҮҮД

Энэ сарын сэдэв:
**Христтэй илүү
адил болох нь**

ХАМТДАА ЯРИЛЦ



Аравдугаар сарын турш та нар Христтэй хэрхэн илүү адил болох талаар суралцах болно (хэрэв танай хэл дээр шинэ сургалтын материал хэвлэгдсэн бол). Энэ өгүүллийг уншсаны дараа энэ долоо хоногт эсвэл энэ сард ажиллах нэг зан чанарыг залбиралтайгаар сонго. Та нэг зорилго тавьж ажиллаад, өсөлт хөгжилтөндөө дүгнэлт хийж болно. Жишээ нь: Та өмнөхөөсөө илүү энэрэнгүй, илүү дуулгавартай эсвэл илүү тэвчээртэй болж чадсан уу? Христтэй илүү адил болох зорилго тань бэрхшээл сорилтуудыг даван туулахад хэрхэн тусалсан бэ? Туршлагаа бусад өсвөр үеийнхэн болон гэр бүлийн гишүүдтэйгээ хуваалцахыг бод.

сүнсний хүч чадал болж байгаа болон ямар зан чанаруудыг хөгжүүлэхийн төлөө ажиллах хэрэгтэй байгааг тодорхойлоход тань тусалж чадна.

- Үйл ажиллагааг дуусгасны дараа анхаарал төвлөрүүлэх нэг зан чанарыг залбирч сонго. Сонгосон зан чанарынхаа талаар 6-р бүлэг дээрх хэсгүүдийг уншихыг бод.
- Энэхүү зан чанарыг хөгжүүлэхэд өөрт тань туслах тодорхой, хэмжиж болохуйц зорилгууд тавь. Зорилго дээрээ ажиллах цаг гарга. Тэгээд өсөлт хөгжилтөндөө үнэлэлт өг. Жишээ нь, хэрэв та хайраар дүүрэн болохыг хичээж байгаа бол, долоо хоногийн турш өдөр бүр гурван удаа ах эсвэл эгчийнхээ талаар сайн зүйлүүдийг нь хэлэх зорилго тавьж болно. Тэр долоо хоногийнхоо төгсгөлд зорилгоо хэрхэн хэрэгжүүлсэнээ дүгнэж, үргэлжлүүлэхэд тань туслах өөрчлөлтүүдийг оруулж болно.
- *Миний сайн мэдээг номло* удирдамжид зан чанар бүрийн талаар судлах судрууд байдаг. Та жагсаасан судруудыг залбирч судлан,

унших үедээ төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэж болно.

- Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлэхийн тулд Тэнгэрлэг Эцэгээс тусламж гуй. Тодорхой тусламж хүс. Жишээ нь “Ах эгч нар маань миний юмыг авахад уурладгаа болих хүч чадлыг надад өгөөч” гэж хэлж болно. Таны залбирал тодорхой байх тусам Их Эзэний хариултыг таних нь төдийчинээ хялбар болох болно.

Бидний Аврагч Есүс Христтэй адил болох нь алгуураар хэрэгжих насан туршийн үйл явц мөн. Зарим үед энэ нь маш хэцүү байж мэднэ. Гэвч бүү цөхөр. Их Эзэн бидэнд ийн амласан юм: “Гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үйлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг; мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон гэрэлтдэг” (С ба Г 50:24). Бид гэрэл ба үнэнийг хүлээн авч, судлан, амьдралдаа хэрэгжүүлж, Бурханыг өдөр бүр дагаснаар өөрсдийн Аврагч Есүс Христтэй улам адилхан болно гэдэгт итгэлтэй байж болно. ■

ӨДӨР ТУТМЫН ХИЙХ ЗҮЙЛС

Өдөр тутмын жижиг үйлдлүүд нь Аврагчтай илүү адил болох замыг дагах алхмууд юм. Танд Христийнхтэй адил зан чанаруудыг хөгжүүлэхэд туслах дараах нэмэлт үйл ажиллагаануудыг хийх талаар бод:

- Өөрийнхөө хөгжүүлэхийг хичээж байгаа зан чанартай холбоотой, Судрын удирдамжид жагсаасан судруудыг унш.
- Өөрчлөгдөх хүсэл ба өөрийгөө хөгжүүлэх хүч чадлын төлөө өдөр бүр залбир.
- Өсөлт хөгжилтөө баримтжуулахын тулд тэмдэглэл хөтөл.
- Эцэг эхтэйгээ ярилц. Тэд чамд тусалж болохын тулд зорилгуудаа тэдэнд мэдэгд.

“Сүмийн зарим гишүүд яагаад та нарын жишгүүдээр амьдардаггүй юм бэ? гэж асуудаг гишүүн бус хүмүүст би юу гэж хэлэх вэ?”

Сүмийн гишүүн бүр сайн мэдээгээр бүрэн дүүрэн амьдардаг бол хэчнээн гайхамшигтай байх билээ. Тэд амьдралдаа илүү олон адислал аваад зогсохгүй бас эргэн тойрныхоо хүмүүст агуу үлгэр дууриал болох байсан. Гэвч бид мөнх бус хүмүүс, тиймээс бид бүгд ямар нэг хэмжээгээр алдаа гаргадаг. Зарим хүмүүс бусдаасаа илүү бүрэн дүүрнээр сайн мэдээний дагуу амьдардгийн гол шалтгаан нь бидний хүн нэг бүрийн хөрвөлт ба гэрчлэлийн хүч өөр өөр түвшинд байдаг юм. Бидний хүн нэг бүрт тохиолддог сорилт бэрхшээлүүд өөр өөр байдаг бөгөөд бидэнд туслах эх сурвалж, хүмүүс ч бас өөр өөр байдаг.

Гишүүн бус хүмүүс “хөрвөлт” “гэрчлэл” гэх мэт үг хэллэгүүдийг ойлгохгүй байж болно, гэвч тэд хүн бүр хэрхэн амьдрахаа сонгож чадна гэдгийг ойлгох болно. Тэнгэрлэг Эцэг энэ замыг бидэнд бэлтгэснийг та тайлбарлаж болно. Бид зөв зүйлсийг сонгосноороо сүнслэг байдлын хувьд өсч хөгжиж болохын тулд Тэрбээр бидэнд сонгох эрхийг өгсөн юм. Гэвч Есүс Христээс бусад бүх хүн алдаа гаргана гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэддэг байсан учраас Тэр бидэнд Аврагчийг өгсөн билээ. Бид Цагаатгалын ачаар наманчилж, уучлагдан, алдаанаасаа суралцаж, амьдралд өсч хөгжиж чадна.

Бид Сүмийн жишгүүдийг дагадаггүй хүмүүсийг шүүдэггүй гэдгийг та тэдэнд тайлбарлаж болно. Үүний оронд бид тэдэнд тусалж, ойлгуулж, тэвчээртэй хандахыг хичээдэг. Бид нүглийг хүлцэн тэвчдэггүй ч нүгэлтнийг зэмлэн буруутгадаггүй (Иохан 8:11-ийг үзнэ үү). Наманчлал бид бүгдэд үргэлж боломжтой байдаг.

Судруудыг судал



Аливаа асуултын хариултыг судруудаас олж болно. Хүмүүс зарлигуудыг сахихгүй байсан ч, бид тэднийг шүүхээс зайлсхийх

ёстой (Матай 7:1-ийг үзнэ үү). Ром 3:23-т “Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй” гэсэн байдаг. Харин Сүмийн гишүүд дуулгавартай байхыг хичээх ёстой нь үнэн юм.

Мадисон М., нас 13, АНУ, Техас

Цагаатгалын тухай заа



Дүрэм журмуудыг дагадаггүй гишүүдээс дутагдлыг олж харснаа хүмүүс ярьж байгаа үед би үүнийг Цагаатгалын тухай заах бо-

ломж болгон ашигладаг. Бид мормончууд учраас төгс төгөлдөр байх ёстой гэсэн үг биш бөгөөд бид нүглээ наманчилж, алдаа дутагдлаа засахын тулд бидэнд Цагаатгал байгаа гэж би тэдэнд хэлдэг. Энэ нь ихэвчлэн улам олон асуулуудыг бий болгодог.

Жэйд Х., нас 16, АНУ, Орегон

Сүм бидэнд сайныг үйлдэхийг заадаг



Хүн бүхэнд тулгардаг сорилт бэрхшээл, уруу таталтууд Сүмийн гишүүдэд бас тулгардаг. Бид бүгдэд сул талууд байдаг. Гэвч энэ

нь энэ сүм үнэн биш гэсэн үг биш юм. Энэ сүм бол сайн мэдээ үнэн гэдгийг мэдэж, өргөмжлөлийг хүлээн авахад нь хүмүүст тусалдаг Есүс Христийн Сүм. Эгэл хүн зарлигуудад дуулгаваргүй байдаг (Мозая 3:19-ийг

үзнэ үү) бөгөөд энэ нь Сүмийн дутагдал биш. Сүм бидэнд сайныг үйлдэхийг заадаг. Гэвч бид бүгдэд сонголт байдаг.

Лавиния С., нас 19, Филиппин, Булакан

Жишгүүд бол бидний аз жаргал



Зарим хүмүүс өөрсдийг нь сайн мэдээнээс холдуулдаг сонголтууд хийдгийг би мэдэх учраас энэ асуулт надад танил юм. Бидний аз жаргалын төлөө,

“үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрахын” (Моисе 1:39) төлөө Их Эзэн бидэнд зарлигуудыг өгдөг билээ. Их Эзэн биднийг Өөртөө эргэж очихыг хүсэн хүлээдэг. Гэвч сонголтыг бид өөрсдөө хийхийг Тэр биднээс хүсдэг. Чухам иймээс зарим хүмүүс бидний жишгүүдээр амьдардаггүй. Намайг Тэнгэрлэг Эцэгтэй эргэн очиж, Түүнтэй хамт амьдран, аз жаргалтай байхын тулд Тэрбээр жишгүүдийг надад өгснийг би мэддэг учраас жишгүүд надад тусалдаг. Жишгүүд бол намайг хайрладаг Түүний хайрын нотолгоо юм.

Морган Д., нас 18, Франц, Лэнгидос Рауссиллон

Тэдний төлөө залбирч, тэдэн дээр оч

Жишгүүдээр амьдардаггүй гишгүүдэд Есүс Христ дээр төвлөрсөн гэрчлэл байхгүй байж болно. Тэд Сүнсний удирдамжийг эрэлхийлж, тэднийг гэрчлэлтэй болгохын тулд бид тэдний төлөө залбирах ёстой. Бид тэдгээр хүмүүс дээр очиж, Христэд ирэхэд нь тэдэнд туслах ёстой.

Андреа К., нас 13, Перу, Лима

Үлгэр дууриал үзүүл



Тэнгэрлэг Эцэгийнхээ зарлигуудыг биелүүлж, Түүнтэй хамт дахин амьдрахад энэ Сүм бидэнд тусалдгаараа нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч хүн зөвхөн Сүмд харьяалагдсан учраас үргэлж сайн зүйл хийнэ гэсэн үг биш юм. Мөнх бус байдлын өмнөх амьдралд Есүс Христийг дагахаар шийдсэн хүмүүс дэлхий даяар байгаа ч, ёс бус явдал, жигшүүрт хэргүүдээр дүүрсэн өнөөдрийн дэлхийг хар л даа.

Бидний хийж чадах хамгийн сайн зүйл бол найз нөхдөдөө үлгэр дууриал үзүүлэх явдал гэж би бодож байна.

Кадэн С., нас 15, АНУ, Юта

Жишгүүдээр амьдарцгаа



Бусад байгууллага, шашны нэгэн адил манай сүмд ч гэсэн илүү итгэлтэй ба бага итгэлтэй хүмүүс байдаг. Бидний хийх

ёстой зүйл нь зөвхөн чадлынхаа хэрээр жишгүүдээр амьдарч мөн бусдыг бас ийн хийхэд нь залбирах хэрэгтэй.

Марэн С., нас 16, АНУ, Аризона



БУСДЫГ ИРЭЭДҮЙД ЯМАР ХҮМҮҮС БОЛСОН БАЙХААР НЬ ХАРЖ СУР

“Дахин хэлэхэд, бид хүмүүсийг одоо ямар байгаагаар нь биш, харин ямар болсон байхаар нь харах үүрэг хариуцлагатай юм. Бусдын тухай ийм байдлаар бодож байхыг би та нараас эрхэмлэн хүсч байна.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Бусдыг ирээдүйд ямар хүмүүс болсон байхаар нь харж сур,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 79.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Би бодол санаагаа хянахыг хичээсээр байгаа, гэвч маш олон уруу таталттай тулгардаг. Би хэрхэн илүү цэвэр ариун бодолтой болох вэ?”

11-р сарын 15-наас өмнө хариултаа илгээнэ үү. Хэрэв хүсвэл, шаардлага хангасан гэрэл зургийг liahona@ldschurch.org 3-р хуудсан дээрх хаягаар эсвэл шуудангаар илгээж болно.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) овог, нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн бичгээр гаргасан таны зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).



Далын
Ахлагч
К.Скотт Грей

Наманчлахад тань туслах нь бишопын дуудлагын чухал хэсэг юм. Түүнтэй хэзээ ярилцах хэрэгтэйг ухамсар тань танд хэлэх болно.

Та ноцтой нүгэл үйлдсэн бол яагаад бишоптоо эсвэл салбарын ерөнхийлөгчдөө нүглээ хүлээх ёстой гэж заадаг юм бол хэмээн бодож болох юм. “Наманчлал нь Их Эзэн бид хоёрын хоорондох хувийн асуудал биш үү? Хэрэв би муу зан чанараа орхиж, үүнийгээ Бурханы өмнө хүлээсэн бол, яагаад бишоптойгоо ярилцах хэрэгтэй юм бэ?” гэж өөрөөсөө асууж болох юм.

Яагаад өөр хэн нэгэнтэй биш, заавал бишоптой ярилцдаг юм бэ?

Олон өсвөр үеийнхэнд хийсэн алдаагаа эцэг эх эсвэл өсвөр үеийнхний удирдагчдынхаа өмнө хүлээх нь илүү тохиромжтой юм шиг санагддаг ажээ. Хэдийгээр таны эцэг эх болон удирдагчид шаардлагатай тусламж зөвлөгөө өгч чадах ч, Их Эзэн бишопыг Израил дахь олон нийтийн шүүгч хэмээн тунхагласан билээ (С ба Г 107:72, 74-ийг үзнэ үү). Тэрбээр тойргийнхоо гишүүдийн зохистой байдлыг тодорхойлох үүрэгтэй. Бишоп нь томилолтоор болон зөв шударга амьдралаараа тойргийнхоо гишүүд, түүний дотор таны талаар Ариун Сүнснээс илчлэлт хүлээн авах эрхтэй юм.

Бишоп таны эцэг эх болон буцад удирдагчдын өгөх боломжгүй арга замаар наманчлалын үйл явцаар дамжуулан танд тусалж чадна.



БИ ЯАГААД ГЭМ БУРУУГАА БИШОПТОО **ХҮЛЭЭХ**

ХЭРЭГТЭЙ ЮМ БЭ? ҮҮНИЙ ТУЛД БИ ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хэрэв нүгэл ноцтой байвал Сүм дэх боломжуудыг хязгаарлах асуудлыг бишоп шийдэх ёстой. Жишээ нь, тэр өөрийн тань наманчлах үйл явцын хэсэг болгон тодорхой хугацаанд ариун ёслолоос хүртэхгүй байх эсвэл санваараа ашиглахгүй байхыг танаас хүсч болно. Тэр тантай ажиллаж, хэзээ дээрх ариун үйл ажиллагаануудад дахин оролцохоор зохистой болсныг тань тодорхойлно.

Уруу татаалтыг эсэргүүцэх чадвараа нэмэгдүүлэхийн тулд юу хийх тухай зөвлөгөөг бишоп тань танд

өгөх болно. Тэрээр таныг наманчлал гэх мэт сургаалын сэдвүүдийг судалж, сурч мэдсэн зүйлээ хуваалцахад тань урамшуулан дэмжиж болно. Бишоп таныг уруу татдаг нөхцөл байдлуудаас өөрийгөө хол байлгахын тулд юу хийж байгаа талаар өөртэй нь долоо хоног бүр уулзаж байхыг хүсч болно.

Би хэзээ түүнтэй ярилцах ёстой вэ?

“Эдгээр зүйлүүд сайхан сонсогдож байна, гэвч миний хийсэн

зүйл бишоптой ярилцахаар тийм ноцтой эсэхийг би яаж мэдэх вэ?” хэмээн та бодож болно. “Ухамсар тань үүнийг танд хэлж өгөх болно” хэмээн товчхон хариулья. Ухамсрынхаа өдөөлтийг мэдэрсэн л бол тэр даруй үйлд (Алма 34:31–34-ийг үзнэ үү).

Хаан Бэнжамин наманчлалын талаар “Та нар тэгснээр нүгэл үйлдэж болох зүйлийг бүгдийг би та нарт хэлж чадахгүй; учир нь маш олон янзын зам мөн аргууд бий, бүр тэдгээрийг би тоолж чадахааргүй тийм олон бөлгөө” хэмээн хэлжээ (Мозая 4:29). Бишопынхоо өмнө таны хүлээх ёстой зүйлсийн нарийвчилсан жагсаалтыг өгөхийн оронд шийдвэр гаргахад тань туслах зарим зарчмудыг би хуваалцъя.

Би юу хүлээх хэрэгтэй вэ?

Би таныг дуулгавартай байхаар хичээснийг тань мэднэ. Гэвч та алдаа тэр бүү хэл ноцтой алдаанууд гаргасан байж болох юм. Хүмүүсийн гаргадаг алдаануудын ихэнхийг хувийн залбирал ба чин сэтгэлийн наманчлалаар дамжуулан шийдвэрлэж болно. Зарим алдаа, ялангуяа ёс суртахуунгүй явдалтай холбоотой алдаа гаргасан бол та Их Эзэнээс өршөөл хүлээн авахын тулд бишоптоо хүлээх шаардлагатай.

Та хийсэн алдааныхаа талаар бодох үед танд гэм буруугийн мэдрэмж төрж, сэтгэл санаа тогтворгүй, баяр баясгалангүй, тэр ч бүү хэл бүр зовлонтой байж болно. Хэрэв танд эдгээр мэдрэмжүүд төрж байгаа бол гаргасан алдааныхаа талаар бишоптойгоо ярилцах хэрэгтэй.

Өөрийгөө эсвэл гэм буруугаа хаацайлж зөвтгөхийг бүү хичээ. “Хийсэн зүйлийнхээ тухай бишопт ярих нь дэндүү ичгүүртэй байна. Тэр намайг ийм юм хийхгүй хүн гэж бодож байгаа. Намайг хийсэн зүйлээ ярихад бишоп мэл гайхах байх даа. Би түүнд цаашдаа таалагдахгүй байх” гэж та бодож болох юм.

Тэр таныг зэмлэхгүй гэдгийг би амлаж байна. Бишоп Их Эзэний үйлчлэгчийн хувьд таныг сонсож байхдаа эелдэг байж, таныг ойлгох болно. Дараа нь тэр наманчлалын үйл явцаар дамжуулан танд туслах болно. Тэр бол Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан цэвэр ариун болоход тань туслах ач ивээлээр дүүрэн Их Эзэний элч юм.

Их Эзэн ийн хэлжээ: “Болгоогтун, нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн бибээр тэдгээрийг цаашид санах нь үгүй.

“Хүн нүглүүдээ наманчилдаг эсэхийг та нар үүгээр нь мэдэж болно-болгоогтун, тэрээр тэдгээрийг хүлээж мөн орхих болно” (С ба Г 58:42–43).

Нүглээ хүлээж, орхисон үед Их Эзэн таныг өршөөх болно. Та шүүгдэх үедээ эдгээр нүглүүдийнхээ төлөө Түүний өмнө хариуцлага хүлээхгүй.

Хэрэв би гэм буруугаа хүлээхгүй бол яах вэ?

Хүн заримдаа буруу юм хийхээ больдог, гэвч шаардлагатай үед бишопынхоо өмнө гэм буруугаа хүлээдэггүй. Үүний үр дүнд тэр хүн Аврагчид ачаа дарамтаа үүрүүлэхийн оронд өөрөө нүглийн дарамтаа үүрсээр байх болно.

Би нэг жишээ хуваалцъя. Хэдэн жилийн өмнө нэг орой би ариун сүмийн эрхийн бичгийг нь шинэчлэхээр насанд хүрэгчидтэй ярилцлага хийж байлаа. Дунд насны нэг эмэгтэй ярилцлагад орохоор орж ирлээ. Тэр ариун сүмд гэрлэсэн бөгөөд бүх насаараа сүмд идэвхтэй байжээ.

Тэр эмэгтэй сэтгэл санааны хувьд их гунигтай байгааг би мэдрэв. Ярилцлагын явцад би сүнслэг мэдрэмж хүлээн авлаа. Би түүнд “Эгч ээ, та өсвөр насандаа нэг ноцтой алдаа гаргаад санваартан удирдагчийнхаа өмнө түүнийгээ хүлээгээгүй юм байна гэсэн мэдрэмж надад төрлөө.

Та тэр тухайгаа надад ярьж болох уу?” гэж асуув.

Нөгөөх эмэгтэй тэр дороо учиргүй уйлж гарлаа. Энэ үнэн гэж тэр хэллээ. Гэвч түүнд тэрхүү нүглээ бишопынхоо өмнө хүлээх нь дэндүү ичмээр юм шиг үргэлж санагддаг байжээ. Тэр үйлдсэн гэм буруугаа хүлээж, хийсэн зүйлийнхээ талаар зохистой байдлыг нь тодорхойлоход хангалттай нарийн ширийн зүйлийг надад ярьсан.

Үйлдсэн нүглээ санваартан удирдагчийнхаа өмнө хүлээсэн нь түүний наманчлалын эхлэл биш, харин төгсгөл нь болсон юм. Тэр эмэгтэй энэхүү нүглийнхээ ачаа дарамт, уй гашуут 30 гаруй жил үүрч явсан нь түүний хувьд огт шаардлагагүй илүү зүйл байжээ.

Тэр наманчлалынхаа эцсийн алхмыг хийсэн учраас гэм буруу нь уучлагдсан юм. Тэр орой болсон ярилцлагаас хойш би түүнтэй үе үе тааралддаг байсан. Тэр эмэгтэй нүүр царай нь гэрэлтэн, аз жаргалтай харагддаг байлаа.

Би түүний нэрийг санахгүй байгааг та нарыг мэдээсэй гэж хүсч байна. Их Эзэн ийм дурсамжуудыг бишопуудын ой тойноос авч хаядаг юм. Миний санаж байгаа зүйл бол дунд насны тэр эмэгтэй санваартны удирдагчид нүглээ хүлээснээр олон жил тээж явсан гэм буруугийн мэдрэмж нь арилсан явдал юм.

Ийм алдаа бүү гарга. Танд гэм буруугийн ямар нэгэн мэдрэмж байгаа боловч үүнийг бишопынхоо өмнө хүлээх хэрэгтэй эсэхийг мэдэхгүй байгаа бол, түүнтэй очиж уулз. Өөртөө туслах боломжийг түүнд олго. Сэтгэл санааны зовлон учруулагч хэрэггүй ачаа дарамтыг насан туршдаа үүрч явах эрсдэлд өөрийгөө бүү оруул. Гэм буруугаа бишопын өмнө хүлээснээр тань мөн наманчлалаар тань дамжуулан Их Эзэн санаа сэтгэлийн дарамт ачааг тань Өөртөө авах болно (Исаиа 1:18-ыг үзнэ үү).



Би яагаад наманчлах хэрэгтэй юм бэ?

Есүс Христ Өөрийн цагаатгагч золиослоор дамжуулан бүх хүн төрөлхтний нүглийн төлөөсийг төлсөн билээ. Тэрээр та нарыг наманчилж, уй гашуу, гай зовлонгоос зайлсхийхэд урьдаг. “Наманчил, эс тэгвээс . . . чиний зовлон гашуун байх болно хэр зэрэг гашууныг чи мэдэх нь үгүй, хэр зэрэг хүчтэйг чи мэдэх нь үгүй, тийм ээ тэвчихэд хэр хэрэг хэцүүг чи мэдэх нь үгүй.

“Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ;

“Гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адилаар тэд зовох ёстой. . . .

“Иймийн тул, би чамд наманчлахыг дахин зарлиглаж байна, . . . мөн тийн чи нүглүүдээ хүлээх болно, эс тэгвээс миний ярьсан эдгээр шийтгэлүүдийг чи амсах болно” (С ба Г 19:15–17, 20).

Есүс Христ туулсан зовлонгоороо дамжуулан чиний нүглийн төлөөсийг аль хэдийн төлснийг би гэрчилж байна. Чи гагцхүү наманчилсан тэр хэмжээгээрээ л уучлагдаж чадна. Нүглийнхээ төлөөсийг төлөхийг бүү хичээ. Туулсан зовлонгийн чинь хэмжээ чамайг гэтэлгэхгүй. Чи уучлалыг зөвхөн Цагаатгалаар дамжуулан хүлээн авах болно.

Та бүхэн Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх итгэлээ хөгжүүлэх болтугай. Шаардлагатай үед бишоптоо нүглээ хүлээнээр наманчлалаар дамжуулан та цэвэр ариун болно гэдгийг би Есүс Христийн нэрээр гэрчилж байна. Түүнээс гадна, та нар Аврагчийн ач ивээл боломж олгогч Түүний хүчээр дамжуулан ирээдүйд уруу татаалтыг эсэргүүцэх хүч чадлаа өсгөн нэмэгдүүлж чадна. Тийнхүү та нар оюун ухаандаа амар амгалан, энэ амьдралд аз жаргалыг олж, ирэх дэлхийд мөнх амьдралыг өвлөн авах болно. ■



БИДНИЙ АГУУ ЭДГЭЭГЧ

“Аврагчийг Агуу Эдгээгч” хэмээн олонтоо өгүүлсэн байдаг. . . . Өвчин бидний бие махбодод хэрхэн

нөлөөлдөгтэй адилаар гэм нүглийн үр дагавар бидний сүнсэнд нөлөөлдөг бөгөөд энэ нь сүнсэнд дахин учирч болох аюул, сүйрлээс сэрэмжлүүлэн хамгаалдаг. Бидний сүнсний шархлааг эдгээж, гэм нүглийг зайлуулах чадвартай илааршуулагч тосолгоо нь Аврагчийн Цагаатгалаас эх ундаргатай юм. Гэвч энэхүү илааршуулагч тосолгоо зөвхөн Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, байнгын дуулгавартай байдлын зарчмуудаар дамжин амьдралд хэрэгждэг. Чин сэтгэлийн наманчлалын үр жимс нь ухамсрын амар амгалан, тайтгарал, сүнсний эдгэрэлт ба шинэчлэлт юм.

Танай бишоп эсвэл салбарын ерөнхийлөгч бол наманчилж, эдгэрэхэд тань туслах эрх мэдэл олгогдсон, сүнсний эдгээгчийн туслах юм.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар, “Бид ариун явдалд итгэдэг,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 53.



Далын
Ахлагч О. Винсент Халэк

Аврагчийг амьдралдаа урих нь

*“Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орно”
(Илчлэлт 3:20).*

Намайг бага байхад Христийн Мэндэлсний Баяраар Аврагч хаалга тогшиж байгаа зургийг ээж гадаа хаддаг байж билээ.

Тэр үед бид сүмийн гишүүд болоогүй байсан бөгөөд би үргэлж ээжээсээ “Есүс яагаад хаалга тогшиж байгаа юм бэ? Хаалганы цаана хэн байгаа юм бэ?” гэж асуув.

Аврагчийн тогшиж байгаа хаалганы гадна талд бариул байхгүйг би хэдэн жилийн дараа олж мэдсэн юм. Хаалганы дотор талд байгаа хүн л хаалгыг онгойлгож чадах байв.

Хаалганы нөгөө талд хэн байдгийг би одоо мэднэ. Энэ чинь бид өөрсдөө шүү дээ!

Аврагч хаалга тогшиж байна, бид бүгд хаалгаа нээж, Түүнийг амьдралдаа ирэхийг урих ёстой.

Би өсвөр насны хөвгүүн байхдаа баптисм хүртэж, сүмийн гишүүн болсноор Аврагчийг амьдралдаа уриаар шийдсэн юм. Найз нар маань төдийгүй эмээ маань надад

сайн үлгэр дууриал жишээ үзүүлдэг байсан. Манай эмээ Калифорний Лос Анжелесийн Ариун Сүмийн ажилтан байсан юм. Тэр ариун сүмд Их Эзэнд үйлчлэхийн тулд өглөөний 4:00 цагт гэрээсээ гарч явдаг байж билээ.

Би баптисм хүртээд хоёрхон жилийн дараа, бүрэн цагийн номлогч болж Их Эзэнд үйлчлэхээр шийдэв. Би номлолд байхдаа Аврагчийг тэд амьдралдаа урьж болохын тулд олон хүнд Аврагчийн тухай тухай мэдэхэд нь тусалсан.

Хожим нь би Самаод номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн. Би шинэ номлогчдоос тэд номлолд үйлчлэхээр хэзээ шийдсэнийг нь үргэлж асуудаг байлаа. Олон хүн Хүүхдийн Хэсэгт байхдаа номлолд үйлчлэхээр шийдсэн тухайгаа ярьсан!

Номлолын үйлчлэлд бэлтгэхэд чинь Хүүхдийн Хэсэг чамд туслах болно. Чадахынхаа хэрээр их зүйлийг сурч мэд. Номлолд үйлчлэх зорилго тавьж ажилла. Тэгвэл чи Аврагчийг амьдралдаа урихад нь хүмүүст туслах чадвартай болно. Номлогч болсон нь миний амьдралыг өөрчилсөн болохоор чиний амьдралыг ч бас өөрчлөх болно. ■



ШИНЭХЭН

*Ариун ёслолыг түгээх нь том хариуцлага юм.
Хэрэв дикон будилбал юу болох вэ?*

Жэйн Макбрайд Чөүт

Бодит түүхээс сэдэвлэв

“Мөн тэрчлэн энэхүү санваарыг хүлээн авдаг тэд бүгд намайг хүлээн авдаг хэмээн Их Эзэн хэлдэг” (С ба Г 84:35).

Бэнжи толины өмнө зогсоод зангиагаа засав. Түүнд цагаан цамц, хар хөх өмд нь маш сайхан зохижээ. Үсээ нямбай гэгч нь самнасан байв. Тэр диконор томилогдоход бэлэн болсон харагдаж байлаа. Тийм байтал тэр яагаад сандарсан юм бол?

Бэнжи судруудаа аваад өрөөнөөс гарлаа. Тэр өнөөдөр сүм дээр бүх зүйл өөр байгаа талаар бодохгүй байхыг хичээв. Ариун ёслол түгээх санваарын шинэ үүргийнхээ талаар бодох бүрт энэ нь түүний санааг зовоож байв. Хэрэв тэр ирэх долоо хоногт анх удаа ариун ёслол түгээхдээ алдаа гаргавал юу болох вэ? Тэр бас гэрээсээ гарахдаа энэ тухай мартахыг хичээлээ.

Ариун ёслол үргэлж нэг хэвийн явагддаг. Тэгээд Бэнжи гэрийнхэнтэйгээ хамт бишоп Салазарын өрөөнд орлоо. Энэ нь үнэхээр өөр байв. Ердийнхөөр бол тэр одоо Хүүхдийн Хэсгийн нээлтийн үйл ажиллагаан дээр байх ёстой байлаа.

Бэнжийг суухад аав нь, бишоп, Залуу Эрэгтэйчүүдийн



ДИКОН



“Хэрэв диконууд та нар . . . дуудлагаа эрхэмлэн биелүүлбэл, бүр одоо ч гэсэн та

нар Бурханы мутар дахь зэмсэг байх болно, учир нь залуу эрэгтэйд өгөгдсөн санваарын хүч нь үүнийг зөв шударгаар ашигласан үед эрэгтэй хүнд өгөгдсөнтэй адил хүчтэй юм.”

Далын Ахлагч Тэд Р.Каллистэр, “Залуу эрэгтэйд өгөгдсөн санваарын хүч,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 62.

ерөнхийлөгч, бишопын зөвлөлийн гишүүд толгой дээр нь гараа тавилаа. Аав нь түүнд Аароны санваар өгөв. Бэнжи адислалын үед сандарсангүй. Түүний сэтгэл тайван, баяртай байв.

Бэнжи босч хүн бүртэй гар барив. Тэгээд тэр ээжийгээ, ах Жэйгээ, бас жаахан эмэгтэй дүү Миразольгоо тэврэлээ.

Дараа нь тэр ням гарагийн анги руугаа явав. Шинэ хичээлүүд нь Хүүхдийн Хэсгийн хичээлтэй адилгүй ч гэсэн танил юм шиг санагджээ. Хичээл нь залбирлын тухай байв. Тэр өмнө нь Хүүхдийн Хэсэгт залбирлын тухай олон хичээл үзжээ. Бэнжи тайвшран санаа алдлаа. Дикон байх нь тийм ч хэцүү биш бололтой.

“Дикон болно гэдэг агуу зүйл шүү” гэж Жэй сүмээс гараад Бэнжид хэлэв. “Би ариун ёслолыг адисална, харин чи түгээж болно.”

Сандарч байсан нь оргүй алга болов. “Тийм ээ, агуу” гэж тэр аяархан хэлэв. Ариун ёслол түгээх нь Бэнжигийн сэтгэлийг хамгийн их зовоож байв!

Бэнжи тэр үдэш оройхон аавыгаа буйдан дээрээ ном уншиж байхтай тааралджээ. “Хэрэв би

хэн нэгнийг алгасаад тэр хүн ариун ёслолоос хүртэж чадахгүй бол юу болох вэ?” гэж тэр асуув. “Хэрэв би бүдэрч унавал юу болох бол?” Тосгуур шалан дээгүүр гулсан унаж, устай аяганууд хаа сайгүй нисэх мэт шидэгдэж буйг тэр санаандаа маш тодоор төсөөлөн харлаа.

Аав нь Бэнжийг мөрөөр нь чанга тэврээд “Би анх удаа ариун ёслол түгээснээ санаж байна. Тэгэхэд би чиний одоогийнхоос илүү сандарч байсан байх аа” гэв.

Бэнжи гайхсандаа нүд цавчив. “Та юу? Та юунаас ч айдаггүй шүү дээ!”

Аав нь чанга инээв. “Би зөндөө олон удаа айдаг байсан. Сандрахгүй байхад юу надад тусалдгийг чи мэдэх үү?”

Бэнжи хормын төдийд бодов. “Залбирал уу?”

Аав нь инээмсэглэв. Тийм ээ, тэр зөв. Залбирал. Тэгээд аав надад адислал өгөв. Чи надаас адислал авмаар байна уу?”

Бэнжи түргэн толгой дохив. “Тэгье! Би бүр олон удаа адислал авмаар байна.”

Тэд гэр бүлээрээ зочны өрөөнд цугларав. Аав нь Бэнжигийн толгой дээр гараа тавилаа. Аавыгаа

ярьж эхлэхэд Бэнжи нүдэнд нь нулимс цийлэгнэж байгааг мэдрэв. Аав нь адислал өгөхдөө, “чи санваарыг ариун нандин ёслолоор дамжуулан авсан бөгөөд бид бусдад үйлчилж болохын тулд Тэнгэрлэг Эцэг бидэнд санваарыг өгдгийг санаж яв. Хэрэв чи үүнийг зүрх сэтгэлийнхээ бүх тэмүүлээр үүнийг хийх аваас, үүгээр бүх зүйлд адислагдах болно.”

Бэнжи долоо хоногийн турш тусламжийн төлөө залбирав. Тэр дараачийн ням гарагт цуглааны байрын өмнө диконуудтай нэгдэв. Тэр Жэйг талхны адислал хэлэхийг анхааралтай сонслоо.

Тэр гэнэт дахин сандарч эхлэв. Тэр ариун ёслолыг сайн түгээж чадах болов уу? Энэ нь маш чухал байлаа! Тэгээд тэр аавынхаа өгсөн адислал дахь амлалтуудыг саналаа. Сүнс түүнд нөлөөлөхөд тэр сэтгэл түгшүүрлэн сандрахаа больж, тосгуураа аваад хариуцсан эгнээнүүд рүүгээ итгэлтэйгээр явав. Тэгээд эхний эгнээнд сууж байсан нэг эмэгтэйд тосгуураа өглөө.

Тэр эмэгтэй түүнийг хараад инээмсэглэв. Бэнжи хариу инээмсэглэхдээ өөрийгөө Их Эзэнд үйлчилж байгаагаа мэдэж байлаа. ■

Винтер Квортэрст ХҮЛЭЭСЭН НЬ

Винтер
Квортэрс

АЙОВАГИЙН ЗАМ

АЙОВА


Науву

Жэннифэр Мадди

Шинэ хот

Бошиглогч Иосеф Смитийг алагдсаны дараа Иллинойн Науву аюултай газар болжээ. Гэгээнтнүүд амьдрах илүү аюулгүй газар олохын тулд гэр орноо орхин зугтаж байлаа. 1846 оны хоёрдугаар сард гэгээнтнүүдийн эхний хэсэг өрнөд нутаг руу хийх аянаа эхэлсэн ч, цаг агаар муудаж, өвчин гарсан нь тэдний аяныг удаашруулжээ. Гэвч тэднийг Айоваг гатлах үед өвөл болохоос өмнө Хадат Уулсаар нэвтрэн гарах нь нэгэнт оройтсон байлаа. Тиймээс сүмийн удирдагчид гэгээнтнүүдийн өвөлжих газрыг сонгосон ажээ. Тэд энэ газрыг Винтер Квортэрс гэж нэрлэсэн ажээ.

Винтер Квортэрс дахь Мормоны Зам Төвийн доторх энэхүү үзмэр нь Айовагийн зам дээрх буудлын багасгасан хувилбар юм. Виллиам Клэйтон "Ирцгээ, Ирцгээ, Гэгээнтнүүд ээ" дууллыг энд бичжээ (Сүмийн дуулал болон хүүхдийн дуунууд, х.2).





Хамтын хүчээр

Зарим хүмүүс гуалин, дүнз модор жижигхэн байшингууд барив. Бусад нь майхан болон агуйд амьдарч байв. Гэгээнтнүүд урт удаан, хүйтэн өвлийн туршид баяр баясгалантай байхыг хичээж, бие биедээ тусалж байлаа. Тэд концерт үзэж, дуулан, бүжиглэдэг байв. Тэд гурилын тээрэм, концертын танхим, сагс сүлждэг үйлдвэр барьжээ.

Аянаа үргэлжлүүлсэн нь

Гэгээнтнүүд Винтэр Квортэрст хахир хатуу өвлийг өнгөрүүлжээ. Олон хүн нас барсан байна. Гэвч анхдагчид Их Эзэн тэднийг адисалж, энэ газрыг Сион болгоход тэдэнд тусална гэдэгт итгэлтэй байлаа. Тэгээд сая нэг юм хавар болоход анхдагчдын эхний хэсэг Солт Лэйкийн Хөндийг зорин Винтэр Квортэрсээс хөдөлжээ.

Өнөөдөр та нар Нэбраскийн Винтэр Квортэрсийн үзэсгэлэнт Ариун сүмийг үзэж, анхдагчдын тухай илүү ихийг мэдэхийн тулд Винтэр Квортэрс дахь Мормоны Зам Төвийг үзэж болно. ■



Та Мормоны Зам Төвд гэгээнтнүүдийн аян замдаа хэрэглэж явсан эд юмсыг үзэж болно. Сүмийн удирдагчид тэдэнд гурил, хоол амтлагч, цагаан будаа, вандуй, саалийн үнээнүүд авч явах хэрэгтэй гэж хэлдэг байлаа.



Зарим гэгээнтнүүд гуалингаар жижигхэн оромжууд барьж, Винтэр Квортэрст байхдаа тэдгээрт амьдарч байлаа.



Гэгээнтнүүд Винтэр Квортэрст түр суурьшсан нь

Зураг чимэглэлийг Ари Ван Де Графф

Анхдагчууд өрнөд нутаг руу хийх аянаа үргэлжлүүлэхээс өмнө өвлийг өнгөрүүлэхийн тулд Винтер Квортэрст түр хугацаагаар суурьшсан билээ. Энэ зурганд нуусан юмсыг олоорой.

харандаа

боов

Шанага

халбага

илүүр

НОМ

Эрэг
чангалдаг
түлхүүр

аяга

Шархны
боолт

бөмбөг
хийлэгч

лууван

модтой
чихэр

зүү

цаг

лийр

ОНЦГОЙ ГЭРЧ



Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
**Ахлагч Д.Тодд
Кристоффэрсон**

Арванхоёр Төлөө-
лөгчийн чуулгын
 гишүүд бол Есүс
Христийн онцгой
гэрчүүд юм.

Есүс Христ бошиглогчидтой хэрхэн ярьдаг вэ?


Тэрээр элч илгээж болно
эсвэл Өөрийн биеэр
хүрч ирж болно.



Есүс
Өөрийн дуу
хоолойгоор
эсвэл Ариун
Сүнсний дуу
хоолойгоор
ярьж болно.



Тэрээр Өөрийн үйлчлэгчдэд
хандан нэг бүрчлэн ярьж
болно эсвэл тэднийг хамт-
даа зөвлөлдөж байхад нь
тэдэнд ярьж болно.



“Христийн сургаал,” *Лиахона*,
2012 оны 5-р сар, 86–90.

Вайолит түүнд
тааруухан ханддаг
байхад Эмма түүнтэй
яаж сайхан харьцах
юм бэ?

Вайолитэд

Чарлотт Мэй Шэппард

Бодит түүхээс сэдэвлэв

*“Чи хөршөө өөр шигээ хайрла”
(Марк 12:31).*

Эмма үүргэвчин цүнхнийхээ оосрыг чангалаад шинэ ангид алхаж орлоо. Энэ бол сургуульд орсон анхны өдөр нь. Тэр дуртай даашинзаа өмсөхөд ээж нь түүний үдийн хоолтой нь хамт амттай жигнэмэг хийн боож өгчээ.

“Өнөөдөр ч агуу өдөр болно доо.” “Мартах аргагүй агуу өдөр болно” гэж Эмма дотроо бодов.

Эмма зогсоод ангийг тойруулан харлаа. Вайолит сууж байх нь тэр.

Өнгөрсөн жил Вайолит тоглоомын талбай дээрх хашлагатай дүүжин савлуур дээр хэнтэй ч ээлжлэхгүй ганцаараа тоглодог байжээ. Тэр Эммад олон нэр өгсөн гэнэ. Түүгээр ч зогсохгүй тэр Эммагийн хамгийн сайн найзыг булааж өөрийн найз болгосон гэнэ.

Вайолит Эммаг хараад ганц ч үг дуугарч чадсангүй. Эмма эргэж хараад үүргэвчин цүнхнийхээ оосрыг улам чангалав. Вайолит өнгөрсөн жилийн турш түүнд нөхөрсөг биш ханддаг байсан болохоор энэ жил ч гэсэн өөрцгүй юм шиг санагджээ.

“Хичээлийн шинэ жилдээ тавтай морилно уу!” гэж хатагтай Колдвэлл ангийн өмнө зогсон мэндчилэв. “Одоо хүн бүрт суудал хуваарилж өгье.”

Ширээнүүдийг хоёр хоёроор нь эгнүүлэн тавьсан байлаа. Хатагтай Колдвэлл чигчий хуруунаасаа эхлэн доош дарж тоолсноо арын

эгнээн дэх хос ширээ рүү зааж, “Эмма. Чи ар талд сууна” гэв.

Эмма ар талын ширээнүүдийн нэгэнд суулаа. Тэр Лайзллыг эсвэл Жэймийг эсвэл

“Вайолит”-ыг хажуудаа суух нь дээ гэж бодлоо.

Эмма цочин нүд нь орой дээрээ гарав. Буруу дуулаагүй байгаа даа?

Тийм ээ. Хатагтай Колдвэлл түүний хажуугийн ширээ рүү заасан хэвээр байлаа. “Чи Эммагийн хажууд сууна, Вайолит” гэж тэр хэллээ.

Вайолит хөмсөг зангидан Эммагийн зүг гэлдрэв. Эмма түүний ширээний дээгүүр харан хана ширтэнэ. Дуусахгүй урт жил болох нь дээ.

Хатагтай Колдвэлл математикийн хичээл дээр ангийнхны бодох ёстой хэдэн бодлогыг самбар дээр бичив. “Та нар бодлогуудыг ганцаараа эсвэл хөрштэйгөө хамтран бодож болно” гэж тэр хэллээ.

Эмма завгүй байгаа дүр үзүүлэн бодлогууд дээрээ тонгойн сууна. Бодлогууд нь зовох юмгүй амархан ажээ. Тэр зүгээр л Вайолитаас нүүр буруулахыг хичээж байлаа. Тэр Вайолит руу өглөөжингөө харсангүй.

Мөрөнд нь нэг юм хүрсэн нь харандаа шиг санагдав. Эмма үүнийг тоосонгүй.

Дахиад ёвров. Вайолит түүнийг ёворсон ажээ!

Эмма огт тоосонгүй бодлогуудаа бодсоор байлаа.

Вайолит гурав дахь удаагаа ёворсон нь тэсэхийн аргагүй санагджээ. Эмма уур нь хүрч байгааг мэдэрлээ. Жилийн турш ингээд байх юм гэж үү? Тэр гараа өргөж, хатагтай Колдвэллд хэлдэг юм бил үү? гэж эсвэл Вайолит руу зүгээр л хардаг юм бил үү гэж бодлоо.

Тэгтэл Эмма хэн нэгний шуухитнах чимээ сонсов. Хүн уйлж байна



ТУСЛАХ НЬ

уу даа? Түүнийг харандаагаар дахин ёвров. Тэгээд толгойгоо өргөж хартал Вайолит түүн рүү ширтэн харж байлаа. Вайолит гартаа харандаа барьчихсан, нүдэнд нь нулимс цийлэгнэж байв. Түүнийхаа дараа яаж ингэж чаддаг байна бичгийн ажил баллуурын толбоор дүүрчээ.

Вайолит харандаагаа гартаа эргүүлсээр байлаа. “Чи надад тусалж болох уу?” гэж тэр чимээгүйхэн асуув.

Эмма түүнийг нэг хором хараад, яах ч учраа эс олов. Вайолит түүнээс туслахыг хүсч байгаа хэрэг үү? Үргэлж эвгүй харьцдаг байсны дараа яаж ингэж чаддаг байна аа? Эмма өөрийнхөө бичгийн ажлыг үргэлжлүүлээ. Вайолит ганцаараа ажиллахаас аргагүй болов. Тэр Эммагийн хөрш байтлаа түүгээр туслуулж чадахгүй байна гэж үү?

Эмма чимээгүйхэн урагшаа харав. Хажууд нь Вайолит аяархан уйлж байгааг тэр сонслоо. Судрууд хөршөө хайрла гэж байнга захидаг ч Вайолит өөр байлаа! Эмма ангидаа түүний дэргэд дөнгөж сая суусан шүү дээ!

Эмма өөрийнхөө ажлыг үргэлжлүүлснээ зогсов. Вайолит бусдаас өөр биш ч юм бил үү. Судрууд хөршөө хайрла гэж захидаг нь бүх хүмүүсийг, тэр ч бүү хэл, муу хүмүүсийг ч хайрла гэсэн утгатай байж болох юм. Туслах нь хэчнээн хэцүү байсан ч тэр шүү дээ.

Эмма санаа алдаад харандаагаа алгуурхан доош нь тавив. Тэр Вайолит руу эргэж хараад,

байдгаараа хичээн, сайхан инээмсэглээд, “Би чамд туслах уу?” гэлээ.

Вайолит толгой дохиод нулимсаа гараараа арчив.

Эмма Вайолитын бичгийн ажил руу тонгойж хараад, эхний бодлогоо бодоход нь туслав. Аятайхан дулаан мэдрэмж түүнд төрлөө. Вайолит жигнэмэгэнд дуртай болов уу гэж тэр бодов. ■



ЕСҮСИЙГ ДАГАХ НЬ

Есүс биднээс хүн бүрийг хайрлахыг хүсэн хүлээдэг. Судруудад Есүс бидэнд гэр бүл болон найз нөхдөө хайрлаж, тэдэнтэй эелдэг уриалгахан харьцаж байхыг заасан байдаг. Есүс “Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө сайныг үйлд” (Матай 5:44) гэж заасан билээ. Энэ нь, хүн өөртэй чинь эвгүй харьцдаг байлаа ч гэсэн та түүнд найрсгаар хандаж, найз нөхөр нь байхыг хичээснээр Есүсийг дагаж чадна гэсэн үг юм.



Би Бурханы бүх хүүхдүүдтэй сайн мэдээг хуваалцана

ХУВААЛЦАХ КАРТ

Та танилцуулах картаа хуваалцанаар сайн мэдээг хуваалцаж болно. Картуудыг дараах хуудсан дээр хатуу цаасан дээр цавуугаар наа. Тэгээд картуудаа хайчилж аваад ар тал дээр нь захиасаа бич.

ДУУ БА СУДАР

- “Бид Түүний үнэнийг дэлхийд авчирна,” *Children’s Songbook*, 172–73
- Матай 5:16

ЯРИЛЦАЦГААЯ

Та гэр бүлийн гишүүн бүрээр дуртай жимснийх нь зургийг зуруулж болно. Тэгээд зургийн ар тал дээр хүн бүр амьдралыг нь сайн мэдээ хэрхэн адисалсан тухай бичиж болно. Тэгээд та нар найзууд болон хөршүүдтэйгээ сайн мэдээг хуваалцаж болох арга замуудын тухай хамтдаа ярилц.

Чи бусадтай хуваалцахыг хүсмээр тийм сайхан амттай ямар нэг зүйл идэж үзсэн үү? Бошиглогч Лихай нэг удаа маш сайхан амттай жимс идэж байна гэж зүүдэлсэн билээ. Уг жимс “[түүний] сэтгэлийг үлэмж агуу баяраар дүүргэсэн” (1 Нифай 8:12) сайхан амттай байлаа. Лихай гэр бүлээ тэр сайхан амттай жимснээс идээсэй гэж хүссэн.

Лихайн зүүдэлсэн жимс Тэнгэрлэг Эцэгийн хайртай адилхан юм. Лихай гэр бүлээ Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдрээсэй гэж хүссэн. Лихай сайн мэдээг гэрийнхэнтэйгээ хуваалцахыг хүссэн. Учир нь сайн мэдээ тэднийг аз жаргалтай болгоно гэдгийг тэр мэдэж байлаа.

Хүүхдүүд сайн мэдээг бусадтай хуваалцахдаа ихэвчлэн сайн байдаг.

Найман настай Мария Эквадорын гудамжинд номлогчдыг харжээ. Тэр өөрт нь сайн мэдээг зааж болох уу? гэж номлогчдоос асуусан гэнэ. Тэд Мариягийн гэр бүлд заахаар гэрт нь иржээ. Мария гэр бүлээсээ хамгийн түрүүнд баптисм хүртсэн гэнэ. Эцэстээ гэрийнхэн нь бас бүгдээрээ Сүмд нэгдсэнд тэр их баяртай байв.

Найман настай Эрик Хүүхдийн Хэсгийн ариун ёслолын цуглааны танилцуулгыг хараад сэтгэл нь хөдөлсөн гэнэ. Тэр хөршүүдээ урьсан ажээ. Хөршүүд нь иржээ.

Эдгээр хоёр хүүхэд хайрладаг хүмүүстэйгээ ямар нэг чухал зүйлийн тухай хуваалцжээ. Сайн мэдээг хуваалцахад гэрчлэл чинь өсөн нэмэгдэх болно. Чи Лихайтай адил “үлэмж агуу баярыг” мэдрэх болно. ■

“Бүү ай!
Учир нь Би чамтай
хамт байна.”

Эхлэл 26:24



“Амар тайвныг
тогтоогч хүмүүс
ерөөлтэй еэ!”

Матай 5:9



“Бурхан та нарыг
Христ дотор
уучилсны адил бие
биенээ уучлан, нэг
нэгнээ энэрэн уян
зөөлөн сэтгэлээр
ханд.”

Ефес 4:32



“Бүх зүйлд
талархлаа
илэрхийл.”

1 Тесалоник 5:18



The Statue of Liberty is shown in the background on the left side of the page, holding a torch aloft.

НЬЮ-Йорк ХОТЫН Камилл

Есөн настай Камилл олон найзтай. “Миний найз нар өөр өөр найзуудтай байдагтаа үнэхээр дуртай байдаг” гэж тэр хэллээ. “Тэд өөр өөр газрынх бас юм хийхдээ өөр өөрөөр хийдэг.”

Камилл найз нараасаа сайн зүйлсийг сурах дуртай бас тэдэнтэй өөрт байгаа зүйлүүдээ хуваалцах дуртай. Найз нартайгаа түүний хуваалцдаг хамгийн сайхан зүйл бол сайн мэдээ юм. Камилл итгэлийн нэг

дэх тунхагийг найз Яйлинтай хуваалцсаныхаа дараа найзынхаа гэр бүлийг номлогчидтой уулзахыг урьжээ. Камилл Яйлинд бас яаж залбирахыг заасан гэнэ. Одоо Яйлин ээжтэйгээ хамт сүмийн гишүүн болоод байна.

“Би Бурханы хүүхэд”, “Гэр бүлүүд үүрд хамт байж чадна” дуунууд бол миний дуртай дууллауд. Сургаал ба Гэрээ 19:23 бол миний дуртай судар. Энэ сударт: “Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун; Миний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхагтун, мөн надаар дамжин амар амгалан чамд байх болно” гэсэн байдаг. Энэ судар намайг уйтгарлах үед үргэлж урам зориг өгдөг.

Миний найз Яйлин 2011 онд баптисм хүртсэн. Бид сүмд хамт явахдаа баяртай байдаг. Би түүнд итгэлийн тунхгуудыг цээжлэхэд нь тусалж байна. Одоо бид хоёр итгэлийн ес дэх тунхаг дээр ажиллаж байгаа.



Манай аав, ээж хоёр Бүгд Найрамдах Доминикан Улсын хүмүүс. Тийм учраас цагаан будаа, вандуй, тахианы мах миний дуртай хоол байдаг биз. Энэ нь манай гэр бүл ямар орны хүмүүс болохыг надад сануулдаг.



Манайх тавуулаа. Миний эгч Эмили арван-хоёрдугаар сард баптисм хүртэж, гишүүнээр батлагдах гэж байгаа. Миний ах Виктор аавтай адилхан нэртэй. Надад одоохондоо ямар ч тэжээвэр амьтан байхгүй. Гэхдээ би яст мэлхийтэй болно гэж бодож байгаа. Яст мэлхий эгдүүтэй бас удаан болохоор зугтаагаад явчихгүй учраас би түүнд дуртай.



Би Мормоны Номон дахь Ахмад Моронайн түүхэнд дуртай. Аав энэ түүхийг бидэнд гэр бүлийн үдшээр уншиж өгдөг байсан нь надад өөрийн тугтай болоход сүнслэгээр нөлөөлсөн юм. Миний туг надад би хэн билээ гэдгийг, Тэнгэрлэг Эцэг надтай үргэлж хамт байдгийг сануулдаг.

БИДНИЙ ХУУДАС



Манай аав, ээж хоёр надад сайн мэдээг заасан. Мөн намайг бүр бага байхаас эхлэн аав, ээж хоёр надад үргэлж сайн үлгэр дууриал үзүүлсээр байгаа билээ. Би хүүхдүүдэд зориулсан судрын түүхүүдийг уншиж сурсан болохоор Мормоны Номонд дуртай болсон. Би Мормоны Номыг ганцаараа бас гэрийнхэнтэйгээ өдөр бүр уншдаг. Аммон бол Мормоны Номон дахь миний дуртай баатар. Тэр бол агуу номлогч байлаа. Би том болохоороо түүн шиг болохыг хүсдэг.

Эстэбан М., нас 8, Колумб




Манай гэр бүл ээжийн эх орон Панамд амралтаараа байх үед аав, ээж хоёр миний дүү Еоалибэт бид хоёрыг авч Панамын Ариун сүм рүү явсан. Манай ээж бидний гарыг ариун сүмийн хананд хүргүүлэхээр биднийг дагуулж очсон юм. Хожим нь, бид ариун сүмд байхдаа маш баяртай байснаа ээждээ хэлэхэд тэр надад миний мэдэрсэн тэр зүйл бол Ариун Сүнс байсныг хэлсэн юм.

Сергио Б., нас 7, Флорида, АНУ



Паша З., нас 9, Украин



6 настай К.Летиция -г 3-тай байхад Бразилын Куритиба ариун сүм баригдаж дуусчээ. Тэр ариун сүм рүү очих дуртай байсан бөгөөд нээлттэй хаалганы сүүлчийн долоо хоногт өдөр бүр ариун сүм рүү очдог байжээ. Тэр ариун сүм дээр очиж, үзэсгэлэнт цэцэрлэгүүдээр зугаалах дуртай хэвээр байгаа ажээ. Летиция бас зураг зурж, усанд сэлэх дуртай.



**ХҮҮХДИЙН ХЭСЭГ:
ЕСҮСИЙГ ДАГА**

Италийн 11 настай Мауризио Д. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай ихийг сурч мэддэг учраас ариун ёслолын цуглаанд дуртай ажээ. Сүм хөгжилтэй, сонирхолтой бас гоё учраас тэр сүмд явах дуртай. Мауризио Сүм дээр баяртай байдаг бөгөөд олон найзтай.



Бид Мексикийн Тихуана Ариун сүмийн газрыг хөндөхөд бэлтгэж байх үед их баяртай байсан. Бид гэр бүлээрээ үйлчлэл хийхээр явсан. Бид ариун сүмийн газрыг цэвэрлэсэн. Их Эзэний өргөө баригдаж дуусахад Тэрээр өргөөндөө ирнэ гэдгийг би мэднэ.

Есүс С., нас 6, Мексик



Bảng Khắc
Bảng Vàng


Судруудыг судлах нь зөвийг сонгоход надад тусалдаг.

"Алтан ялтсууд," П. Туэт Ноа, нас 10, Камбож



Би Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг дагасан үед зөвийг сонгодог.

Н. Тай Линда, нас 8, Камбож



Мормоны Номон дахь миний дуртай хэсэг бол Нифайн түүх болон далайг гаталсан тэдний аялал юм.

Кэлли К., нас 10, Филиппин



Бид гэр бүлээрээ үүрд хамт амьдрахын тулд ариун сүмд лацдан холбуулах хэрэгтэй.

Шанна К., нас 8, Филиппин



Би гэрийнхэнтэйгээ хамт сүмд явж, Есүс Христийн тухай сурч мэдэх дуртай. Би гэртээ судрын түүхүүдийг уншиж, тогтоон, дуолууд дуулж, гэр бүлийн үдшийн үеэр тоглоом тоглох дуртай. Сайн мэдээ манай гэрийнхнийг адисалж, намайг аз жаргалтай болгосон юм. Би Мормоны Номыг сургуулийнхаа гурван багшид бас хамгийн сайн найз Мигелдээ өгсөн. Миний дуртай Хүүхдийн хэсгийн дуу бол "Бид дэлхийд Түүний үнэнийг авчирна" дуулал юм (*Children's Songbook*, 172).

Мартим П., нас 6, Португал



Хэнрик С., нас 7, Бразил


Есүс нифайчуудын хүүхдүүдийг адисалсан нь

Жан Пинбороу

Сүмийн сэтгүүлүүд

Олон хүмүүс Есүсийг тойрон
бүчжээ. Тэрээр түүхүүд
ярихыг тэд сонсохыг хүсчээ.
Тэнгэрийн тухай заахыг тэд
Түүнээс хүсч байлаа.





Хүмүүс өвчлөхөд Есүс тэднийг эдгээж байв. Тэр хараагүй хүмүүсийг бас дүлий хүмүүсийг эдгээжээ.



Нэг өдөр хэдэн хүн бага насны хүүхдүүдээ Есүст үзүүлэхээр авчрав. Тэд хүүхдүүдээ адислал өгөхийг Түүнээс хүсчээ. Есүст төвөг удахгүй байхыг шавь нар нь хүмүүсээс хүсэв. Есүс огт завгүй байдаг гэж тэд боджээ.

Харин Есүс тийм
их завгүй биш байв.
Тэрээр хүүхдүүдийг
Өөр рүүгээ ирүүл
гэж шавь нартаа
хэлэв. Тэнгэрийн
хаант улс бол
бяцхан хүүхдүүд
шиг хүмүүсийнх
юм гэж Тэр хэлжээ.



Есүс бүх хүүхдүүдэд хайртай. Чи хэн бэ? гэдэг нь эсвэл ямархуу төрх байдалтай, хаана амьдардаг нь хамаагүй юм. Есүс та нарт хайртай! ■

Марк 10:13–16-аас.



Есүс нифайчуудын хүүхдүүдийг адисалсан нь
 “Есүс хүүхдүүдийг тэвэрч, тэдэн дээр мутраа тавиад ерөөв” (Марк 10:16).

БИ ХАРААЛЫН ҮГ ХЭЛДЭГ БОЛСОН БАЙВ . . .



Р.Вал Жонсон

Сүмийн сэтгүүлүүд

Ээжийн нүүрэнд мэл гайхаж, цочирдсон, урам хугарсан харц илэрсэнд би гунигтай байлаа. Энэ бүхэн ээжийн харцанд дараа дараалан илэрснээ, итгэл эвдсэн урвалт хэмээх сэтгэл хөдлөл болон хувирав.

Миний ээж амьдралын минь 15 жилийн туршид Тэнгэрлэг Эцэгээ үг яриа, үйл хэргээр дээдлэн хүндэлж байхыг заадаг байсныг би үл тоомсорлон, миний амнаас сав л хийвэл бүдүүлэг, олхиогүй үгс гардаг болсны төлөө гэм буруугаа бүр ч их мэдэрч байлаа.

Би уг нь хараалын үг хэллэгийг цээрлэдэг байсан. Тэр жилээс өмнө би хараалын үг хэллэг ерөөсөө хэлдэггүй байв. Гэвч би тэр зун Ютагийн Загас, Шувуу агнуурын газарт ажиллаж байхдаа энэ муу зуршлыг хамт ажиллаж байсан хөвгүүдээс сурсан юм.

Бидний гол ажил бол өргөст үүргэнийг замын хажуугаас хадаж зайлуулах явдал байв. *Өргөст үүргэнэ* бол онцгой хортой хогийн ургамал болохыг бид тэр даруй ойлгосон. Өргөст үүргэнэ газар сайгүй их хэмжээгээр ургадаг бөгөөд бусад ургамлуудыг боомилон устгадгаас гадна ойртсон юм бүхэнд өргөсөөрөө наалдан шигдээд салдаггүй.

Бид гартаа хүрз барин, энэ хортой ургамлын эсрэг зунжингаа, бүр ядарч туйлдталаа тулалдахдаа хараалын үг хэллэгт ялгүй суралцсан юм. Хамт ажиллагсдын үг яриа надад эхлээд эвгүй сонсогддог байв. Дараа нь би хараалын үг хэллэгийг хүлцэн тэвчдэг болсноо, эцэст нь, өөрөө үүнийг хэлдэг болсон билээ. Тэр зуны төгсгөлөөр үүргэнэ нохойн үсэнд шигдээд салдаггүй шиг хараалын үг хэллэг миний ярианд бүр шингэчихсэн байлаа.

*Үүргэнэ нохойн
үсэнд шигдээд
салдаггүй шиг
хараалын үг
хэллэг миний
хэл ярианд бүр
шингэчихсэн
байлаа.*

Гэвч намайг хараал хэлэхэд ээжийн минь үзүүлсэн хариу үйлдэл намайг өөрчлөгдөх хэрэгтэй байгааг надад итгүүлсэн юм.

Ийнхүү өөрчлөгдөх нь амар байгаагүй. Хараалын үг хэллэг бол зөвхөн үгсийн сонголт биш, энэ бол бас сэтгэлгээний загвар юм. Амьдралдаа бидний сонсдог хэл яриа, уншдаг үгс, үздэг дүрслэлүүд бидний бодол санаанд нөлөөлдөг. Хэрэв би үг яриандаа хэрэглэдэг үгсийг өөрчлөхийг хүсвэл оюун ухаандаа урьдаг зүйлсийг өөрчлөх хэрэгтэй гэдгийг удалгүй ойлгосон.

Аз болоход, би сүмд болон семинарт идэвхтэй явдаг байлаа. Хараалын үг хэллэг бидний сайн бодол санааг шахан зайлуулдаг. Харин, хэрэв би сайн бодол санаатай орчинд байх юм бол энэхүү бодол санаа дахин давамгайлах болно. Би өдөр бүр судар судалж, залбирахад анхаарлаа төвлөрүүлээ. Зохисгүй бодол санааг өөгшүүлсэн кино, телевизийн хөтөлбөрүүдийг үздэггүй болсон.

Би хэл яриагаа аажмаар сайжирч байгааг мэдэрсэн. Тэр жилийн эцэс гэхэд би хараалын үг хэлдэг муу зуршлаасаа ангижирсан байлаа.

Би энэ туршлагаас үгийн хүчний тухай олон зүйлийг мэдсэн. Үг бүтээн байгуулж чадна эсвэл устгаж чадна. Үг хүнийг гомдоож болно эсвэл эдгээж болно. Үг хүмүүсийг гутааж чадна эсвэл тэдэнд хайр энэрэл, итгэл найдварын үрийг суулгаж чадна.

Тэнгэр, газрыг Бүтээгч Аврагчийг Үг хэмээн нэрлэсэн нь надад сонирхолтой санагдах (Иохан 1:1–4; С ба Г 93:6–11-ийг үзнэ үү).

Свеаринг (андгай тангараг, хараалын үг) гэдэг нь эерэг болон сөрөг утгатай гэдгийг би ойлгосон. Бид шүүхэд үнэнийг хэлэхээр андгайлдаг. Бид баптисм хүртсэн үедээ Бурханы зарлигуудыг сахихаар хүндэтгэлтэйгээр амладаг эсвээс андгай тангараг өгдөг. Бид үүн лүгээ адил Тэнгэрлэг Эцэгийн адислалуудаас хамгийн агуут нь хүлээн авахын тулд ариун сүмийн гэрээнүүдээ сахихаар ариун амлалтуудыг өгдөг.

Эцсийн дүгнэлт нь: Бидний үгс Түүнийг дээдлэн хүндэлж, Түүний алдар сууг илэрхийлдэг байвал бид Үгтэй улам адилхан болж чадна. ■



ДЭВИД О.МАККЭЙ

Дэвид О.Маккэй Ютагийн Хантсвиллд гэр бүлийнхээ ферм дээр өссөн ажээ. Тэр мал, амьтдад хайртай байсан бөгөөд насан туршдаа **адуу** малласан. Тэр Их Британид үйлчилж байхдаа “Чи хэн ч байлаа гэсэн, үүрэгт ажлаа сайн хий” гэсэн **зүйр үгийг** сурч, уриагаа болгосон ажээ. Тэр Их Британид олон удаа эргэж ирсэн ба 1958 онд **Английн Лондонгийн Ариун сүмийг** адисалжээ.



“Бид эцэг эх, удирдагчдын хувьд өсвөр үеийнхэнд хэдхэн сар үргэлжлэх бүрэн цагийн номлолын үйлчлэлд бэлтгэхэд нь туслаад зогсохгүй үүрд мөнх үргэлжлэх ариун сүмийн гэрээнүүдийг хийж, сахихад нь тэдэнд туслах хэрэгтэй байна. Анхны алхмудыг тэдний бага наснаас нь эхлэх хэрэгтэй.” “Өсвөр насныхан ба ариун сүмийн гэрээнүүд”-ийг үзнэ үү, х.18. Энэ мөн бусад өгүүлүүд нь настай, залуу бүх гишүүдэд сайн мэдээг хуваалцаж үүний дагуу амьдрахад илүү сайн бэлтгэхэд нь тусалж чадна.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ